



ШҮҮХИЙН АКАДЕМИ

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО

ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО

ГАРЫН АВЛАГА

Энэхүү гарын авлагыг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн
Шүүхийн судалгааны төвөөс бэлтгэн гаргав.

Эх бэлтгэсэн: Сэлэнгэпресс ХХК

Цаасны хэмжээ: 210x148

Хэвлэлийн хуудас: 12х.х

© Шүүхийн академи, 2024.

Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан тул энэхүү бүтээлийг зөвшөөрөлгүй хэвлэх,
нийтлэх, олшруулах, хуулбарлахыг хориглоно.



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ОРШИЛ	5
НЭГ. ЭХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН БҮЛД ХАМААРАХ УЛСУУД	17
I. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	17
II. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	19
III. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	34
IV. ЯПОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	39
V. ЭСТОНИ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	42
VI. АВСТРИ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	45
ХОЁР. АНГЛО-САКСОНЫ ЭРХ ЗҮЙН БҮЛД ХАМААРАХ УЛСУУД	48
I. АВСТРАЛИ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	48
II. ШИНЭ ЗЕЛАНД УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	50
III. ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	53
IV. КАНАД УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	55
V. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	57
VI. СИНГАПУР УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	60
ГУРАВ. СОЦИАЛИСТ ЭРХ ЗҮЙН БҮЛ БОЛОН ПОСТ СОЦИАЛИСТ ОРНЫ ТӨЛӨӨЛӨЛ	63
I. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	63
II. ОХУ-ЫН ЗОХИЦУУЛАЛТ	73
III. БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	78
IV. БҮГД НАЙРАМДАХ УЗБЕКИСТАН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	83
НОМ ЗҮЙ	88



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Шүүхийн академи	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
ШБЗБтХ	Шүүхийн бүтэц, зохион байгуулалтын тухай хууль
АИХ	Ардын Их Хурал
БНАСАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс
БХАГИХ	Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс



ОРШИЛ

Энэхүү гарын авлага нь дэлхийн зарим орны шүүхийн тогтолцоо, тухайн шүүхүүдийн харьяалан шийдвэрлэх хэрэг, маргааныг танилцуулсан бүтээл юм.

Судалгааны багийн зүгээс эх газрын эрх зүйн бүлд хамаарах Франц, ХБНГУ, БНСУ, Япон, Эстони, Австри улсуудын; жишгийн эрх зүйн бүлд хамаарах Австрали, ИБУИНХУ, АНУ, Шинэ Зеланд, Канад, Сингапур улсуудын; Социалист эрх зүйн бүлд хамаарах БНХАУ, пост социалист орнуудын төлөөлөл болох ОХУ, Польш, Социалист эрх зүйн бүлд хамаарах БНХАУ, ОХУ-ын; пост социалист орнуудын төлөөлөл болох Польш, Узбекистан улсуудын шүүхийн тогтолцооны эрх зүйн зохицуулалтыг судалсан болно.

Эрх зүйн бүл нь харьцуулсан эрх зүй судлалын үндсэн гол ухагдахууны нэг хийгээд эрх зүйн эх сурвалж, эрх зүйн үндсэн ухагдахуун, эрх зүйн бүтэц ба тэдгээрийн бүрэлдэн тогтсон түүхэн замналын нийтлэг байдлыг нэгтгэсэн эрх зүйн үндэсний тогтолцооны нийлбэр цогц юм. Мөн эрх зүйн бүл гэдэг нь эрх зүйн тогтолцооны үүсэл гарал, эрх зүйн эх сурвалж, институт, эрх зүйг хэрэглэх, хэрэгжүүлэх ажиллагаа болон шинжлэх ухааны үндсэн ухагдахуун, салбар эрх зүй зэрэг элементүүдээрээ ижил төсөөтэй үндэсний эрх зүйн тогтолцоонуудын уялдаа холбоо юм.¹

Дэлхий нийтэд өргөн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн тогтолцооны 1) Англо-Саксон, 2) Эх газар, 3) шашны, 4) социалист гэсэн 4 бүлд улсууд хуваагдаж байна.

Эх газрын эрх зүйн бүл² нь Ромын эзэнт гүрний үеэс улбаатай бөгөөд тухайн үед хаан ширээнд сууж байсан Юстиниан хаан өөрийн нэрээр мөнхөлсөн “Юстиниан кодекс” хэмээх нэртэй хуулийн эмхэтгэлийг хийлгэснээр эх газрын эрх зүйн тогтолцооны үндэс тавигдсан билээ.³ Улмаар 1789 онд Францын их хувьсгал, түүний дараа 1799 оноос

¹ Ч.Батцэцэг, Монгол Улсад эрх зүйг эзэлдэн нутагшуулах арга ажиллагаа, сургамж дүгнэлт, 2013, 32 дахь тал

² Нэр томъёоны хувьд: “Civil law-Эх газрын эрх зүйн уламжлал”, “Romano Germanic law-Ром Германий эрх зүйн бүл”, “Continental legal system-Эх газрын эрх зүйн бүл” гэх зэргээр нэрлэгдэн, орчуулагдсан байдаг ба энэхүү бүтээлд “Эх газрын эрх зүйн бүл” хэмээх нэршлийг ашигласан болно.

³ JOSEPH DAINOW, “The Civil Law and the Common Law: Some Points of Comparison,” American Journal of Comparative Law 15, no3 (1967), 420.



Наполеоны гардаж хийсэн эрх зүйн эрс шинэчлэл, реформын үр дүнд хууль тогтоомжуудыг төрөлжүүлж гаргах үйл явц эхэлж, Наполеоны байлдан дагуулалт болон европын орнуудын колоничлолын бодлогоос улбаалан эх газрын эрх зүйн тогтолцоо дэлхийн бусад хэсэгт нутагших болсон түүхтэй⁴ бөгөөд эх газрын эрх зүйн бүл нь өрнөдийн сонгодог эрх зүйн нэлээд өргөн тархсан систем юм.

Энэхүү бүлд хамаарах улсуудын эрх зүйн тогтолцооны онцлог шинжийн хувьд авч үзвэл тус бүлийн эх сурвалж нь төрөлжсөн хуулиуд байдгаас үүдэн шүүх нь эрх зүйг бүтээхгүй харин эрх зүйг хэрэглэх, тайлбарлах эрх хэмжээтэй байдаг бөгөөд эрх зүй нь тодорхой салбарууд, тодорхой төрлүүдээр ангилагдаж системчлэгдсэн байдаг онцлогтой байна. Тухайлбал, эрх зүйн тогтолцоог нийтийн болон хувийн гэж ангилжээ. Ийнхүү ангилах явдал нь эх газрын эрх зүйн бүлд хамаарах бүх орнуудад нийтлэг зүйл болж төлөвшсөн бөгөөд нийтийн болон хувийн эрх ашгийг хооронд нь адилтгах буюу харьцуулах боломжгүй, тэдгээрийг зааглан ойлгох шаардлагатай гэж үзэх хандлага түгээмэл дэлгэрсэнтэй холбоотой юм.⁵

Ромын эрх зүйн уламжлал дээр тулгуурласан 1804 оны Францын Иргэний хууль, 1896 оны Германы Иргэний хуулиуд нь орчин үеийн эх газрын эрх зүйн хөгжилд чухал нөлөөг бий болгосон⁶ буюу эх газрын эрх зүйн тогтолцоо нь түүхэн гарал, хөгжлийн өрнөл, зүй тогтлоороо Франц болон Герман улсын эрх зүйн системд суурилан хөгжсөн тул Францын болон Германы гэсэн дэд ангилалд авч үздэг.⁷ Дээрх хуулиуд нь нэг үзэл санаан дээр тулгуурлан хөгжиж эхэлсэн боловч бий болох үеийн түүхэн нөхцөл байдал, эрх зүйн уламжлал, зан заншил зэргээс шалтгаалан эрс ялгаатай тул эх газрын эрх зүйн тогтолцооны 2 дэд ангилал болон хөгжжээ.

Түүхэн цаг үе, улс төрийн нөхцөл байдалтай холбоотойгоор Герман болон Францын эрх зүйн бүл шударга ёсыг хэрэгжүүлэх, хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн харилцааг зохицуулах үүднээс хууль тогтоомжийг системчлэн нэгтгэх замаар нийгмийн дэг журам, зохицлыг бий болгох нийтлэг шинж чанартай байсан. Өөрөөр хэлбэл,

⁴ Д.Баярсайхан, *Эрх зүйн онол* (5 дахь хэвлэл), 2018, 94 дахь тал.

⁵ Д.Баярсайхан, *Өмнөх эшлэл 4*, 114-115 дахь тал.

⁶ Mary ann Glendon, Paolo G.Carozza, Colin B.Picker, *Comparative legal traditions*, 3rd ed, 2007, 60,

⁷ Д.Баярсайхан, *Эрх зүйн онол*, 2018, 93 дахь тал.



системчлэгдсэн хууль нь тус тусын нийгэмд иргэний эрх, үүргийг тодорхойлж, ойлгомжтой, нийтлэг, хүртээмжтэй журмаар нийгмийг хангах хэрэгсэл болдог.⁸ Гэхдээ Франц, Герман нь эх газрын эрх зүйн бүл дэх бусад улс орнуудтай харьцуулахад бие биеийнхээ хууль, эрх зүйн нөлөөнд бага өртсөн гэж үздэг⁹ бөгөөд хууль тогтоомжийг системчлэх үйл явцад эрх зүйн уламжлал, түүхэн нөхцөл байдал нөлөөлж тухайн эрх зүйн бүлд хэд хэдэн ялгаатай шинж¹⁰ бий болсон байна.¹¹

Франц болон Германы загвар нь шүүгчдийн гүйцэтгэх үүргийн талаарх ойлголтоороо ялгаатай байдаг. Тодруулбал, Францын шүүгч хуулийг хэрэглэхгүй байх эрх чөлөөтэй гэж үздэг бол Германд шүүгч шийдвэр гаргахдаа хуулийн эх бичвэрийг хатуу дагаж мөрдөх үүрэгтэй байдаг. Тиймээс Германы шүүгчдийн хууль тайлбарлах эрх мэдэл нь Францын шүүгчтэй харьцуулахад хязгаарлагдмал байдаг байна.

Дээрхээс үзвэл Герман болон Франц улс нь хууль тогтоомжийг системчлэн нэгтгэх зорилгоороо ижил байсан хэдий ч тус тусын эрх зүйн тогтолцооны анх үүссэн уламжлал, түүх, зан заншил нь ялгаатай байсны улмаас хууль тогтоомжуудаа нэгтгэн системчлэх явцдаа хоорондоо ондоожжээ. Тус хоёр улс нь аль нэг улсынхаа хууль, эрх зүйн нөлөөнд барагтаа өртөж байгаагүй гэхэд хилсдэхгүй.¹²

МЭ-ий XI зуунаас XIX зууныг хүртэл Английн¹³ тэлэлт, улс төр, эрх зүйн шинэчлэл нь **Англо-Саксоны эрх зүйн бүл** хэмээх өвөрмөц эрх зүйн тогтолцоо бүрэлдэн бий болох суурийг тавьжээ. 1066 оны Нормандын булаан эзлэлтийн дараах эрх мэдлийн төвлөрлөөс үүдэлтэй засаглалын хэв маяг нь хаан болон түүний томилсон шүүгчдийн тогтоосон бичмэл бус

⁸ Sofia Stefanelli, *A Comparative Study Of The German And French Paths To Codification Of Private Law*, 2023, 16.

⁹ *Supra* note 8, 616.

¹⁰ Францын болон Германы системчилсэн хуулийн бүтэц, хэв маяг нь ихээхэн ялгаатай. Тухайлбал, Францын эрх зүйн бүлд хууль тогтоогч хууль хэрэглэгдэх нийгмийн бүх харилцааг урьдчилан тодорхойлох боломжгүй гэж үзэн, нарийвчилсан заалт гэхээсээ илүү ерөнхий зарчмыг хуульчлах замаар илүү уян хатан байдлыг сонгосноор, хуулийн нэр томьёо, ерөнхий бүтэц нь ойлгомжтой байдаг онцлогтой бол Германы системчилсэн хууль нь үгсийн сангийн нарийн сонголт, эрх зүйн үзэл баримтлалын шинээр нэвтэрсэн нэр томьёо зэрэг нарийвчлалаараа онцлог юм.

¹¹ *Supra* note 8, 225.

¹² Sofia Stefanelli, *A Comparative Study Of The German And French Paths To Codification Of Private Law*, 2023, 16.

¹³ XI зууны үед Англи нь өнөөгийн Уэльс, Скотланд, Ирландтай нэгдээгүй байсан. Харин Нормандын эзлэлтийн дараах 700 орчим жилийн туршид газар нутгийн тэлэлт, ялалт, улс төрийн нэгдлийн үндсэн дээр өнөөгийн Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хант Улсын бүрэлдэхүүн бий болжээ. Иймд Англо-Саксоны эрх зүйн бүлийн үүслийг Английн эрх зүйн тогтолцооны хөгжилтэй холбон үзэж тайлбарладаг.



хэм хэмжээг хууль хэмээн үзэж эхэлснээр язгууртны гэж болох эрх зүйн засаглал Англи болон хожим түүний колоничлолд байсан хөрш орнуудад тогтсон ба энэ нь шүүхийн жишгийг эрх зүйн гол эх сурвалжид тооцох онцлог тогтолцоог бий болгосон байна.

Нормандын эзлэн түрэмгийллээс өмнөх үед Английн нутаг дэвсгэрт ерөнхийдөө нэгдмэл эрх зүйн тогтолцоогүй олон тооны аймгууд засаглаж, бичмэл бус заншлын хэм хэмжээнүүдийг түлхүү хэрэглэгддэг байжээ. Энэ үед феодалын систем тогтож эхэлсэн бөгөөд газрын эзэд түрээслэгч болон тосгоны иргэдийн хувьд шударга ёсыг тогтоох, тэднийг хамгаалах эрх, үүргийг эдэлж, цуглуулсан татвараараа аюулгүй байдлаа сахиулдаг байв.¹⁴ Харин үүнээс хойш эзлэн түрэмгийллийн дараа Уиллям (*William*) хаан Английн газрыг тэдгээр уугуул газрын эздээс хураан авч өөрийн итгэлт дагагчдад (англ. *Trustworthy followers*) хуваан өгч захируулан өөртөө дээд эрх мэдлийг олж авчээ. Улмаар төрийн дээд хэргийг Вестминстер (*Westminster*) төвлөрүүлэн захирч байв. Хааны засаглал дор төрийн эрх мэдэл хуваарилагдаагүй байсан бөгөөд түүний ойрын зөвлөхүүдийг багтаасан the Curia Legis хэмээх бие даасан бүтцийг байгуулж, энэ нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байсан.

Шүүхийн тогтолцооны хувьд орон нутгийн шүүхүүд, шүүхтэй төстэй байгууллагууд заншлын хэм хэмжээг баримтлан хэрэг маргааныг хянан шийдвэрлэж байсан боловч “бэлгэдлийн хувьд хаан шударга ёсыг тогтоогч хэмээгдэж”¹⁵, улс орны аюулгүй байдалтай холбоотой маргаануудыг хянан шийдвэрлэдэг “Хааны шүүх”-ийг байгуулсан байдаг. Хааны шүүхийн хэргийн харьяаллыг үндсэн гурван хэсэгт хувааж үзнэ. Нэгдүгээрт, хааны санхүү тухайлбал, албат ноёд нь хаанд төлөх газрын төлбөртэй холбогдсон аливаа маргааныг шийдвэрлэх Татварын буюу Санхүүгийн шүүх (англ. *Court of Exchequer*), хоёрдугаарт, аливаа өмч болон хааны өмчлөлд албан ёсоор байдаг газрыг эзэмшихтэй холбогдсон асуудлыг харьяалах Коммон плеэ шүүх (англ. *Court of Common Pleas*), гуравдугаарт хаант улсын амгалан тайван байдалд харшилсан ноцтой эрүүгийн хэргийг харьяалан шийдвэрлэх Кингс Бенч (англ. *Court of King's Bench*) зэрэг шүүхүүдэд тус бүр хэрэг хянан шийдвэрлэнэ.¹⁶

¹⁴ Mary Ann Glendon, Paolo G. Carozza and Colin B. Picker, *Comparative Legal Tradition*, 3rd ed. (Thomson West, 2007), 307.

¹⁵ Б.Амарсанаа, *Харьцуулсан эрх зүй судлал*, 2014, 57 дахь тал.

¹⁶ Өмнөх эшлэл 15.



Цаг хугацааны явцад хаант засаглалын эрх мэдэл улам бүр тэлж 1215 онд Магна Харт батлагдсанаар орон нутгийн шүүхүүд хавчигдан үгүй болж хааны шүүхийн эрх хэмжээ нэмэгдэж ирсэн төдийгүй шашны эрх зүйн нөлөөлөл ихэсжээ. Ecclesiastical Courts буюу шашны шүүх нь шашны хэм хэмжээнд тулгуурлан шийдвэрлэх боломжтой гэр бүлийн болон бусад маргаануудыг шийдвэрлэх болсон байна.¹⁷

Энэ бүх явцад хааны эрх мэдлийн нөлөөлөл түүний байгуулсан институциудад хүчтэй байсан учир бичмэл хуулийг батлаагүй байна. Хожим XIV-XV зууны орчимд парламентыг тусгаарлан байгуулсны дараа ч энэ байдал хэвээр хадгалагджээ. Үүнийг дараах шалтгаануудтай холбон тайлбарласан байна.¹⁸

Нэгдүгээрт, эх газрын эрх зүйн бүлийн хууль тогтоогчоос ялгаатай нь шүүгчийн байр суурийг эзлэхийг оролдож байсны хувьд Английн хууль тогтоогч нь ерөнхий, номлолын шинжтэй эрх зүйн хэм хэмжээг тогтоохоос зайлсхийж байсан юм.

Хоёрдугаарт, парламент болон шүүхийн харилцан хамаарал, өрсөлдөөнтэй холбогддог. Анх парламент нь Англид хууль тогтоохдоо шүүгчийн эрх зүй бүтээж байгаа үйл ажиллагааг зогсоохыг зорьж байсан тухай бичсэн байдаг.

Гуравдугаарт, хэдийгээр тухайн үед шүүгчийн тогтоодог эрх зүйн хэм хэмжээтэй адилаар эрх зүйн хэм хэмжээг тогтоохыг парламент оролдож байсан ч парламентын тогтоосон хэм хэмжээг шүүх хэрэглэхгүй бол Английн эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болж чадахааргүй байжээ.

Ийнхүү Английн эрх зүйн гол эх сурвалж нь шүүхийн өмнөх шийдвэрүүд (англ. *Precedent*) болж stare decisis зарчмыг чанд баримталж эхэлжээ. Stare decisis гэдэг нь шүүгч хэрэг маргааныг түүнтэй төсөөтэй тохиолдлыг шийдвэрлэсэн өмнөх шүүхийн шийдвэрт нийцүүлж шийдэхийг хэлнэ.¹⁹ Stare decisis болон жишиг шийдвэрүүдийн цаад үндэслэл нь шүүхийн үр ашигтай байдал, талуудад шударга хандах, урьдчилан таамаглах боломжтой байх, дур зоргоороо шүүхийн шийдвэр

¹⁷ Mary Ann Glendon, Paolo G. Carozza and Colin B. Picker, *Comparative Legal Tradition*, 3rd ed. (Thomson West, 2007), 311.

¹⁸ *Өмнэх эшлэл* 15, 74-75 дахь тал.

¹⁹ Mikaia Mariel Lemonik Arthur, *Law and Justice Around the World: A Comparative Approach*, (University of California Press, 2020), 22.



гаргахыг хянах, тэнцвэржүүлэх явдал юм.²⁰

Дараах гурван шалгуурт нийцсэн нөхцөлд өмнөх шүүхийн шийдвэрийг шүүгч *stare decisis* зарчмын дагуу хэргийг шийдвэрлэхдээ баримтална:²¹

1. Өмнөх шийдвэрийн шийдэл нь шийдвэрлэж буй маргааны гол асуудал буюу *ratio decidendi*-тай агуулгын хувьд ижил байх;
2. Өмнөх шийдвэр нь шүүхийн шатлалын хувьд шийдвэр гаргах гэж буй тухайн шүүхийн дээд шатны шүүхээс гаргасан байх /англ. *hierarchy of courts*/;
3. Өмнөх шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон үйл баримт болон шийдвэрлэх гэж буй хэргийн үйл баримт хоорондоо төсөөтэй байх зэрэг болно.

Эх газрын эрх зүйн нэгдмэл кодекстой харьцуулахад тодорхой орны шүүхээс өмнө гаргасан шийдвэрүүдийг бусад улс орнууд хүлээн авч нутагшуулахад хүндрэлтэй байжээ.²² Иймд жишгийн эрх зүй нь газар нутгийн хувьд зөвхөн Английн хөрш болон колони орнуудын хүрээнд нэвтэрч тогтсон байна. Тухайлбал, Австрали улс Английн нөлөөнд байх үед тус улсын эрх зүйн үндсэн эх сурвалж нь Английн шүүхүүдийн давж заалдах журмаар гаргасан шийдвэрүүд болжээ.²³ Үүнтэй ижил нөхцөл байдал мөн Канад Английн нөлөөнд байх хугацаанд давтагдсан байдаг. Энэ мэтчилэн Америк, Өмнөд Африкийн орнууд, Энэтхэг гэх мэт улсуудад Английн колоничлолын нөлөөгөөр жишгийн эрх зүйн онцлог шинж дамжин тархсан билээ.

Шүүхийн жишиг нь Английн ард түмний дунд угаас байсан жам ёсны дэг журмыг шүүгчээр дамжуулан илрүүлж, хадгалж буй явдал хэмээн үзэж байв.²⁴ Гэсэн хэдий ч олон зууны туршид язгууртан шүүгчдийн бий болгосон жишиг журам нь үнэн хэрэгтээ ард түмний хүсэл зорлгийг илэрхийлж чадах эсэх, парламентаас илүү үүнийг тусгах чадамжтай эсэх нь эргэлзээтэй.²⁵ Иймд XIX дүгээр зууны үед Жереми Бентам болон бусад шүүхийн жишгийн эсрэг байр суурийг баримтлагч эрдэмтдийн нөлөөгөөр парламентаас эрх зүйн зарим харилцааг зохицуулсан хуулиудыг (англ.

²⁰ Jasper Kim, *American Law 101: An Easy Primer on the U.S. Legal System*, (American Bar Association Book Publishing, 2024), 11.

²¹ Uwe Kischel, *Comparative Law*, (Oxford Press, 2019), 238-242.

²² Mary Ann Glendon, Paolo G. Carozza and Colin B. Picker, *Comparative Legal Tradition*, 3rd ed. (Thomson West, 2007), 321.

²³ Ibid, 322.

²⁴ *Supra* note 21, 246.

²⁵ *Supra* note 21, 242.



Statute) баталж эхэлсэн боловч эх газрын эрх зүйн тогтолцоотой адил нэгдмэл кодекс бий болоогүй байна.²⁶ Эдгээр хуулиуд нь шүүхийн жишгээр тогтоогдсон эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тодотгох, эсвэл тухайн улсын бодлого, үнэт зүйлтэй нийцэхгүй гэж үзсэн тохиолдолд өмнө тогтсон шүүхийн жишгийг бүхэлд нь өөрчлөхөд чиглэдэг гэж ойлгож болно.²⁷

Жишгийн эрх зүйн орнуудад парламентаас баталсан эрх зүйн эх сурвалжуудын хүчин чадал нэмэгдсээр байгаа билээ. Тухайлбал, Англо-Саксоны бүлийн орнуудын томоохон төлөөлөл болох АНУ-д шүүхийн жишиг хэргүүдээс гадна үндсэн болон хоёрдогч гэсэн хоёр үндсэн эх сурвалжуудыг хэрэглэдэг байна.²⁸

Дээрх хоёр эрх зүйн бүлтэй харьцуулахад **социалист эрх зүйн бүл** нь харьцангуй шинэ бүл юм. Социалист системийн задрал нь эх газрын эрх зүйн бүл бүхий улсуудад явагдсан бөгөөд Англи-саксоны эрх зүйн бүл бүхий улсуудад явагдаагүй. Өөрөөр хэлбэл, Зөвлөлт холбоот улсын харьяанд байсан улсууд болон 1992 оноос өмнөх Монгол улс, орчин үед Хятад, Вьетнам зэрэг улсуудыг социалист эрх зүйн тогтолцоотой гэж үзэж болох юм. Гэхдээ социалист эрх зүй нь эх газар болон жишгийн эрх зүйн бүлийн адил “бие даасан эрх зүйн бүл” болох эсэх нь нэгдмэл байр сууринд хүрээгүй маргаантай байдаг асуудал юм. Тодруулбал, баруун Европ болон социалист улсуудын судлаачид эх газрын эрх зүйн бүлээс тусдаа “социалист эрх зүйн бүл”-ийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үздэг хандлага (*separationist thesis*) болон үүнийг эсэргүүцдэг онолын хандлага байдаг.²⁹ Харин Монгол Улс дахь эх сурвалжуудад “бие даасан эрх зүй бүл” хэмээн авч үздэг байна.³⁰

Социалист эрх зүйн бүлийг эх газрын эрх зүйн бүлээс тусдаа бие даасан бүл хэмээн авч үзэхдээ социалист эрх зүйн бусад эрх зүйн бүлээс ялгарах онцлог шинжүүдийг үндэслэл болгон дэвшүүлдэг. Социалист эрх зүй нь бусад эрх зүйн бүлээс ялгаатай нь нэг намын засаглал, төвлөрсөн

²⁶ Mary Ann Glendon, Paolo G. Carozza and Colin B. Picker, *Comparative Legal Tradition*, 3rd ed. (Thomson West, 2007), 316.

²⁷ Uwe Kischel, *Comparative Law*, (Oxford Press, 2019), 242.

²⁸ Jasper Kim, *American Law 101: An Easy Primer on the U.S. Legal System*, (American Bar Association Book Publishing, 2024), 13.

²⁹ 五十嵐清『社会主義法系は存在したか? -John Quigley, Socialist Law and the Civil Law Tradition, 37 Am.J.Comp.L.781(1989)の紹介を中心に-』、札幌法学3巻1号(1991)、3頁。

³⁰ С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, 2011, 662 дахь тал.



төлөвлөгөөт эдийн засагтай байна³¹. Мөн эдийн засагт төрийн гүйцэтгэх үүрэг нь хувийн эрх зүйг нийтийн эрх зүйн шинжтэй болгодог онцлог шинжтэй.³² Түүнчлэн хуульд агуулагдаж буй шашны үзэл суртал (pseudo-religious character), хуулиас илүүтэйгээр улс төрийн хэрэгцээ, шаардлагад ач холбогдол өгдөг онцлог шинжүүдтэй.³³ Социалист эрх зүйн бүл дэх шүүх нь эх газрын эрх зүйн бүл дэх шүүхээс илүү өргөн хэмжээний бүрэн эрхийг эдлэх бөгөөд “удирдан чиглүүлэх” чиг үүрэгтэй байдаг³⁴. Дээрх үндэслэлүүдээр социалист эрх зүйг бие даасан эрх зүйн бүл гэж авч үздэг байна.

Социалист эрх зүйн бүлийн улсуудад “социалист хууль ёсны зарчим (социалистическая законность)” үйлчилдэг бөгөөд тус зарчим нь төрийн хууль, түүнд үндэслэж гаргасан эрх зүйн актыг төр, олон нийтийн бүх байгууллага, тэдгээрийн албан хаагчид, нийт ард иргэдээс нэг янзаар ойлгож хэлбэрэлтгүй, нарийн чанд сахин биелүүлж байхад оршино³⁵ гэх зарчим юм. Гэвч социалист нийгэмд ард иргэдийн дагаж, мөрдөх ёстой хууль нь “социалист хууль” байсан бөгөөд хууль, эрх зүйн тогтолцоо нь Монгол Ардын Хувьсгалт Намаас социалист нийгмийг цогцлоон бүтээхэд шаардлагатай “арга хэрэгсэл” байсан юм. Тухайлбал, Стучка П.И болон Вышинский А.Я –ын “хууль (закон)”-н тухайн үзэл нь хүлээн зөвшөөрөгдөж байсан. Стучка нь “хууль” –г *эрх баригч ангийн эрх ашигт нийцсэн, эрх баригч ангийн зохион байгуулагдсан эрх мэдлээр хамгаалагдсан нийгмийн харилцааны тогтоолцоо* гэж тодорхойлсон. Мөн Вышинский нь “*Эрх баригч ангийн хүсэл зоригийг илэрхийлсэн, хууль тогтоох процессын дагуу батлагдсан зан үйлийн дүрэм, мөн түүний хэрэглээ нь эрх баригч ангид ашигтай, таатай байдалаар нийгмийн харилцааг хамгаалах, бэхжүүлэх, хөгжүүлэх зорилгоор төрийн албадлагаар хэрэгждэг, төрийн эрх мэдлийн дагуу хариуцлага тогтоосон ёс заншил, нийтийн аж ахуйн дүрмийн нэгдэл*” гэж “хууль”-г тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, Стучка болон Вышинский нар нь “хууль”-г

³¹ 五十 前掲注 (29) 3頁。Энэхүү үзлийн гол төлөөлөгчдийн гол бүтээл нь David, Les grand systemes de droit contemporains (Droit compare), Paris 1964. Osakwe, Glenton et al., Comparative Legal Traditions in a Nutshell, St.Paul 1982, John N.Hazard, Communists and Their Law; A search for the Common Core of the Legal Systems of the Marxian Socialist States, Chicago&London 1969 бүтээлүүдийг үзнэ үү.

³² 五十 前掲注 (29)、5頁。

³³ 五十 前掲注 (29)、5-9頁。

³⁴ 五十 前掲注 (29)、5-9頁。

³⁵ Б.Чимид, *Бүгд найрамдах монгол ард улсын захиргааны эрх зүй (Ерөнхий анги)*, 1988, 72 дахь тал.



“эрх баригч ангид ашигтай” дүрэм гэж тодорхойлсон бөгөөд “социалист хууль ёсны зарчим”-н дагуу ард иргэдийн мөрдөх ёстой хууль нь “эрх баригч анги”-н хүсэл зоригийг илэрхийлсэн хэм хэмжээ байсан юм. Гэхдээ Стучка болон Вышинский нарын “хууль”-г тодорхойлох үзэл баримтлалыг Пашуканис Е.Б шүүмжилдэг байсан.³⁶ Дээрхээс үзвэл социалист эрх зүйн бүл бүхий улсуудад хуулийг парламентын байгууллагаас батлах боловч тус хуулийн зорилго нь хувь хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалахаас илүүтэйгээр социалист нийгмийн эрх ашгийг дээгүүр тавьж байсан онцлогтой байна.

Социалист эрх зүйн бүл бүхий улсуудад шүүхийн бие даасан байдлын тухай ойлголт байхгүй бөгөөд шүүх эрх мэдэл нь хууль тогтоох байгууллагын хяналтад байдгийг төвөггүй харах боломжтой. Жишээ дурдахад Монгол Улсын 1940 болон 1960 оны хоёр Үндсэн хуульд заасны дагуу дээд шүүх нь АИХ, түүний тэргүүлэгчдэд ажлаа хариуцан тайлагнадаг бөгөөд Үндсэн хууль болон нийтийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагаа шүүхийн хяналтаас гадуур үлдсэн³⁷ шинжтэй байдаг. Мөн шүүх нь бие даасан эрх мэдлийн институт бус гүйцэтгэх эрх мэдэлд харьяалагддаг байсан³⁸.

Дээрхээс гадна социалист улсуудын томоохон төлөөлөл болох Бүгд Найрамдах Хятад Ард улс (цаашид “БНХАУ” гэх)-ын Үндсэн хуулийн 3 дахь хэсэгт зааснаар “*төрийн захиргааны байгууллага, төрийн хяналтын байгууллага, шүүх, прокурорын байгууллагыг “Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал”* (цаашид БХАТИХ)-аас байгуулах бөгөөд БХАТИХ-ийн өмнө ажлаа хариуцаж, БХАТИХ-ийн хяналтын доор ажиллана гэжээ. Хятадын Үндсэн хуулийн 131 дүгээр зүйлд “*Ардын шүүх нь хуульд заасны дагуу бие даан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж, захиргааны байгууллага, олон нийгмийн бүлэг болон хувь хүний нөлөөнөөс хараат бус байна*” гэж заасан байдаг бөгөөд энэ заалт нь тунхаглалын шинжтэй. Бодит байдал дээр Хятадын шүүх нь Хятадын Коммунист Намаас хамааралтай бөгөөд намын улс төр, эрх зүйн хорооны шууд удирдлага дор ардын шүүх болон прокурорын байгууллага ажилладаг. Шүүх болон прокуророос “чухал болон эмзэг” хэргүүдийг шийдвэрлэхдээ

³⁶ Б.Дөлгөөн, *Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны эрх зүй: онол, хэрэглээ, тулгамдсан асуудал*, 2023, Эшлэл 4.

³⁷ Б.Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал*, 2017, 125 дахь тал.

³⁸ БНМАУ-ын 1924 оны Үндсэн хуулийн 27 дугаар зүйл, 1940 оны Үндсэн хуулийн 33 дугаар зүйл.



тухайн шатны намын эрх зүйн хороонд тайлагнаж, баталгаа авдаг. Мөн ардын шүүхийн байгууллага нь захиргааны байгууллагатай төстэй, тушаал дагах, босоо удирдлагын зарчимд үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд намын шийдвэрийн дагуу хэргийг хянан шийдвэрлэдэг байна.³⁹

Өөрөөр хэлбэл социалист эрх зүйн бүлтэй улс орнууд нь төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг хүлээн зөвшөөрдөггүй ба шүүхийн тогтолцоонд намын оролцоо өндөр байдаг. Шүүх эрх мэдлийг ангийн тэмцлийг зогсоох зэвсэг гэж үздэг ба хууль тогтоох байгууллагаас шүүх, прокурор, цагдаагийн байгууллагад тавьж буй хяналтаар илэрдэг байна.

Дээрхээс үзвэл эх газар, жишиг, социалист эрх зүйн бүлүүд нь харилцан уялдаа болон ижил төсөөтэй шинжүүдтэйгээс гадна, ялгаа бүхий шинжийг агуулдаг байна. Тухайлбал, эх газрын эрх зүйн бүл нь Англо-Саксоны эрх зүйн бүлээс хэрхэн ялгардаг талаар харьцуулалтын үүднээс товч авч үзвэл, хууль тогтоомж болоод шүүхийн шийдвэр аль аль бүлд байх хэдий ч тэдгээрийн ач холбогдолтой байдал нь гол ялгаа болдог. Мөн эх газрын эрх зүйн бүлийн хувьд эрдэмтэн, судлаачдын дэвшүүлж буй онолын ойлголтууд нь эрх зүйн хөгжилд томоохон нөлөө үзүүлэх хүчин зүйлийн нэгд тооцогддог ба эрх зүйн боловсрол олгоход тухайн онолын ойлголтуудыг хийсвэрлэх зарчмын үүднээс ашигладаг бол Англо-Саксоны эрх зүйн бүлийн хувьд илүүтэй тодорхой тохиолдол шийдвэрлэхэд тулгуурласан байдаг ажээ. Үүнтэй адилаар хууль зүйн судалгааны хувьд эх газрын эрх зүйн бүлд ихэвчлэн хууль болон бусад хуульчилсан акт дахь зохицуулалтаар судалгаа эхлэн, цаашлаад тэдгээрийн тайлбар болон онолын ойлголтуудыг авч үзсэний дараагаар шүүхийн шийдвэрийг судлах хандлага түгээмэл ажиглагддаг байна.⁴⁰

Уламжлалт эх газрын эрх зүйд шүүх эрх зүйг “бүтээдэг”-гүй бөгөөд шүүхийн шийдвэр эрх зүйн эх сурвалж болохыг үгүйсгэдэг боловч орчин үеийн эх газрын эрх зүйд эрх зүйг тайлбарлаж, хэрэглэж буй шүүгчээс эрх зүй хамааралтай байж болохыг улам бүр хүлээн зөвшөөрч байна.⁴¹ Жишээ нь, 1804 оны Францын Иргэний хуульд одоо үед үүсэж болох гэм хорын харилцааг урьдчилж зохицуулж чадаагүй тул орчин үеийн францын гэм

³⁹ 장우석, 중국 사법해석 제도에 대한 고찰, 2021, 12, <https://s-space.snu.ac.kr/handle/10371/178301>, (2024.11.25).

⁴⁰ Joseph Dainow, “The Civil Law and the Common Law: Some Points of Comparison” (1967), 427-430, https://heinonline.org/HOL/Page?handle=hein.journals/amcomp15&div=34&gsent=1&casa_token=&collection=journals

⁴¹ Mary Ann Glendon, Comparative Legal Traditions: Text, Materials and Cases on Western Law, 3rd ed, (American Casebook Series, 2007) 74



хорын эрх зүйг шүүхийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэсэн тайлбарууд тодорхойлж байна.⁴²

Дэлхийн улс орнуудын үндэсний эрх зүйн тогтолцооны үүсэл хөгжлийн түүхийг авч үзвэл тэдгээр нь өөр хоорондоо харилцан нөлөөлөлд оршин авах гээх, уламжлах, шилжүүлэн хэрэглэх, нэг талын болон хоёр талын сонирхлын дагуу экспортлох-импортлох явцад үүсэж, бүрэлдэж ирсэн байна.⁴³ Эх газрын болон Англо-Саксоны эрх зүйн бүл хооронд бие биеэсээ ашигтай, давуу талуудаа солилцож, өөрийн бүлд шилжүүлэн суурилуулж буй бөгөөд сүүлийн жилүүдэд эрх зүйн бүлүүд ойртож (конвергенци), дан дангаараа оршин тогтнох боломжгүй болж байгаа бөгөөд цаашид нэгдмэл эрх зүйн тогтолцоонд шилжих тухай 20 дугаар зууны сүүл үеэс эхлэн ном, бүтээлд тэмдэглэж байжээ.⁴⁴

Орчин үед эрх зүйн бүлийг зааглан хувааж, улс орнуудыг аль нэг эрх зүйн бүлд хамааруулан хөгжүүлэх байдал арилж байгаа бөгөөд аль болох хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, эрх зүйн өндөр соёлд хүрэхийн төлөө адилших буюу конвергенцижүүлэх хандлага давамгайлах болсон.⁴⁵

Түүхийн үүднээс авч үзвэл манай эриний 193-211 оны хооронд Ромын эзэн хаан байсан Сэвэрус эрх зүйн тогтолцооны хийдэл нь бичмэл хуулийн хоёрдмол утга, тодорхойгүй байдлаас бий болдог. Энэ нь заншлын эрх зүй (лат. *consuetudo*) ба төсөөтэй шийдэгдсэн хэрэг маргаан (лат. *res perperuo similiter iudicatae*) хоёроор нөхөгддөг ба эдгээр нь хоёулаа хууль зүйн хүчин чадалтай⁴⁶ тухай тэмдэглэж байжээ.

Мөн Рэнэ Дэвид “зөвхөн парламентаар баталсан хуулийг эрх зүйн эх сурвалж мэт үздэг төөрөгдөл арилж байна. Гэвч хуучны үзэл байр сууриа тавьж өгөхдөө удаан байдаг”⁴⁷ гэсэн ба эх газрын эрх зүйт орнуудын хууль тогтоомжид шүүхийн жишгийг заавал дагаж мөрдөх тухай шууд заасан заалт ховор хэдий ч шүүхийн жишгийг хэрэглэж болохоор заасан тойруу утгатай заавал оршиж байдаг⁴⁸ талаар авч үзсэн эх сурвалжууд мөн байна.

⁴² Ibid 73.

⁴³ Ч.Батцэцэг, *Монгол Улсад эрх зүйг зээлдэн нутагшуулах арга ажиллагаа, сургамж дүгнэлт*, 2013, 11 дэх тал.

⁴⁴ Өмнөх эшлэл 43, 9-10 дахь тал.

⁴⁵ Өмнөх эшлэл 43, 66 дахь тал.

⁴⁶ Б.Гүнбилэг, *Жишгийн эрх зүй*, 2008, 46 дахь тал

⁴⁷ Өмнөх эшлэл 46, 47 дахь тал.

⁴⁸ Өмнөх эшлэл 43, 10 дахь тал



Тодруулбал, хоорондоо адил төсөөтэй эрх зүйн тогтолцоонуудыг нэгтгэх замаар эрх зүйн бүлийн ангилал, ойлголт бий болсон боловч энэ нь цаг үе бүрд шүүмжлэл дагуулсаар ирсэн ба хорьдугаар зууны сүүлч үеэс эхлэн эрх зүйн бүлүүд хоорондоо уусах, хосолмол хэв шинжийг баримтлах болжээ. Эрх зүйн бүлүүд өөр хоорондоо давуу, ач холбогдолтой шинжээ солилцох, нутагшуулах нь эерэг нөлөөтэй байх бөгөөд орчин үед эрх зүйн бүлийн онцлог шинж гэхээсээ илүүтэйгээр улс орнуудын эрх зүйн тогтолцооны онцлог хэв маяг бүрэлдэн бий болсон байна. Тийм ч учраас энэхүү гарын авлагад социалист эрх зүйн тогтолцоо суурьтай улсууд болох пост социалист орны төлөөллийг "тусгай бүлэг" болгон ангилсан нь тус орнууд хэдийн эх газрын эрх зүйн бүлийн загвараар хөгжиж буй ч "социалист эрх зүйн тогтолцоотой байсан" гэх түүхэн онцлогийг харьцуулсан судалгаанд заавал "анхааран" авч үзэх шаардлагатай байдагтай холбоотой юм. Тус гарын авлага нь хууль, эрх зүйн чиглэлээр судалгаа хийхээр зорьж буй судлаачдад эх газар, жишиг, социалист эрх зүйн бүл болон пост социалист орны шүүхийн тогтолцооны онцлог, адил болон ялгаатай талыг харьцуулан дүгнэх боломжийг олгоно хэмээн найдаж байна.




НЭГ. ЭХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН БҮЛД ХАМААРАХ УЛСУУД

1. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Бүгд найрамдах Франц Улс (цаашид “Франц улс” гэх)-д шүүх эрх мэдлийг хуваарилах зарчим үйлчилдэг бөгөөд энэ хүрээндээ захиргааны хэрэг болон иргэн, эрүүгийн хэргийг хэлэлцэх хоёрдмол шүүхийн тогтолцоо байдаг.

Схем 1. Франц улсын шүүхийн тогтолцоо



1. Хяналтын шүүх

Францын ердийн шүүхийн тогтолцооны дээд шатны шүүх нь Хяналтын шүүх (*фр. Cour de Cassation*) бөгөөд тус шүүх нь иргэний 3 танхим, нийгмийн эрх зүйн танхим, худалдаа, санхүү, эдийн засгийн танхим, эрүүгийн танхим гэсэн 6 танхимаас бүрддэг.⁴⁹ Танхим бүр тус гомдлын тооноос хамаарч тэнцүү бус тооны шүүгчийн бүрэлдэхүүнтэй байдаг ба доод шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох ноцтой үндэслэлгүй эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүн “илт

⁴⁹ Cour de cassation, The cour de cassation's international newsletter, 2024, p 2,



ойлгомжтой байгаа” тохиолдолд хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнээр хянан хэлэлцэнэ. Өмнө дурдсанаас бусад тохиолдолд хэргийг 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх ба тус бүр саналын 1 эрхтэй байна.⁵⁰ Мөн Шүүхийн зохион байгуулалтын хууль⁵¹ (*фр. Code de l'organisation judiciaire*) -д “хуульд өөрөөр заагаагүй бол хэргийг сондгой тооны шүүгчийн бүрэлдэхүүнээр шийдвэрлэнэ” гэж заажээ.

Хэргийг шийдвэрлэхэд зарчмын асуудал үүссэн, эсхүл анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн буюу нийтэд ач холбогдолтой асуудал бол нийт шүүгчийн хуралдаанаар шийдвэрлэнэ. Нийт шүүгчийн хуралдааныг бүх танхимын даргалагч, ахмад шүүгчид болон танхим бүрээс 1 шүүгч, нийт 19 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр явуулдаг.

Түүнчлэн хэд хэдэн танхимд зэрэг харьяалагдах эсхүл өөр өөр танхимууд ялгаатай байдлаар шийдвэрлэсэн, шийдвэрлэх магадлалтай тохиолдолд хамтарсан хуралд шилжүүлдэг. Хамтарсан хурлын бүрэлдэхүүнд дээд шүүхийн тэргүүн, эсхүл түүний орлогч болон хамаарал бүхий танхим тус бүрээс 4 шүүгч (танхимын даргалагч, ахлах шүүгч, 2 шүүгч) шийдвэрлэнэ. Хамтарсан хурлын зорилго нь хууль тогтоомжийн талаарх танхимуудын саналын зөрөөтэй байдлыг таслан зогсооход чиглэдэг.⁵² Хяналтын шүүхийн хамгийн ахмад туршлагатай шүүгчийг декан гэх бөгөөд тэрээр тэргүүний эзгүйд нийт шүүгчдийг даргална.

2. Захиргааны дээд шүүх

Захиргааны дээд шүүх (*фр. Conseil d'Etat*) нь маргааны төрлөөр 10 танхимд хуваагддаг бөгөөд Захиргааны дээд шүүхэд ирсэн яаралтай хариу өгөх өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх алба мөн байдаг.⁵³ Захиргааны шүүхийн хууль⁵⁴ (*фр. Code de justice administrative*)-ийн I дэвтрийн 2-р хэсэгт заасны дагуу танхимууд хэд хэдэн танхимд зэрэг хамаарах хэргийг хамтарч шийдвэрлэж болдог ба танхимаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа тохиолдолд саналын эрхтэй 3 шүүгч, хамтарсан танхимаар

⁵⁰ Role of the Cour de cassation, <https://www.courdecassation.fr/en>

⁵¹ Франц улсын Шүүхийн зохион байгуулалтын хууль, https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006071164/2024-11-05/

⁵² Ibid

⁵³ L'organisation du Conseil d'État, <https://www.conseil-etat.fr/qui-sommes-nous/le-conseil-d-etat/organisation>

⁵⁴ Франц улсын Захиргааны шүүхийн хууль, https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006070933/2024-11-05



шийдвэрлэж байгаа тохиолдолд саналын эрхтэй 5-аас доошгүй шүүгчийн бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэнэ.

Түүнчлэн Франц улсад Захиргааны дээд шүүх болон Хяналтын шүүх хоорондын хэргийн харьяаллын маргааныг шийдвэрлэх үүрэгтэй хэргийн тусгай шүүх (Зөрчилдөөний шүүх) үйл ажиллагаа явуулдаг байна.

3. Ердийн харьяаллын анхан шатны шүүхүүд

Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд нь хувь хүмүүс хоорондын иргэний маргаан буюу түрээс, ашиглалт, банк, даатгал, гэр бүл салалт, үрчлэлт, өв залгамжлал, хөршийн эрх зэрэгт холбогдох маргааныг шийдвэрлэдэг. Мөн ажилчид болон ажил олгогчдын хоорондын маргааныг шийдвэрлэх Аж үйлдвэрийн шүүх (фр. Le conseil de prud'hommes), арилжаа эрхлэгч болон хувь хүмүүсийн хоорондын маргааныг шийдвэрлэх Арилжааны шүүх (фр. Le tribunal de commerce) зэрэг хэд хэдэн дагнасан шүүхүүд бий.⁵⁵

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд нь насанд хүрэгчдийн үйлдсэн гэмт хэрэг (хулгай, дээрэм, хүчирхийлэл гэх мэт) болон тус гэмт хэргээс үүдэлтэй хохирол, нөхөн төлбөрийн маргааныг хянан хэлэлцдэг.⁵⁶ Мөн хүүхдийн (16 насанд хүрээгүй) үйлдсэн гэмт хэргийн шүүх (фр. Le tribunal pour enfants), насанд хүрээгүй хүний (16-18 насны хүн) шүүх (фр. La cour d'assises) гэсэн дагнасан шүүхүүд байдаг.⁵⁷

II. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид “ХБНГУ”)–ын Үндсэн хууль⁵⁸ (англ. *Basic Law for the Federal Republic of Germany*)–ийн 95 дугаар зүйлд Холбооны улсын хүрээнд байгуулах Холбооны дээд шүүхүүдийг хуульчилсан. Эдгээр нь **Холбооны улсын шүүх** (англ. *Federal Court of*

⁵⁵ Les juridictions civiles spécialisées, <https://www.justice.gouv.fr/justice-france/lorganisation-cours-tribunaux/lordre-judiciaire/juridictions-civiles-specialisees>

⁵⁶ Les juridictions pénales, <https://www.justice.gouv.fr/justice-france/lorganisation-cours-tribunaux/lordre-judiciaire/juridictions-penales>


⁵⁷ Les juridictions pour mineurs, <https://www.justice.gouv.fr/justice-france/lorganisation-cours-tribunaux/lordre-judiciaire/juridictions-mineurs>

⁵⁸ Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, 1949, https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html, (Сүүлд үзсэн: 2024.10.28).



Justice), Холбооны захиргааны шүүх (англ. *Federal Administrative court*), Холбооны санхүүгийн шүүх (англ. *Federal Fiscal Court*), Холбооны хөдөлмөрийн шүүх (англ. *Federal Labour Court*), Холбооны нийгмийн халамжийн шүүх (англ. *Federal Social Court*)-үүд байх ба чиг үүргийн хувьд ердийн, захиргааны, санхүү, хөдөлмөрийн болон нийгмийн халамжтай холбоотой маргааны харьяаллаар дагнаж, салбар бүрийнхээ эцсийн шатны шүүх болдог.

Схем 2. ХБНГУ-ын шүүхийн тогтолцоо



1. Ердийн шүүхийн тогтолцоо

Эрүүгийн хэргийн шүүх болон иргэний хэргийн шүүх нь ердийн шүүхийн тогтолцоонд хамаардаг бөгөөд энэхүү шүүхийн тогтолцоо нь Орон нутгийн шүүх, Муж улсын шүүх, Муж улсын дээд шүүх, Холбооны улсын шүүх гэсэн 4 шаттай байна. Ердийн шүүхийн тогтолцоонд хэргийг голдуу шүүх бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх бөгөөд муж улсын шүүхийн



бүрэлдэхүүнийг танхим (гер. *Kammern*) хэмээн нэрлэх бол муж улсын дээд шүүх, Холбооны улсын шүүхийн бүрэлдэхүүнийг сенат (гер. *Senat*) хэмээн нэрлэнэ. Хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд мэргэжлийн шүүгч байхаас гадна олон нийтийн шүүх эрх мэдэлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх үүднээс иргэдийн төлөөлөгчийг оролцуулдаг.

Эрүүгийн хэргийн шүүхийн тогтолцоо

Эрүүгийн хэргийн шүүхийн тогтолцоо нь 4 шаттай байх бөгөөд эрүүгийн хэрэг нь шат бүрийг дамжихгүй, 3 эсвэл 2 үе шатыг дамжих байдлаар эцэслэн шийдвэрлэгддэг.

1. Орон нутгийн шүүх (гер. *Amtsgericht*)
2. Муж улсын шүүх (гер. *Landgericht*)
3. Муж улсын дээд шүүх (гер. *Oberlandesgericht*)
4. Холбооны дээд шүүх (гер. *Bundesgerichtshof*)

Эрүүгийн хэргийн шүүхийн тогтолцоо, шүүхийн үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг Шүүхийн тунхаг хууль⁵⁹ болон Эрүүгийн процессын хууль⁶⁰-аар тус тус зохицуулсан байна. Эрүүгийн хэргийн харьяаллыг нутаг дэвсгэрийн харьяалал, хэргийн харьяалал, чиг үүргийн харьяалал гэсэн төрлүүдэд хуваах бөгөөд хэргийн харьяаллаар аль шүүх тухайн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх, мөн хэргийг шийдвэрлэх шүүхийн бүрэлдэхүүнийг зааж өгдөг. Дээрх дөрвөн шатны шүүхээс орон нутгийн шүүх, муж улсын шүүх, муж улсын дээд шүүх нь эрүүгийн хэргийг хуульд зааснаар анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Мөн хэргийг шүүгч дангаар шийдвэрлэхээс илүүтэйгээр бүрэлдэхүүнтэй шийдвэрлэдэг бөгөөд уг бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийг багтаадаг. Англи-америкийн эрх зүйн тогтолцоонд *Jury* буюу тангарагтны шүүгч нь шүүгдэгчийн гэм буруутай эсэх талаар шийдвэр гаргаж, шүүгч нь оногдуулах эрүүгийн хариуцлагыг тогтоодог бол Герман улсын хувьд сайн дурын шүүгч (гер. *Laienrichter*) буюу иргэдийн төлөөлөгч нь шүүгдэгчийн гэм буруугийн асуудал болон эрүүгийн хариуцлага оногдуулах асуудалд мэргэжлийн шүүгчтэй адил эрхтэй оролцдог байна.⁶¹

Орон нутгийн шүүх хэргийг анхан шатны журмаар хянан

⁵⁹ Gerichtsverfassungsgesetz (GVG), 1950, <https://www.gesetze-im-internet.de/gvg/index.html> (Сүүлд үзсэн: 2024.11.26).

⁶⁰ Strafprozeßordnung (StPO), 1950, <https://www.gesetze-im-internet.de/stpo/BJNR006290950.html#BJNR006290950BJNG000102311>, (Сүүлд үзсэн: 2024.11.25).

⁶¹ Volker Krey, Manfred Heinrich: *Deutsches Strafverfahren*, 2019. S.33



шийдвэрлэх бөгөөд шүүгч дангаар эсвэл нэг мэргэжлийн шүүгч, хоёр иргэдийн төлөөлөгч (гер.*Schöffe*)-ийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг хянан шийдвэрлэдэг байна. Шүүхийн тунхаг хуулийн 24 зүйлд зааснаар орон нутгийн шүүх нь дараах хэргийг шийдвэрлэнэ. Үүнд:

1. Муж улсын болон муж улсын дээд шүүхэд анхан шатны журмаар хянан шийдвэрлүүлэхээр харьяалуулснаас бусад гэмт хэргийг,
2. 4 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг.

Орон байрны амгалан тайван байдлыг алдагдуулах, доромжлох, хүний бие махбодод гэмтэл учруулах, захидал харилцааны нууцад халдах, дарамт үзүүлэх, эд зүйл сүйтгэх гэмт хэрэг болон хоёр жилээс доош хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийг шүүгч дангаар, харин 2 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэргийг шүүх бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэнэ.

Муж улсын шүүхийн бүрэлдэхүүнийг эрүүгийн танхим (гер.*Strafkammer*) гэж нэрлэх бөгөөд их, бага танхимд хуваагддаг. Их танхим нь хуулиар харьяалуулсан зарим хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг бол бага танхим нь орон нутгийн шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар хянадаг. Муж улсын шүүх нь нэг талаас хэргийг анхан шатын журмаар шийдвэрлэдэг ба нөгөөтээгүүр гомдлын үндсэн дээрх хэргийг давж заалдах журмаар хянадаг тул давхар чиг үүрэгтэй (гер.*Doppelfunktion*) шүүх хэмээн үздэг байна.

Их танхим нь хуулиар харьяалуулсан зарим хэргийг тухайлбал 4 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг (үүнд: хүнийг алах гэмт хэрэг, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг, хүний бие махбодод гэмтэл учруулсны улмаас хохирогч нас барах гэмт хэрэг зэрэг), Эрүүгийн хууль⁶²-ийн 66 дугаар зүйлд заасан урьдчилан сэргийлэх зорилгоор цагдан хорих, сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх асуудлыг шийдвэрлэх зэрэг хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэнэ. Ингэхдээ 3 мэргэжлийн шүүгч, 2 иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэдэг байна. Их танхим хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн тохиолдолд уг шийдвэрт гаргах гомдлыг муж улсын дээд шүүхэд гаргахгүйгээр шууд Холбооны улсын шүүхэд гаргадаг.

⁶² Strafgesetzbuch (StGB), 1871, <https://www.gesetze-im-internet.de/stgb/index.html>, (Сүүлд үзсэн: 2024.11.25).



Их танхимаас гадна эрүүгийн хэргийн тусгай танхим ажиллах бөгөөд үүнд Тангарагтны шүүх (гер.*Schwurgericht*), Улсын аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх танхим (гер. *Staatsschutzkammer*), Эдийн засгийн эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх танхим (гер. *Wirtschaftsstrafkammer*) багтана.

Муж улсын дээд шүүх хуулиар харьяалуулсан зарим хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхээс гадна хэргийг хяналтын журмаар шийдвэрлэдэг тул мөн давхар чиг үүрэгтэй шүүхэд хамаарна. Уг шүүх нь Эрүүгийн хуульд заасан холбооны улсын аюулгүй байдалд халдах, эх орноосоо урвах, улсын нууц задруулах, энх тайвны эсрэг үйл ажиллагаа явуулах зэрэг гэмт хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Шүүх хэргийг шийдвэрлэхдээ 3 эсвэл 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх бөгөөд тус бүрэлдэхүүнийг сенат (гер. *Senat*) хэмээн нэрлэдэг байна. Орон нутгийн шүүхийн шийдвэрт хэргийн оролцогч нь давж заалдах журмаар муж улсын шүүхэд гомдол гаргахаас гадна энэ шатыг алгасаж шууд хяналтын гомдлоо муж улсын дээд шүүхэд гаргаж болох бөгөөд үүнийг Sprungrevision хэмээн нэрлэдэг. Гомдлыг хянахдаа 3 мэргэжлийн шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянаана.

Холбооны улсын шүүхүүд нь бүтэц, зохион байгуулалт болон тамгын газрын хувьд тус тусдаа бие даасан байдаг. Мөн шүүхүүд өөр хоорондоо хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахын тулд Нэгдсэн Зөвлөл (англ. *Joint Panel*)-тэй ажилладаг байна.⁶³ Холбооны улсын шүүх нь иргэний болон эрүүгийн эрх зүйн Зөвлөл (англ. *Panel*)-үүдэд хуваагдах бөгөөд, Зөвлөлийн тоог Холбооны Хууль зүйн сайд тогтоодог. Одоогоор иргэний эрх зүйн 13, эрүүгийн эрх зүйн 6 зөвлөл ажиллаж байгаа талаар тэмдэглэжээ.⁶⁴ Зөвлөл бүр даргалагч шүүгчтэй бөгөөд үлдсэн шүүгчид бүгд иргэний эсхүл эрүүгийн аль нэг Зөвлөлд байнгын томилогддог. Ийнхүү Зөвлөл бүр 6-аас 8 хүртэлх шүүгчдээс бүрдэж (даргалагч шүүгчээс гадна),⁶⁵ харин Шүүхийн тунхаг хууль (англ. *Courts Constitutional Act*)-д зааснаар хэрэг хянан шийдвэрлэх хуралдаанд даргалагч шүүгчийг оролцуулан 5 шүүгч оролцож шийдвэр гаргадаг.⁶⁶ Хэрэг хянан

⁶³ The President of the Federal Court of Justice, *The Federal Court of Justice - Broschuere*, 2021, p.5, https://www.bundesgerichtshof.de/SharedDocs/Downloads/EN/BGH/broschuere2020_NurTextEnglisch.pdf?__blob=publicationFile&v=4, (Сүүлд үзсэн: 2024.10.28).

⁶⁴ Ibid, 6.

⁶⁵ Ibid.

⁶⁶ Courts Constitution Act (Gerichtsverfassungsgesetz – GVG, 1975), art. 139(1).



шийдвэрлэх хуралдааны бүрэлдэхүүнийг Зөвлөлийн бүх гишүүдийн баталсан хуваарийн (англ. *Schedule of Jurisdiction*) дагуу томилдог. Үүнээс гадна эрүүгийн эрх зүйн зөвлөлүүд даргалагч шүүгчийг оролцуулан **3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр гомдол хүлээн авч шийдвэрлэдэг.** Уг зохицуулалт нь хэргийг хянан хэлэлцэхээс татгалзсан болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны саатлын улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгосон шийдвэрт гаргасан гомдолд хамааралгүй юм.⁶⁷

Шүүхийн тунхаг хуулийн 132 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Холбооны улсын шүүхэд эрүү, иргэний зөвлөлүүд дундаасаа Их Зөвлөл (англ. *Grand Panel*)-ийг байгуулах ба Их зөвлөлөөс Нэгдсэн Их Зөвлөл (англ. *United Grand Panels*)-ийг байгуулахаар заасан байна. Хэрэв зөвлөлүүд бусад зөвлөлөөс гаргасан шийдвэртэй санал зөрөлдсөн тохиолдолд Их танхимаас тухайн асуудлыг хянан хэлэлцдэг бол эрүү болон иргэний хэргийн зөвлөлүүдийн дунд саналын зөрүүтэй асуудал үүсвэл Нэгдсэн Их Зөвлөл хянан хэлэлцэж шийдвэрлэхээр зохицуулжээ.

Тэгвэл эрүүгийн хэргийн хувьд хэргийг хуваарилахдаа голчлон бүс нутгийн харьяаллыг шалгуур болгодог. Эрүүгийн хэргийн 6 зөвлөл тус бүр өөрсдийн харьяалах давж заалдах шатны шүүхийн тойргоос ирсэн гомдлуудыг хүлээж авахаас гадна дараах маргаануудыг зарим зөвлөлүүдэд тусгай чиг үүргийн хувьд хуваарилдаг. Үүнд:

Эрүүгийн хэргийн нэгдүгээр зөвлөл:

цэргийн гэмт хэрэг, үндэсний батлан хамгаалахын эсрэг зөрчил, татвар болон гаалийн гэмт хэрэг.

Эрүүгийн хэргийн гуравдугаар зөвлөл:

төрийн эсрэг гэмт хэрэг.

Эрүүгийн хэргийн дөрөвдүгээр зөвлөл:

зам тээврийн хөдөлгөөний хэрэг.

Иргэний хэргийн шүүхийн тогтолцоо

Иргэний хэргийн шүүхийн тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг Шүүхийн тунхаг хууль болон Иргэний процесс хуулиар⁶⁸ тус тус зохицуулжээ. Иргэний шүүхийн тогтолцоо нь 4 шаттай байна.

⁶⁷ Courts Constitution Act (Gerichtsverfassungsgesetz – GVG, 1975), art. 139(2).

⁶⁸ Zivilprozessordnung, (ZPO) 1950, <https://www.gesetze-im-internet.de/zpo/index.html>, (Сүүлд үзсэн: 2024.11.27).



1. Орон нутгийн шүүх (гер. *Amtsgericht*)
2. Муж улсын шүүх (гер. *Landgericht*)
3. Муж улсын дээд шүүх (гер. *Oberlandesgericht*)
4. Холбооны дээд шүүх (гер. *Bundesgerichtshof*)

Орон нутгийн шүүх болон муж улсын шүүх нь иргэний хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Эрүүгийн хэрэгт муж улсын дээд шүүх нь хуулиар харьяалуулсан зарим хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг бол иргэний хэрэгт муж улсын дээд шүүхэд хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэггүй гэдгээрээ ялгаатай болно.

Орон нутгийн шүүхийн харьяалан шийдвэрлэх хэргийг Шүүхийн тунхаг хуулийн 23 дугаар зүйлд заасан байна. Орон нутгийн шүүх нь нэхэмжлэлийн үнийн дүн нь 5.000 еврогоос хэтрээгүй хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Мөн маргааны үнийн дүнгээс үл хамаарах зарим хэргийг тухайлбал, гэр бүлийн маргаан, орон сууцны түрээсийн маргаан, аялагч болон аяллын үйлчилгээ үзүүлж буй этгээдүүдийн хооронд гарсан маргаан, зэрлэг амьтны учруулсан хохирлын маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Орон нутгийн шүүхэд хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэдэг байна.⁶⁹

Муж улсын шүүх нь 5.000.01 еврогоос дээш нэхэмжлэлийн дүн бүхий иргэний хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг. Ингэхдээ муж улсын шүүхэд хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэхгүй, бүрэлдэхүүнээр шийдвэрлэх бөгөөд уг бүрэлдэхүүнийг танхим (гер. *Kammer*) хэмээн нэрлэнэ. Танхим нь 3 мэргэжлийн шүүгчээс бүрдэнэ.⁷⁰ Мөн муж улсын шүүхэд арилжааны хэргийн танхимыг байгуулж болох бөгөөд уг танхим нь 1 мэргэжлийн шүүгч, 2 иргэдийн төлөөлөгчийн⁷¹ бүрэлдэхүүнтэйгээр хэргийг шийдвэрлэдэг байна.

Муж улсын дээд шүүх нь муж улсын анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийг 3 мэргэжлийн шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

Холбооны улсын шүүх нь иргэний болон эрүүгийн эрх зүйн Зөвлөл (англ. *Panel*)-үүдэд хуваагдаж, тэдгээрийн тоог Холбооны Хууль зүйн сайд

⁶⁹ § 22 Absatz 4 GVG

⁷⁰ § 75 GVG

⁷¹ Шүүхийн тунхаг хуулийн 105 дугаар зүйлд zwei ehrenamtlichen Richtern (англ. two honorary judges) буюу хүндэт шүүгч хэмээн нэрлэдэг байна.



тогтоодог. Одоогоор иргэний эрх зүйн 13 зөвлөл ажиллаж байгаа талаар тэмдэглэжээ.⁷² Зөвлөл бүр даргалагч шүүгчтэй бөгөөд үлдсэн шүүгчид бүгд иргэний, эсхүл эрүүгийн аль нэг зөвлөлд байнгын томилогддог. Иргэний хэргийн хувьд хэрэг хуваарилалт нь аль болох мэргэшсэн байх зарчмыг баримталдаг уламжлалтай. Иргэний зөвлөлүүдэд дараахь эрх зүйн салбаруудыг үндсэн чиглэл болгон хуваарилсан байна. Үүнд:

Иргэний хэргийн нэгдүгээр зөвлөл:

зохиогчийн эрх, оюуны өмчийн эрхийн хамгаалалт, зуучлал, агуулах болон тээвэрлэлтийн хууль, агентлагийн хууль.

Иргэний хэргийн хоёрдугаар зөвлөл:

компанийн тухай хууль, холбоодын тухай хууль.

Иргэний хэргийн гуравдугаар зөвлөл:

төрийн болон нотариатчийн хариуцлага, материаллаг хууль, гэрээний эрх зүй, хөдөлмөрийн хууль.

Иргэний хэргийн дөрөвдүгээр зөвлөл:

өв залгамжлал, даатгал.

Иргэний хэргийн тавдугаар зөвлөл:

үл хөдлөх хөрөнгийн тухай хууль.

Иргэний хэргийн зургаадугаар зөвлөл:

зөрчлийн хууль, зам тээврийн ослын маргаан, бүтээгдэхүүний хариуцлага, эмнэлгийн хариуцлага.

Иргэний хэргийн долоодугаар зөвлөл:

барилга, архитектурын хууль, хэрэгжүүлэх хууль.

Иргэний хэргийн наймдугаар зөвлөл:

арилжаа, түрээс.

Иргэний хэргийн есдүгээр зөвлөл:

төлбөрийн чадваргүй байдал, өмгөөлөгчийн хариуцлага, нягтлан бодогчийн хариуцлага.

Иргэний хэргийн аравдугаар зөвлөл:

патентын тухай хууль, бэлэглэлийн тухай хууль, аялал жуулчлалын тухай хууль.

Иргэний хэргийн арван нэгдүгээр зөвлөл:

банкны тухай хууль, хөрөнгийн зах зээлийн тухай хууль.

Иргэний хэргийн арван хоёрдугаар зөвлөл:

гэр бүлийн тухай хууль, арилжааны түрээсийн хууль.

Иргэний хэргийн арван гуравдугаар зөвлөл:

эрчим хүчний салбарын хууль, худалдах худалдан авах харилцаа.

⁷² The President of the Federal Court of Justice, *supra* note 63. p.8.



2. Захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо

Захиргааны шүүх нь нийгмийн асуудал, татварын асуудлаас бусад нийтийн эрх зүйн асуудлыг шийдвэрлэдэг. Энэхүү дагнасан шүүх нь нийтийн захиргааны байгууллагаас өөрт олгогдсон эрх хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор иргэн, хуулийн этгээдийн эрх, ашгийг хөндсөн маргааныг хянан хэлэлцдэг. Захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо болон захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг Шүүхийн тунхаг хууль болон Захиргааны шүүхийн тухай хууль⁷³-аар тус тус зохицуулдаг. Захиргааны хэргийн шүүх нь 3 шаттай байна.

- Захиргааны шүүх (гер.*Verwaltungsgerichte*)
- Захиргааны дээд шүүх (гер.*Oberverwaltungsgericht*)
- Холбооны захиргааны шүүх (гер.*Bundesverwaltungsgericht*)

Захиргааны шүүх

Герман улсад 51 захиргааны шүүх үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд уг шүүх нь захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг. Захиргааны шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх өгүүлбэрт “Захиргааны шүүх нь үндсэн хуулийн шүүхийн бус, мөн түүнчлэн хуулиар өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн бүх маргааныг хянан шийдвэрлэнэ”⁷⁴ хэмээн заасан байна. Захиргааны шүүх нь захиргааны дээд шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэхээр хуульд зааснаас бусад бүх захиргааны хэргийн маргаан тухайлбал, захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэл, даалгах нэхэмжлэл, эрх зүйн харилцаа байгаа эсэх эсвэл захиргааны акт хууль бус болохыг тогтоолгох нэхэмжлэл зэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг байна.

Захиргааны шүүх хэргийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх бөгөөд бүрэлдэхүүн нь 3 мэргэжлийн шүүгч, 2 иргэдийн төлөөлөгчөөс бүрддэг.⁷⁵ Иргэдийн төлөөлөгчийг захиргааны хэргийн шүүх хуралдаанд оролцуулж байгаа нь олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд аман шүүх хуралдаанд мэргэжлийн шүүгчтэй адил эрхтэй оролцох

⁷³ Verwaltungsgerichtsordnung (VwGO), 1960, <https://www.gesetze-im-internet.de/vwgo/index.html#BJNR000170960BJNE006001308> (Сүүлд үзсэн:2024.11.25).

⁷⁴ 40 Abs 1 Satz 1 VwGO

⁷⁵ англиар *Honorary judges* гэнэ. https://www.gesetze-im-internet.de/englisch_vwgo/englisch_vwgo.html#p0084



ба 25 насанд хүрсэн, тухайн дүүрэгт оршин суудаг, Герман улсын иргэн байх ёстой.⁷⁶

Захиргааны дээд шүүх

Захиргааны шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг хоёр дахь шатны шүүх болох захиргааны дээд шүүх хянан шийдвэрлэнэ. Тус улс нь нийт 16 мужтай бөгөөд муж бүрд захиргааны дээд шүүхийг байгуулсан бөгөөд гагцхүү Берлин болон Бранденбург мужийн дунд нэг захиргааны дээд шүүхийг байгуулсан байна. Ингэснээр тус улсад нийт 15 мужид захиргааны дээд шүүх үйл ажиллагаа явуулж байна.⁷⁷ Захиргааны дээд шүүх нь хуульд зааснаар зарим хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг. Тодруулбал, Захиргааны шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан хэм хэмжээний актын хяналт, 48 дугаар зүйлд заасан томоохон хэмжээний төсөлтэй холбоотой маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг байна. Захиргааны хэргийн шүүх нь сенатаас бүрдэх бөгөөд сенатын бүрэлдэхүүнд 3 мэргэжлийн шүүгч, 2 иргэдийн төлөөлөгч байна.

Холбооны улсын захиргааны шүүх

Захиргааны шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт *“Холбооны улсын захиргааны шүүх нь Ерөнхийлөгч, Даргалагч шүүгч болон шаардлагатай тооны бусад шүүгчдээс бүрдэнэ”* гэж, 2 дахь хэсэгт *“Холбооны улсын захиргааны шүүхэд танхимуудыг байгуулна”* гэж, мөн 3 дахь хэсэгт *“Холбооны улсын захиргааны шүүхийн танхимууд нь 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэр гаргана; хэлэлцүүлэг өрнүүлээгүй бол шийдвэрийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэнэ”* гэж тус тус заасан байгаагаас харвал Холбооны улсын захиргааны хэргийн шүүх хэрэг маргааныг 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэдэг байна.

Холбооны улсын захиргааны шүүх

Холбооны улсын захиргааны хэргийн шүүхийн танхим (англ. *Senate*) бүр нь даргалагч болон бусад шүүгчдээс бүрдэж, танхимын ажилд нэг

⁷⁶ § 20 VwGO

⁷⁷ Aufgaben und Aufbau der Verwaltungsgerichtsbarkeit, <https://www.justiz.nrw.de/Gerichte/Behoerden/fachgerichte/Verwaltungsgericht/aufbau/index.php> (сүүлд үзсэн: 2024.11.25).



болон хэд хэдэн судлаачид судалгааны ажлаар дэмжлэг үзүүлдэг. Одоогийн байдлаар 11 танхим эрх зүйн маргаантай асуудлаар хяналтын шатны гомдлыг хянан хэлэлцэж, 2 танхим зэвсэгт хүчний асуудалтай холбоотой маргааныг шийдвэрлэж байна.⁷⁸ Мөн бусад холбооны шүүхүүдийн адилаар захиргааны шүүх нь Их танхим (англ. *Grand Senate*)-тай байх ба Захиргааны хэргийн шүүхийн процессын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар аль нэг танхим хууль зүйн асуудлаар бусад танхимын, эсхүл Их танхимын шийдвэрийн эсрэг байр суурьтай байвал уг асуудлыг Их танхим хянаж шийдвэрлэдэг.

Ийнхүү Холбооны улсын шүүх, Холбооны улсын захиргааны хэргийн шүүхүүд нь бүтэц, зохион байгуулалтын хувьд зөвлөл, танхимд хуваагдсанаар хууль зүйн нарийн төвөгтэй маргааныг шийдвэрлэхэд мэргэшсэн, үр дүнтэй байдлыг цогцлоох суурийг тавьсан гэж харж болохоор байна. Зөвлөл, танхим бүр тодорхой хууль, эрх зүйн салбарыг хариуцаж, тухайн шүүгчид өөрт хамаарах чиглэлээр мэргэшсэн мэдлэгээ дээшлүүлэх боломжтойн дээр тухайн маргааныг шийдвэрлэж буй 5 шүүгчийн бүрэлдэхүүн байнгын байх тогтолцоо нь ижил төсөөтэй хэрэг, маргааныг өөр өөрөөр шийдвэрлэх эрсдэлийг бууруулах, ажлын ачааллыг хөнгөвчлөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг илүү системтэйгээр, шуурхай явуулах эерэг талуудтай. Мөн зөвлөл, танхимуудын хооронд санал зөрөлдсөн тохиолдолд уг асуудлыг шийдвэрлэх эрх бүхий Их танхим, Нэгдсэн Их Танхим, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах үүднээс Нэгдсэн Зөвлөлтэй байдаг нь шүүхүүдийн үйл ажиллагаанд нэгдмэл байдлыг хадгалах нөхцөлийг бүрдүүлж буй хэрэг юм.

3. Санхүүгийн шүүх

Санхүүгийн шүүхийн тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг 1965 онд батлагдсан Санхүүгийн шүүхийн процессын хууль⁷⁹-аар зохицуулдаг. Уг хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар санхүүгийн шүүх нь захиргааны шүүхийн тусгай шүүх юм. Санхүүгийн шүүхийн тогтолцоо нь 2 шаттай.

1. Санхүүгийн шүүх (гер. *Finanzgericht*)
2. Холбооны санхүүгийн шүүх (гер. *Bundesfinanzhof*)

⁷⁸ Federal Administrative Court Supreme Court, <https://www.bverwg.de/en/das-gericht/organisation/richter-und-senate>, (Сүүлд үзсэн: 2024.10.29).

⁷⁹ Finanzgerichtsordnung (FGO), 1965, <https://www.gesetze-im-internet.de/fgo/index.html>, (Сүүлд үзсэн: 2024.11.27).



Санхүүгийн шүүх

Санхүүгийн шүүх нь орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн албан татвар, өв залгамжлалын татвар зэрэг татвартай холбогдох маргаан болон гаалийн эрх зүйн маргааныг анхан шатны журмаар харьяалан шийдвэрлэнэ. Мөн тус шүүхийн хэргийн харьяаллыг 1996 онд өргөжүүлснээр хүүхдийн тэтгэмжтэй холбогдох маргааныг шийдвэрлэдэг болжээ. Санхүүгийн шүүх хуульд шүүгч дангаар шийдвэрлэхээр зааснаас бусад хэргийг 3 мэргэжлийн шүүгч, 2 иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэнэ. Санхүүгийн шүүхийн тогтолцоо нь бусад шүүхийн тогтолцоотой харьцуулахад хоёр шаттай байдаг бөгөөд санхүүгийн шүүх нь муж улсын дээд шүүхийн статустай байдаг.⁸⁰

Холбооны санхүүгийн шүүх

Хэргийн оролцогчоос санхүүгийн шүүхийн шийдвэрт гаргах хяналтын гомдлыг Холбооны санхүүгийн шүүхэд гаргана. Санхүүгийн шүүхийн ажиллагааны тухай хуулийн 115 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хяналтын гомдол нь “эрх зүйн чухал ач холбогдолтой, эрх зүйн хөгжилд эсвэл хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах шаардлагатай, эсвэл процесс ажиллагааны журам зөрчсөн” бол Холбооны санхүүгийн шүүх хяналтын журмаар хянан шийдвэрлэдэг байна. Холбооны санхүүгийн шүүх нь хэргийг 5 мэргэжлийн шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэдэг.

4. Хөдөлмөрийн шүүх

Хөдөлмөрийн шүүхийн тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг 1953 онд батлагдсан Хөдөлмөрийн шүүхийн тухай хуулиар зохицуулна.⁸¹ Хөдөлмөрийн шүүхийн тогтолцоо нь 3 шаттай байна.

1. Хөдөлмөрийн шүүх (гер.*Arbeitsgericht*)
2. Муж улсын хөдөлмөрийн шүүх (гер. *Landesarbeitsgerichten*)
3. Холбооны улсын хөдөлмөрийн шүүх (гер. *Bundesarbeitsgericht*)

Хөдөлмөрийн шүүх

Хөдөлмөрийн шүүх нь Хөдөлмөрийн шүүхийн тухай хуулийн

⁸⁰ § 2 FGO

⁸¹ Arbeitsgerichtsgesetz, 1953, <https://www.gesetze-im-internet.de/arbogg/> (Сүүлд үзсэн:2024.11.25).



2-3 дугаар зүйлд нэрлэн заасан маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх бөгөөд уг маргаанууд нь **Urteilsverfahren** болон **Beschlussverfahren** гэсэн хоёр төрөлд хуваагддаг байна. Хөдөлмөрийн шүүхийн тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан иргэний эрхтэй холбогдох хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг шүүх зөвхөн Urteilsverfahren ажиллагаа явуулж шийдвэрлэдэг. Уг ажиллагаа нь иргэний хэргийн процесс ажиллагааны адил талууд шүүхэд нотлох баримуудыг гаргаж өгөх үүрэг хүлээдэг байна.⁸² Уг маргаанд ажилтан болон ажил олгогч нарын хооронд үүссэн хөдөлмөрийн харилцааны маргаан тухайлбал, ажилтан болон ажил олгогчийн хооронд хөдөлмөрийн харилцаа үүссэн эсэх, хөдөлмөрийн харилцаатай холбоотой хууль бус үйлдэл, хөдөлмөрийн хөлс зэрэгтэй холбоотой маргааныг шийдвэрлэнэ. Шүүх энэ төрлийн ажиллагаанд эхлээд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулдаг байна. Харин дээрх хуулийн 2а дугаар зүйлд заасан маргааныг Beschlussverfahren ажиллагаагаар шийдвэрлэх бөгөөд уг маргаан нь хөдөлмөрийн хамтын маргаанууд байдаг. Уг ажиллагаанд шүүх өөрийн санаачилгаар нотлох баримтыг цуглуулдаг байна. Beschlussverfahren нь ажлын нөхцөл байдлын хууль болон ажилчдын төлөөлөгчийн тухай хууль, хамтран шийдвэр гаргах хуульд заасан асуудлаар хэргийг хянан шийдвэрлэдэг байна.

Шүүх хэргийг 1 мэргэжлийн шүүгч, ажил олгогч болон ажилтны төлөөллөөс тус бүр 1 иргэний төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх бөгөөд уг бүрэлдэхүүнийг танхим (гер.*Kammern*) хэмээн нэрлэнэ.

Муж улсын хөдөлмөрийн шүүх

Муж улсын хөдөлмөрийн шүүх нь давж заалдах журмаар хэргийг хянах бөгөөд 1 мэргэжлийн шүүгч, ажил олгогч болон ажилтны төлөөллөөс тус бүр 1 иргэдийн төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг шийдвэрлэдэг байна.

Холбооны хөдөлмөрийн шүүх

Холбооны хөдөлмөрийн шүүх нь 3 мэргэжлийн шүүгч, ажил олгогч болон ажилтан талаас тус бүр 1 төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр хяналтын журмаар хэргийг шийдвэрлэх бөгөөд уг бүрэлдэхүүнийг сенат

⁸² Norbert Schwab, Stephan Weth: Arbeitsgerichtsgesetz Kommentar, 2011,



хэмээн нэрлэдэг. Холбооны улсын хөдөлмөрийн шүүх нь нийт 10 сенаттай байна.⁸³ Мөн үүнээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах үүднээс бүх мэргэжлийн шүүгчийн бүрэлдэхүүнээс бүрдэх их сенат байна. Холбооны хөдөлмөрийн шүүхэд одоогоор 38 мэргэжлийн шүүгч ажиллаж байгаа бөгөөд тус шүүгчдийг Холбооны хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Шүүгчийг сонгох хороотой хамтран санал болгосноор Холбооны ерөнхийлөгч (гер. *Bundespräsidenten*) томилдог байна.

5. Нийгэм халамжийн шүүхийн тогтолцоо

Тус улс нь Нийгэм халамжийн тухай хууль⁸⁴-ийг 1953 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр баталж, улмаар 1954 оноос эхлэн нийгэм халамжийн шүүхүүдийг байгуулж эхэлжээ. Уг хууль батлагдахаас өмнө нийгэм халамжийн харилцаатай холбогдох маргааныг даатгалын алба (гер. *Reichsversicherungsamt*) нь хариуцан шийдвэрлэдэг байсан.⁸⁵ Нийгэм халамжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд нийгмийн халамжийн шүүхийг “захиргааны хэргийн тусгай шүүх” хэмээн тодорхойлсон байна. Уг шүүх нь 3 шаттай байна.

1. Нийгэм халамжийн шүүх (гер. *Sozialgerichte*)
2. Муж улсын нийгэм халамжийн шүүх (гер. *Landessozialgerichte*)
3. Холбооны нийгэм халамжийн шүүх (гер. *Bundessozialgericht*)

Нийгэм халамжийн шүүх

Нийгэм халамжийн шүүх нь захиргааны хэргийн тусгай шүүх бөгөөд Нийгэм халамжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд нийтийн эрх зүйд хамаарах зарим маргааныг харьяалан шийдвэрлэнэ. Үүнд:

1. Өндөр насны тэтгэвэр мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй этгээдийн өндөр насны халамжийн маргаан;
2. Эрүүл мэндийн даатгал, нийгмийн асаргаа сувилгааны даатгал мөн хувийн асаргаа сувилгааны даатгалын маргаан;
3. Гэнэтийн ослын даатгалтай холбоотой маргаан;
4. Холбооны хөдөлмөрийн агентлагийн чиг үүрэгт хамаарах

⁸³ Das Bundes-Arbeitsgericht, <https://www.bundesarbeitsgericht.de/leichte-sprache-2/>

⁸⁴ Sozialgerichtsgesetz (SGG), 1953, https://www.gesetze-im-internet.de/sgg/inhalts_bersicht.html, (Сүүлд үзсэн:2024.11.22).

⁸⁵ Bundessozialgericht, Geschichte, https://www.bsg.bund.de/DE/Home/home_node.html, (Сүүлд үзсэн:2024.11.22).



- хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой маргаан;
5. Нийгмийн даатгалтай холбоотой бусад маргаан;
 6. Нийгмийн нөхөн төлбөртэй холбоотой маргаан;
 7. Нийгэм халамжийн тухай хуулийн 8 дахь бүлгийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар мөн орогнол хүсэгчийн тэтгэмжийн тухай хуульд холбогдох маргаан
 8. Хөдөлмөр алдалтын зэргийг тогтоох
 9. Зардал хуваарилалтай холбоотой асуудлаар

Муж улсын нийгэм халамжийн шүүх

Нийгэм халамжийн шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ. Муж улсын нийгэм халамжийн шүүхийг мужууд дундаа байгуулж болох бөгөөд одоогоор тус улсад нийт 14 муж улсын нийгэм халамжийн шүүх үйл ажиллагаагаа явуулж байна. Хэргийг давж заалдах журмаар хянахдаа 3 мэргэжлийн шүүгч, 2 иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй байна.

Холбооны нийгэм халамжийн шүүх

Холбооны улсын нийгэм халамжийн шүүх нь хяналтын журмаар хэргийг 3 мэргэжлийн шүүгч, 2 иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ. Холбооны улсын нийгэм халамжийн шүүх нь зөвхөн хууль хэрэглээний асуудлыг шийдвэрлэх замаар хуулийн нэгдмэл байдлыг хангадаг. Уг шүүх нь 12 сенатад хуваагддаг бөгөөд нэг сенат нь 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй байна.⁸⁶ Хяналтын журмаар гаргасан гомдол нь хуульд заасан шаардлагыг хангасан бол хүлээн авч шийдвэрлэнэ. Холбооны улсын бусад шүүхийн адил мөн их танхимтай байна.

⁸⁶ Bundessozialgericht, https://www.bsg.bund.de/DE/Gericht/Rechtsprechung/rechtsprechung_node.html




III. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

I. БНСУ-ын шүүхийн тогтолцоо

БНСУ-ын Үндсэн хууль⁸⁷ (сол.헌법)-ийн 101 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх эрх мэдэл нь шүүгчдээс бүрдсэн шүүхэд хадгалагдана”, 2 дахь хэсэгт “Шүүх нь Дээд шүүх болон бусад бүх шатны шүүхээс бүрдэнэ” гэж тус тус заасан. Дээд шүүхийн болон бусад шүүхийн тогтолцоо, бүтцийг Шүүхийн бүтэц, зохион байгуулалтын тухай хууль (сол.법원조직법) (цаашид “ШБЗБтХ” гэх)-аар зохицуулдаг байна. Уг хуулийн дагуу шүүхийг Дээд шүүх, давж заалдах шүүх, патентын шүүх, орон нутгийн шүүх, гэр бүлийн шүүх, захиргааны хэргийн шүүх, дампуурлын шүүх⁸⁸ зэрэг 7 төрлийн шүүхэд ангилдаг.

Схем 3. БНСУ-ын шүүхийн тогтолцоо⁸⁹



Үндсэн хуулийн шүүх

БНСУ нь Үндсэн хуулийн шүүхтэй бөгөөд Үндсэн хуулийн 6 дугаар бүлэгт эрх зүйн үндсийг тусгажээ. БНСУ-ын Үндсэн хуулийн 111 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн шүүх нь нэгт: шүүхээс гаргасан хүсэлтийн дагуу хууль тогтоомж Үндсэн хууль зөрчиж буй

⁸⁷ БНСУ-ын Үндсэн хууль (대한민국헌법), <https://law.go.kr/%eb%b2%95%eb%a0%b9/%eb%8c%80%ed%95%9c%eb%af%bc%ea%b5%ad%ed%97%8c%eb%b2%95>.

⁸⁸ 법원조직법 제3조 1항, <https://law.go.kr/%eb%b2%95%eb%a0%b9/%eb%b2%95%ec%9b%90%ec%a1%b0%ec%a7%81%eb%b2%95>.

⁸⁹ БНСУ-ын цахим хуудас: <https://eng.scourt.go.kr/eng/judiciary/organization/courts.jsp>.



эсэх, хоёрт: импичментийн шүүх хурал, гуравт: улс төрийн намыг татан буулгах маргаан, дөрөвт: захиргааны байгууллага хоорондын, захиргааны байгууллага болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага хоорондын, орон нутгийн өөрөө удирдах байгууллага хоорондын эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой маргаан, тавт: хууль тогтоомжид Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэхээр заасан маргааныг харьяалан шийдвэрлэнэ.⁹⁰

Давж заалдах шатны шүүх

Давж заалдах шатны шүүх нь орон нутгийн шүүх, гэр бүлийн шүүх, дампуурлын шүүхийн 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэсэн маргаан болон захиргааны шүүхийн анхан шатны шийдвэр, тогтоол, захирамжид давж заалдах гомдол гаргасан маргааныг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэдэг.⁹¹

Төрөлжсөн шүүхэд патентын шүүх, гэр бүлийн шүүх, захиргааны хэргийн шүүх, дампуурлын шүүх хамаарна.

Патентын шүүх

Шүүхийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд 1998 оны 03 сарын 01-нд Патентын шүүхийг байгуулсан. Тус шүүх нь патентын урьдчилан шийдвэрлэх ажиллагааны шийдвэрт гаргасан гомдлыг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг бөгөөд тухайн шүүхийн шийдвэрийг эсэргүүцэн давж заалдах бол шууд Дээд шүүхэд хандахаар хуульчилсан. Ийнхүү патентын шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг 2 шатны шүүхийн тогтолцоогоор шийддэг байна.⁹²

Гэр бүлийн шүүх

Гэр бүлийн болон өсвөр насны хүүхдийг хамгаалахтай холбоотой маргааныг төрөлжин шийдвэрлэх зорилгоор гэр бүлийн шүүхийг анх 1963 оны 10 сарын 01-нд Сөүл хотод байгуулсан бөгөөд орон нутгийн шүүхтэй адил түвшний шүүх юм. Улмаар бусад аймаг, хотуудад энэ шүүхийг дагнан байгуулсан бөгөөд гэр бүлийн шүүхгүй нутаг дэвсгэрт орон нутгийн шүүх

⁹⁰ БНСУ-ын Үндсэн хууль, <https://law.go.kr/lsc.do?menuId=1&subMenuId=15&tabMenuId=81&qury=#undefined>

⁹¹ БНСУ-ын дээд шүүхийн цахим хуудас: <https://www.scourt.go.kr/judiciary/organization/high/index.html>, (Сүүлд үзсэн: 2024.11.27).

⁹² БНСУ-ын дээд шүүхийн цахим хуудас: <https://www.scourt.go.kr/judiciary/organization/specialized/index.html>, (Сүүлд үзсэн: 2024.11.27).



холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ.

Гэр бүлийн шүүх нь гэр бүлийн болон өсвөр насны хүүхдийн хамгааллын хэргүүдээс гадна 1998 оноос “Гэр бүлийн хүчирхийлэлд хариуцлага хүлээлгэх тусгайлсан хууль”-ийн хэрэгжилтийн дагуу гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргүүдийг шийддэг. Мөн 2011 оны 10 дугаар сараас эхлэн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид гэр бүлийн шүүхэд хүчирхийлэл үйлдсэн этгээдийг тусгаарлах хүсэлт гаргах боломжтой болж хохирогчийг хамгаалах тогтолцоо бүрдсэн. 2014 оны 09 сарын 29-өөс “Хүүхдийн хүчирхийлэлд хариуцлага хүлээлгэх тусгайлсан хууль”-ийн хэрэгжилтийн дагуу хүүхэд хамгаалалтай холбоотой хэргийг шийдвэрлэж, хохирогч хүүхдийг хамгаалах боломжтой болсон байна. Мөн 2013 оны 07 сарын 01-ээс өвчин эмгэг тусах, хөгжлийн бэрхшээлтэй болох, өндөр настай болох болон бусад шалтгаанаар сэтгэл санааны өөрчлөлтөд орсон хүмүүст илүү өргөн, уян хатан хамгаалалт үзүүлэх зорилгоор насанд хүрэгчдийг хамгаалах тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн.⁹³

Захиргааны хэргийн шүүх

Захиргааны шүүх нь 1998 оны 03 сарын 01-нд Сөүл хотод анх байгуулагдсан. Сөүл хот дахь захиргааны шүүх нь татвар, газар олголт, хөдөлмөр болон бусад захиргааны эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэдэг. Өмнө нь урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явагдсаны дараагаар шүүхэд нэхэмжлэл гаргах шаардлага тавигддаг байсан бол захиргааны хэргийн шүүх байгуулагдсанаар хуульд өөрөөр заагаагүй бол урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар гомдол гаргахгүйгээр шууд шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой болсон байна.⁹⁴

Дампуурлын шүүх

2017 оны 03 сарын 01-нд Өмнөд Солонгосын анхны дампуурлын шүүх Сөүлд байгуулагдсан бөгөөд 2023 оны 03 сарын 01-нд Сувон болон Пусан хотод байгуулагдсан. Дампуурлын шүүх байгуулагдаагүй орон нутгуудад дампууралтай холбоотой маргаануудыг тухайн орон нутгийн шүүх харьяалан шийдэх бөгөөд зөвхөн Чүнчон хотын орон нутгийн шүүхийн харьяа Канруны туслах шүүх нь хувь хүний дампууралтай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх эрхтэй. Дампуурлын шүүх нь

⁹³ БНСУ-ын дээд шүүхийн цахим хуудас, өмнөх эшлэл 92.

⁹⁴ БНСУ-ын дээд шүүхийн цахим хуудас, өмнөх эшлэл 92.



хуулийн этгээд, хувь хүнийг дахин хөрөнгөжүүлэх, дампуурсанд тооцох, хөрөнгөжүүлэх, гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй этгээдийг дампуурсанд тооцох болон тэдгээртэй холбоотой хэргүүдийг хянаж шийдвэрлэнэ.⁹⁵

Орон нутгийн шүүх

Орон нутгийн шүүх нь иргэн болон эрүүгийн хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэнэ. Анхан шатны шүүх хуралдааныг үндсэндээ шүүгч дангаар явуулах бөгөөд дараах төрлийн хэрэг маргааныг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

Иргэний хэрэгт: Нэхэмжлэлийн үнийн дүн 5 сая воноос давсан болон нэхэмжлэлийн үнийн дүнг тооцоолох боломжгүй маргаан орно. Гэхдээ чек, өрийн бичигт хамаарах мөнгөний нэхэмжлэл болон санхүүгийн байгууллагын зээлтэй холбоотой маргааныг нэхэмжлэлийн үнийн дүн хамаарахгүйгээр шүүгч дангаар хянан шийдвэрлэнэ.

Эрүүгийн хэрэгт: Цаазаар авах, бүх насаар хорих эсвэл 1 жилээс дээш хугацаагаар хорих эсвэл эд хөрөнгөтэй холбоотой маргаан орно. Харин чек хуурамчаар үйлдэх, давтан хүчирхийлэл үйлдэх, давтан хулгай хийх зэрэг гэмт хэргүүдийг шүүгч дангаар хянан шийдвэрлэнэ.

Мөн орон нутгийн шүүхийн бүтцэд салбар шүүх болон хот, тосгоны шүүхүүд багтах бөгөөд эдгээр шүүх нь иргэний хэрэгт нэхэмжлэлийн үнийн дүн 30 сая вон хүртэлх, эрүүгийн хэрэгт 200,000 вон хүртэлх торгууль эсвэл саатуулахтай холбоотой жижиг хэрэг маргааныг шүүгч дангаар шийдвэрлэдэг. Харин орон нутгийн шүүх нь бүрэлдэхүүнээр салбар шүүх эсвэл хот, тосгоны шүүхийн шүүгчийн дангаар гаргасан шийдвэр, тогтоол, зарлигт гаргасан гомдлыг давж заалдах журмаар хүлээн авч шийдвэрлэдэг байна.⁹⁶

БНСУ-ын Дээд шүүх нь ерөнхий шүүгчийг оролцуулаад 14⁹⁷ шүүгчтэй ба шүүгчид дундаас 1 шүүгчийг Дээд шүүхийн тамгын газрын даргаар ажиллуулах бөгөөд энэ үүргийг давхар гүйцэтгэж буй шүүгч нь шүүх хуралдаанд оролцдоггүй байна.

⁹⁵ БНСУ-ын дээд шүүхийн цахим хуудас, өмнөх эшлэл 92.

⁹⁶ БНСУ-ын дээд шүүхийн цахим хуудас: <https://www.scourt.go.kr/judiciary/organization/district/index.html>.

⁹⁷ *Supra* note 88, 법원조직법 제4조 2항.



БНСУ-ын Дээд шүүх нь шүүх тогтолцооны хамгийн дээд шатны шүүх болохын хувьд дараах давж заалдсан хэрэг маргааныг эцсийн байдлаар хянан шийдвэрлэнэ. Үүнд:⁹⁸

- Давж заалдах шатны шүүх болон патентын шүүхийн хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт гаргасан гомдол;
- Давж заалдах шатны шүүх болон патентын шүүхээс гаргасан дээрхээс бусад захирамж, тушаалтай холбогдуулан гаргасан гомдол;
- Бусад хууль тогтоомжоор Дээд шүүхээр шууд хянан шийдвэрлүүлэхээр заасан маргаан (Ерөнхийлөгч болон Үндэсний ассамблейн гишүүний сонгуулийн үр дүнтэй холбоотой маргаан)

Мөн зарим тохиолдолд БНСУ-ын Дээд шүүх нь дүрэм, журам, захирамж, тушаал, бүх шатны шүүхийн шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянах эрх хэмжээтэй байдаг тул Үндсэн хуулийн шүүхийн үүргийг гүйцэтгэдэг гэж үзэж болно.⁹⁹

II. Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

БНСУ-ын Дээд шүүх нь зохион байгуулалтын хувьд бүлгийн хурал буюу бага суудал, хамтын хурал буюу их суудлын хэмжээнд маргааныг хянан шийдвэрлэж байна. Үүнийг ШБЗБТХ-д “Дээд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь нийт шүүгчдийн 2/3-оос илүү гишүүнтэйгээр хамтын хурал /их суудал/-аар явагдах бөгөөд ерөнхий шүүгч хуралдааныг даргална” гэж хуульчилжээ. Хэдийгээр ШБЗБТХ-д нийт шүүгчдийн 2/3-оос илүү гишүүнтэйгээр хуралдана гэж хуульчилж өгсөн ч практик дээр Дээд шүүхийн нийт шүүгчид буюу 13 шүүгчийн бүрэлдэхүүнээр хамтын хурал буюу их суудлаар хэргийг хянан шийдвэрлэж байна.

Хяналтын журмаар хэрэг маргааныг хэлэлцэхдээ 3-аас илүү гишүүнтэй (одоогийн байдлаар бүлгийн хурал 4 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаж байна) бүлгийн хурал /бага суудал/-аар анхлан шийдвэрлэх бөгөөд бүлгийн бүх гишүүдийн санал нэгдвэл тухайн бүлгээс хэргийг хянан шийдвэрлэнэ.¹⁰⁰ Хэрэв бүлэг бүрэн санал нэгдэхгүй бол хамтын хурал (нийт шүүгчдийн 2/3)-аар хэргийг шийдвэрлэх бөгөөд энэ хурал дээр

⁹⁸ Supra note 88, 법원조직법 제14조.

⁹⁹ БНСУ-ын Дээд шүүхийн цахим хуудас: <https://www.scourt.go.kr/supreme/composition/duty/duty01/index.html>

¹⁰⁰ Supra note 88, 법원조직법 제 7조 1항.



олонхийн саналаар хэргийг эцэслэн шийдвэрлэж тусгай саналыг шүүхийн шийдвэрт тусгана

Харин доор дурдсан хэрэг маргааныг бүлгийн хурлаар хянан шийдвэрлэх боломжгүй, хамтын хурлаар (нийт шүүгчдийн 2/3) хянан шийдвэрлэнэ. Үүнд:


- Захирамж, дүрэм, журам Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн;
- Захирамж, дүрэм, журам хууль зөрчсөн гэж үзсэн;
- Дээд шүүхээс өмнө нь гаргасан Үндсэн хууль, хууль, дүрэм журам, захирамжид хийсэн тайлбартаа өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн;
- Бүлгийн хурлаар хянан шийдвэрлэх нь тохиромжгүй гэж үзсэн;
- Бүлгийн гишүүд санал нэгдээгүй зэрэг тохиолдлууд хамаарна.¹⁰¹

Хамтын хурлыг ерөнхий шүүгч даргалах бөгөөд хуралдаанд оролцсон нийт шүүгчдийн олонхын саналаар шийдвэр гаргадаг.

IV. ЯПОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Япон Улсын Үндсэн хууль¹⁰² (яп. 日本「憲法, цаашид “Японы ҮнХ” гэх)-ийн 76 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүх эрх мэдэл нь дээд шүүх болон хуулийн дагуу байгуулагдсан доод шатны шүүхээс бүрдэнэ гэж заасан бөгөөд тус улс нь 3 шатны шүүхийн тогтолцоотой.

Схем 4. Япон улсын шүүхийн тогтолцоо



¹⁰¹ Ibid.

¹⁰² Япон Улсын Үндсэн хууль, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/174>



Хялбар ажиллагааны шүүх

Хялбар ажиллагааны шүүх нь хөнгөн гэмт хэрэг болон 1,400,000 иенээс бага үнийн дүнтэй иргэний хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг. Хялбар ажиллагааны эрүүгийн хэрэгт холбогдох шийдвэрт гомдол гаргах тохиолдолд давж заалдах шатны шүүхэд гаргана. Харин иргэний хэрэгт холбогдох шийдвэрт гомдол гаргах тохиолдолд ердийн шүүхэд гомдол гаргаж, давж заалдах шатны шүүх хяналтын журмаар эцэслэн шийдвэрлэнэ. Түүнчлэн, бага үнийн дүнтэй хэргийг (600,000 иенээс бага) тусгайлсан журмаар хянан шийдвэрлэдэг. Хуульд зааснаар давж заалдах журмаар гомдол гаргах эрхгүй боловч татгалзал гаргах боломжтой.

Гэр бүлийн шүүх

Гэр бүлийн шүүхийн хувьд гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаан, насанд хүрээгүй этгээдийн холбогдсон эрүүгийн хэрэг, эсхүл насанд хүрээгүй этгээд гэмт хэрэгт холбогдох өндөр эрсдэлтэй байгаа нөхцөл байдлыг анхан шатын журмаар хянан шийдвэрлэдэг. Хялбар ажиллагааны шүүх болон гэр бүлийн шүүхэд харьяалагдахаас бусад хэргийг ердийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг.

Дээд шүүхийн бүтэц болон хүлээн авах гомдлын хүрээ

Япон Улсын дээд шүүхийг онолын шүүх гэж үздэг тул гомдлын хүрээг хуулиар хязгаарласан байдаг. Дээд шүүх нь нийт 15 шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд болон холбогдох нэгж, тасаг, албанаас бүрддэг.

Шүүхийн тухай хууль¹⁰³ (яп.裁判所法, цаашид “ШТХ” гэх)-ийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүгч нар нь их суудал (大法廷) болон 3 бага суудалд (小法廷) хуваагддаг. Их суудал нь нийт шүүгчдийн хурал байдаг бол бага суудал нь тус бүр 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй бөгөөд тэргүүнийг тухайн суудлын шүүгч нар дотроосоо сонгодог. Улсын дээд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам¹⁰⁴ (яп.最高裁判所裁判事務管理規則, цаашид “УДШХХШАЖ” гэх)-ын 3 дугаар зүйлд тухайн бага суудалд Ерөнхий шүүгч хуваарилагдсан тохиолдолд суудлын тэргүүн болно гэж заажээ. Жил бүрийн 12 дугаар

¹⁰³ Япон Улсын шүүхийн тухай хууль, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4150>

¹⁰⁴ Япон Улсын Дээд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, https://www.courts.go.jp/toukei_siryu/kisokusyuu/sonota_kisoku/sonota_kisoku_06/index.html



сард шүүгчдийн зөвлөгөөнөөр шүүгч нар дараа жил аль бага суудалд хуваарилагдах, сэлгэн ажиллах дарааллыг тогтоодог (УДШХХШАЖ-ийн 4 дүгээр зүйл).

Бага суудал нь эрүүгийн, иргэний, захиргааны гэж хуваагддаггүй. Дээд шүүх гомдлыг хүлээн авсны дараа шүүхийн цахим системээр хэргийг бага суудалд хуваарилах бөгөөд ихэнх нь бага суудлын хурлаар хянан шийдвэрлэгддэг¹⁰⁵. Бага суудлын 3-аас доошгүй тооны шүүгч оролцсон тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдана (УДШХХШАЖ-ийн 2 дугаар зүйл). Бага суудал хэргийг хянан хэлэлцээд дараах тохиолдолд хэргийг их суудал руу шилжүүлдэг (ШтХ-ийн 10 дугаар зүйл). Үүнд:

1. Талуудын аль нэг нь гомдол гаргасан тохиолдолд хууль, Засгийн газрын шийдвэр, журам эсхүл захиргааны акт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг тогтоох (Хууль, Засгийн газрын шийдвэр, журам эсхүл захиргааны акт Үндсэн хуульд нийцсэн гэж шийдсэн их суудлын шийдвэртэй адил агуулга бүхий санал хамаарахгүй)¹⁰⁶;
2. Өмнөхөөс бусад тохиолдолд хууль, Засгийн газрын шийдвэр, журам эсхүл захиргааны акт Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл;
3. Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн талаарх тайлбар нь Улсын дээд шүүхийн өмнөх шийдвэрийг зөрчсөн.

Түүнчлэн, ШтХ-ийн 10 дугаар зүйлд зааснаас гадна бага суудлаар хэрэг хянан шийдвэрлэх үед шүүгчдийн санал тэнцсэн тохиолдолд¹⁰⁷, эсхүл их суудлаар хянан шийдвэрлэх нь тохиромжтой гэж үзсэн тохиолдолд Ерөнхий шүүгчид мэдэгдэж, их суудлаар хянан шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ. Их суудлын хуралдаанд 9-өөс доошгүй тооны шүүгч оролцсон тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдана (УДШХХШАЖ-ийн 7 дугаар зүйл). Их суудлын хуралдааныг Ерөнхий шүүгч даргална. Үндсэн хууль зөрчсөн гэж үзэхийн тулд нийт шүүгчдийн 8-аас доошгүйн санал нэгдсэн байх шаардлагатай (УДШХХШАЖ-ийн 12 дугаар зүйл).

¹⁰⁵ 市川正人ほか『現代の裁判（第8版）』（有斐閣・2022年）68頁。

¹⁰⁶ Япон улсын дээд шүүх нь үндсэн хуулийн бодит хяналтыг хэрэгжүүлдэг.

¹⁰⁷ Жишээ нь 4 шүүгчийн санал хоёр хоёроор тэнцэх.

V. ЭСТОНИ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Эстони улсын шүүх эрх мэдэл нь Мужийн шүүх (англ. *Countrty court*), Захиргааны хэргийн шүүх (англ. *Administrative court*), Тойргийн шүүх (англ. *Circuit court*) болон Дээд шүүхээс (англ. *Supreme Court*) бүрддэг. Тус улсын шүүхийн систем нь 3 шатлалтай бөгөөд Мужийн шүүх, Хотын шүүх болон захиргааны шүүхүүд нь анхан шатны шүүх, Тойргийн шүүх нь давж заалдах шатны шүүх юм. Тус улсын шүүхийн тогтолцоог схемээр үзүүлбэл:

Схем 5. Эстони улсын шүүхийн тогтолцоо



Тойргийн шүүхүүд нь анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар хянан хэлэлцдэг бол Дээд шүүх нь бусад шүүхийн шийдвэрийг хянах эрхтэй. Мөн Эстони улсын Дээд шүүх нь Үндсэн хуулийн хяналтын үүргийг давхар гүйцэтгэдэг.¹⁰⁸ Эстони улсын Шүүхийн тухай хууль¹⁰⁹ (англ. *Courts act*)-ийн 25-р зүйлд зааснаар Дээд шүүх нь 19 шүүгчтэй. Мөн хуулийн 28-р зүйлд зааснаар Дээд шүүх нь Иргэний хэргийн танхим, Эрүүгийн хэргийн танхим, Захиргааны хэргийн танхим, Үндсэн хуулийн хяналтын танхимаас бүрддэг.

Үндсэн хуулийн хяналтын танхим нь 9, Иргэний хэргийн танхим 7, Эрүүгийн хэргийн танхим 6, Захиргааны хэргийн танхим 5 шүүгчээс тус тус бүрддэг. Эстони улсын Дээд шүүхийн 18 шүүгч иргэн, эрүү, захиргааны аль нэг танхимд харьяалагддаг¹¹⁰ ба тэдгээрээс 8 шүүгч, Ерөнхий шүүгчийн хамт Үндсэн хуулийн хяналтын танхимыг бүрдүүлдэг.

Харин хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний тухайд Дээд шүүх

¹⁰⁸ Эстони улсын Үндсэн хууль (1992)-ийн 12-р бүлэг, <https://www.riigiteataja.ee/en/eli/521052015001/consolide>

¹⁰⁹ “Estonian Court System”, Supreme court of Estonia, October 28, 2024, <https://www.riigikohus.ee/en/estonian-court-system#:~:text=Estonia's%20court%20system%20consists%20of,is%20prohibited%20by%20the%20Constitution.>

¹¹⁰ Supreme Court of Estonia, *The Supreme Court of Estonia*, (Ecoprint AS, 2019), 11 <https://www.riigikohus.ee/sites/default/files/Tr%C3%BCkis/2019-Riigikohus-brozuur-2019-ENG.pdf>



нь хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр, танхимаар, тусгай бүрэлдэхүүнээр, эсхүл нийт шүүгчийн хуралдаанаар хянан хэлэлцэнэ.¹¹¹ Иргэний процессын хууль¹¹² (англ. *Code of Civil Procedure*)-ийн 18-р зүйл, Эрүүгийн процессын хууль¹¹³ (англ. *Code of Criminal Procedure*)-ийн 354-р зүйл, Захиргааны процессын хууль¹¹⁴ (англ. *Code of Administrative Court Procedure*)-ийн 227 дугаар зүйлд зааснаар Дээд шүүх нь хэргийг хуульд өөрөөр заагаагүй бол танхимын 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэдэг.

3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэрэг хянан шийдвэрлэж буй бүрэлдэхүүн дотор хууль хэрэглэх, тайлбарлахтай холбоотой зарчмын зөрүүтэй санал гаргасан, хэрэг хянан шийдвэрлэж буй бүрэлдэхүүний олонх хууль хэрэглэх талаар танхимын байр суурийг өөрчлөхийг дэмжсэн, эсхүл шүүхийн практикт нэгдмэл байдлыг хангах үүднээс хэргийг танхимаар

¹¹¹ Ibid 6.

¹¹² Эстони улсын Иргэний процессын хууль, <https://www.riigiteataja.ee/en/eli/513122013001/consolide>

18 дугаар зүйл

- (1) Хуульд өөрөөр заагаагүй бол Дээд шүүх иргэний хэргийг дор хаяж гурваас доошгүй шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэнэ.
- (2) Дээд шүүхийн шүүх бүрэлдэхүүн хуулийг тайлбарлах, хэрэглэх талаар зарчмын зөрүүтэй санал гаргавал уг асуудлыг Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын бүрэлдэхүүнд шилжүүлнэ. Мөн Шүүхийн практикийг уялдуулах, хөгжүүлэхэд шаардлагатай эсхүл иргэний хэргийн танхимын хууль хэрэглээний одоогийн байр суурийг өөрчлөхийг хүсвэл шүүх бүрэлдэхүүн иргэний хэргийг Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын бүрэлдэхүүнд шилжүүлнэ.
- (3) Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын бүрэн бүрэлдэхүүний хуралдааныг Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын Ерөнхий шүүгч түүний эзгүйд албан тушаалд түрүүлж томилогдсоноор, адил хугацаанд томилогдсон бол ахмад настай гишүүн даргална.
- (4) Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын гишүүдийн гуравны хоёроос дээш нь оролцсон тохиолдолд Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын бүрэлдэхүүний хуралдааны ирц хүрсэнд тооцно.

¹¹³ Эстони улсын Эрүүгийн процессын хууль, <https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide>

354 дугаар зүйл

Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын гурван хүний бүрэлдэхүүнтэй шүүх бүрэлдэхүүнд хуулийг хэрэглэх талаар зарчмын зөрүүтэй санал гарсан, эсхүл өмнөх шүүхийн шийдвэрт Эрүүгийн хэргийн танхимаас баримталж байсан хуулийг хэрэглэх талаар байр суурийн өөрчлөх шаардлага гарсан бол Дээд шүүхийн зургаан шүүгчээс бүрдсэн Эрүүгийн хэргийн танхимын бүрэлдэхүүнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай тогтоолын үндсэн дээр шилжүүлнэ.

¹¹⁴ Эстони улсын Захиргааны процессын хууль, <https://www.riigiteataja.ee/en/eli/512122017007/consolide>

- (1) Захиргааны хэрэг хянан шийдвэрлэж буй бүрэлдэхүүний шүүгчийн саналаар дараах тохиолдолд тухайн хэргийг Захиргааны хэргийн танхимын бүрэн бүрэлдэхүүнээр хянан хэлэлцүүлэхээр шилжүүлнэ:
 - 1) Захиргааны хэргийн танхимын гурван гишүүний бүрэлдэхүүнд тухайн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан хуулийг хэрэглэхтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргасан;
 - 2) Шүүх бүрэлдэхүүний олонх нь хууль хэрэглэх талаар Захиргааны хэргийн танхимын байр суурийг өөрчлөхийг дэмжсэн, эсхүл шүүхийн практикийн нэгдмэл хандлагыг хангах үүднээс хянан хэлэлцэх шаардлагатай гэж үзсэн.



хянан хэлэлцэх шаардлагатай гэж үзсэн бол танхимаар хэлэлцүүлэхээр шилжүүлнэ. Иргэний процессын хуулийн 18 дугаар зүйлийн 4 дүгээр хэсэгт зааснаар Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын гишүүдийн гуравны хоёроос дээш нь оролцсон тохиолдолд Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын хурал хуралдана.

Цаашлаад, Иргэний процессын хуулийн 19-р зүйл, Захиргааны процессын хуулийн 226 дугаар зүйл, Эрүүгийн процессын хуулийн 354 дүгээр зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй Дээд шүүхийн танхимын бүрэлдэхүүний олонх хууль тайлбарлахдаа Дээд шүүхийн өөр танхим, Тусгай бүрэлдэхүүний (англ.*Special Panel*) хамгийн сүүлд гаргасан байр суурийг өөрчлөх шаардлагатай гэж үзвэл хэргийг тусгай бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ. Танхимуудын хооронд хууль хэрэглэх, тайлбарлахтай холбоотой зарчмын маргааныг Тусгай бүрэлдэхүүн шийдвэрлэдэг.

Иргэний процессын хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүгийн процессын хуулийн 355 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Захиргааны процессын хуулийн 227 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тус тус зааснаар Дээд шүүхийн тусгай бүрэлдэхүүн нь хууль хэрэглээний талаар өөр байр суурьтай байгаа танхимын 2 шүүгч, мөн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах танхимын 2 шүүгч болон Ерөнхий шүүгчээс бүрддэг. Түүнчлэн Захиргааны процессын хуулийн 227 дугаар зүйлийн 2-т зааснаар тусгай бүрэлдэхүүн 3 танхимаас бүрдэж болох бөгөөд ийм бүрэлдэхүүний хувьд Ерөнхий шүүгч болон танхим бүрийн 2 шүүгчээс буюу 7 шүүгчээс бүрдэнэ. Тусгай бүрэлдэхүүний шийдвэр олонхын саналд үндэслэнэ.

Иргэний процессын хуулийн 19 дүгээр зүйл, Эрүүгийн процессын хуулийн 355 дугаар зүйл, Захиргааны процессын хуулийн 228 дугаар зүйлд тус тус зааснаар дараах тохиолдолд хэргийг Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэргийг шийдвэрлэнэ:

- Танхимын бүрэлдэхүүний олонх хууль хэрэглээний талаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны өмнө баримталж байсан эрх зүйн зарчим, байр сууринаас өөр санал гаргасан;
- Танхимын бүрэлдэхүүний олонх нь уг асуудлыг Улсын дээд шүүх хянан шийдвэрлэх нь хууль хэрэглээний нэгдмэл байдалд чухал гэж үзсэн;
- Тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн нь Үндсэн хуулийн шүүхийн



процессын хуулийн дагуу шийдвэрлэх асуудал байж болзошгүй.

Түүнчлэн Шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 4 дүгээр хэсэгт зааснаар дор хаяж 11 шүүгч ирснээр нийт шүүгчийн хуралдаан хуралдах бөгөөд шийдвэрийг олонхын саналд үндэслэн гаргана. Санал тэнцүү хуваагдсан тохиолдолд Дээд шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэх санал өгнө. Мөн Иргэний процессын хуулийн 13-р зүйлд зааснаар Дээд шүүх нь хэргийн харьяаллыг тогтоодог байна.

VI. АВСТРИ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Бүгд Найрамдах Австри улс (цаашид “Австри улс” гэх)-д эрүү болон иргэний хэргийн дээд шатлал (англ. *The highest instance*) нь Дээд шүүх¹¹⁵ юм. Мөн захиргаа болон үндсэн хуулийн буюу нийтийн эрх зүйн асуудлаар эцсийн шийдвэр гаргадаг тусдаа 2 дээд шүүх байдаг.¹¹⁶

Дээд шүүх нь эрүү, иргэний давж заалдах гомдлыг хянан хэлэлцэхээс гадна хууль тогтоомжийн төсөл санаачлах явцад тогтмол дүгнэлт гаргадаг байна.¹¹⁷ Харин Захиргааны хэргийн дээд шүүх нь төлөвлөлтийн зөвшөөрөл, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, санхүү болон цагаачлалын асуудлыг шийдвэрлэдэг байна.¹¹⁸

Тус улсад ердийн харьяаллын шүүх нь нийтийн эрх зүйн шүүхийн харьяаллаас гадуурх бүх асуудлыг буюу иргэн, эрүү, өрсөлдөөний эрх зүйд холбогдох маргааныг шийдвэрлэдэг. Тухайлбал, иргэний хэрэг шүүхэд нэхэмжилсэн хэмжээ болон эрүүгийн хэргийн төрөл гэх мэт хүчин зүйлээс хамаарч тухайн хэргийг дүүргийн эсхүл мужийн шүүх тус тус шийдвэрлэдэг.¹¹⁹ Тодруулбал, дүүргийн шүүхийн хувьд 15,000 еврогоос доош үнийн дүнтэй нэхэмжлэл, гэр бүл, түрээс, торгох ялтай гэмт хэрэг болон 1 жилээс дээшгүй хугацаагаар хорих ял шийтгэх гэмт хэргийг шийдвэрлэдэг.¹²⁰ Харин мужийн шүүх нь дүүргийн шүүхэд

¹¹⁵ Холбооны Үндсэн хууль - The Federal Constitutional law of 1920. Art 92(1).

¹¹⁶ “Position and Function,” The Supreme Court of Justice of the Republic of Austria, November 6, <https://www.ogh.gv.at/en/the-supreme-court-of-justice/position-and-functions/>.

¹¹⁷ Ibid.

¹¹⁸ “The Supreme Administrative Court,” Verwaltungsgerichtshof, November 6, <https://www.vwgh.gv.at/english.html>.


¹¹⁹ Helmut Weichsel, “A Brief Overview of the Austrian Legal Information System and Laws”, *GlobaLex*, (August 2021), <https://www.nyulawglobal.org/globalex/austria1.html>.

¹²⁰ “National ordinary courts,” The European e-Justice portal, November 27, https://e-justice.europa.eu/content_ordinary_courts-18-at-en.do?member=1.

харьяалуулснаас бусад төрлийн маргааныг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.¹²¹

Шүүхийн тогтолцооны нэг салбар болох Үндсэн хуулийн шүүх нь ердийн харьяалал эсхүл захиргааны эрх бүхий байгууллага шийдвэрлэх боломжгүй холбооны засгийн газар, муж улс, хотын захиргаанд холбогдох маргааныг хүлээн авч шийдвэрлэдэг.¹²² Тус шүүхийн үндсэн зорилго нь иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах болон хууль тогтоомж Австри улсын Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах явдал юм.¹²³

Схем 6. Австри улсын шүүхийн тогтолцоо¹²⁴



Дээд шүүх нь 60 шүүгчтэй бөгөөд тэргүүн (англ. *President*), 2 дэд тэргүүн (англ. *Vice Presidents*) болон 57 шүүгчээс бүрддэг.¹²⁵ Дээд шүүхийн

¹²¹ Ibid.

¹²² Холбооны Үндсэн хууль - The Federal Constitutional law of (1920) Art. 137.

¹²³ *Supra* note 119.

¹²⁴ "Internal organization of the ordinary courts competent to review administrative acts," Association of the Councils of State and Supreme Administrative, October 21, 2024, <https://www.aca-europe.eu/index.php/en/tour-d-europe-en?page=detail&countryid=3>.

¹²⁵ "The Supreme Court of Justice," The Supreme Court of Justice of the Republic of Austria, October 22, <https://www.ogh.gv.at/en/the-supreme-court-of-justice/>.



шүүгчдийг Хууль зүйн сайдаас нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч насан туршид нь томилдог¹²⁶ байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд өөрөөр заагаагүй бол 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй явуулдаг ба нэг шүүгч даргалж, нэг шүүгч илтгэдэг.¹²⁷ Харин тодорхой төрлийн маргааны харьяалал шийдвэрлэх, өршөөл үзүүлэх зэрэг тохиолдолд 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шүүх хуралд оролцдог.¹²⁸ Мөн Дээд шүүхийн тогтоосон практикаас өөрөөр шийдвэрлэх эсхүл нэгдмэл ойлголт шинээр бий болгох хэргийг шийдвэрлэхдээ 11 шүүгч оролцдог байна.¹²⁹

Захиргааны хэргийн дээд шүүх нь 70 шүүгчтэй бөгөөд тэргүүн, дэд тэргүүн болон 68 шүүгчээс бүрддэг.¹³⁰ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ихэвчлэн 5 шүүгч оролцох ба захиргааны зөрчил (Гер. *Verwaltungsstrafsachen*)-д холбогдох хэрэгт 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй оролцдог байна.¹³¹

Дээрхээс үзвэл, Австри улсын дээд шүүх хэргийг шийдвэрлэхдээ нийт шүүгчдээр оролцдоггүй байх ба нийтлэг тохиолдолд 5, хуульд заасан зарим тохиолдолд 3 болон 11 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг шийдвэрлэдэг байна. Мөн шүүгчдийг нэрс болон хариуцсан үүргийн дагуу жагсааж хэрэг хуваарилах үүргийг тус шүүхийн тэргүүнүүд хүлээдэг байна.

¹²⁶ Парламентийн судалгааны хүрээлэн, *Парламент (судалгааны эмхэтгэл)*, 2021, 476 дахь тал.

¹²⁷ Дээд шүүхийн тухай хууль (1968) - Gesamte Rechtsvorschrift für Oberster Gerichtshof, § 6.

¹²⁸ Дээд шүүхийн тухай хууль (1968) - GROG, § 7, Satz 1.

¹²⁹ Дээд шүүхийн тухай хууль (1968) - GROG, § 8, Satz 1.

¹³⁰ *Supra note 118*.

¹³¹ Захиргааны шүүхийн тухай хууль (1985) - Gesamte Rechtsvorschrift für Verwaltungsgerichtshofgesetz, §11 (1).



ХОЁР. АНГЛО-САКСОНЫ ЭРХ ЗҮЙН БҮЛД ХАМААРАХ УЛСУУД

I. АВСТРАЛИ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Австрали улсын шүүхийн тогтолцоо нь холбооны шүүх болон мужийн шүүх гэсэн үндсэн 2 бүтэцтэй. Холбооны шүүхийн бүтэц нь Хамтын нөхөрлөлийн хууль тогтоомжоор харьяалуулсан холбооны тойргийн шүүх болон холбооны шүүхээс бүрдэх бол мужийн шүүх нь өөрийн мужийн хуулиар зохицуулагдах шүүхийн тогтолцоотой. Холбооны тойргийн шүүх нь худалдааны эрх зүйн маргаан, захиргааны эрх зүйн маргаан, гэр бүлийн маргаан, хүний эрх, дампууралтай холбоотой маргааныг харьяалан шийдвэрлэдэг байна. Холбооны шүүх нь эдгээр маргааныг давж заалдах шатны журмаар хянадаг бол иргэний хэргийн хувьд дээд шатны шүүхийн журмаар шийдвэрлэдэг. Харин мужийн шүүхийн хувьд муж бүр дээд шүүхтэй бөгөөд эрүү болон иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг. Австрали улсын ихэнх мужийн шүүхийн шатлал нь орон нутгийн буюу магистратын шүүх, дүүргийн буюу мужийн шүүх болон мужийн дээд шүүхээс бүрддэг байна. Мужийн дээд шүүх нь иргэний хэрэг маргааныг давж заалдах шатны журмаар хэлэлцэх, улсын дээд шүүх рүү гаргасан гомдлыг хянан хэлэлцэх, эрүүгийн онц ноцтой гэмт хэргийг хэлэлцэх зэрэг үүргийг хүлээдэг.¹³² Хэрэв муж улсын шүүх аливаа хэрэг маргааныг шийдвэрлэх шүүхийн практик, хууль тогтоомж дотоодын хэмжээнд байхгүй бол ойролцоох нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс орнууд болох Англи, Уэльс, Канад, Америк, Шинэ Зеланд зэрэг улсын шүүхийн практикийг харгалзан үздэг байна.¹³³

Австрали улсын Дээд шүүх (англ. *The High court*) нь эцсийн шийдвэрийг гаргах эрх бүхий дээд шатлалын шүүх бөгөөд Үндсэн хууль болон бусад хуулийг тайлбарлах, хэрэглэхтэй холбоотой маргаан, холбооны шүүхэд давж заалдах журмаар гаргасан онцгой ач холбогдол бүхий хэргийг шийдвэрлэх болон иргэн, эрүүгийн хэргийг эцсийн байдлаар хянан шийдвэрлэдэг.¹³⁴

¹³² “Overview of Australia’s Court system,” McCullough Robertson Lawyers, October 8, 2024, <https://www.mccullough.com.au/2020/08/21/overview-of-australias-court-system/>.

¹³³ “Court system in Western Australia,” Supreme Court of Western Australia, October 8, 2024, https://www.supremecourt.wa.gov.au/C/court_system_in_western_australia.aspx.


¹³⁴ “Court system in Western Australia,” Supreme Court of Western Australia, October 8, 2024, https://www.supremecourt.wa.gov.au/C/court_system_in_western_australia.aspx.



Тус улсын Дээд шүүх нь Ерөнхий шүүгч болон бусад зургаан шүүгч буюу нийт 7 шүүгчийн бүрэлдэхүүнтэй бөгөөд Ерөнхий шүүгч¹³⁵ болон шүүгчдийг Ерөнхий амбан захирагч (англ. *Governor-General*) томилдог¹³⁶ байна.

Үндсэн хуулийг тайлбарлах, хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн аль нэг хэсгийг өөрчлөх болон хуулийн зарчмыг тайлбарлах нь олон нийтэд ач холбогдолтой гэж үзсэн хэрэг маргааныг улсын Дээд шүүх бүрэн бүрэлдэхүүнээрээ буюу 7 шүүгчтэйгээр шийдвэрлэдэг. Харин мужийн Дээд шүүх, холбооны шүүх, гэр бүлийн шүүхийн шийдвэрийг давж заалдсан гомдлыг улсын Дээд шүүх хоёроос доошгүй шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр эцэслэн шийдвэрлэдэг байна. Зарим төрлийн хэрэг маргааныг 1 шүүгч дангаараа шийдвэрлэх тохиолдол ч мөн байдаг байна. Шийдвэрийг шүүгч тус бүр хувьдаа гаргах бөгөөд санал зөрсөн тохиолдолд олонхын саналаар шийддэг.¹³⁷

Схем 7. Австрали улсын шүүхийн тогтолцоо¹³⁸



¹³⁵ “About the Justices,” High Court of Australia, October 8, 2024, <https://www.hcourt.gov.au/justices/about-the-justices>.

¹³⁶ High Court of Australia Act (1979), art. 5.

¹³⁷ “Operation of the High Court,” High Court of Australia, October 8, 2024, <https://www.hcourt.gov.au/about/operation>.

¹³⁸ *Ibid*



Шүүхийн харьяаллын асуудлыг Шүүхийн хууль¹³⁹ (англ. *Judiciary act*), Австралийн Дээд шүүхийн хууль¹⁴⁰ (англ. *High Court of Australia Act*), Австралийн холбооны шүүхийн хууль¹⁴¹ (англ. *Federal Court of Australia Act*), Дээд шүүхийн хууль¹⁴² (англ. *Supreme Court Act*) зэргээр дэлгэрэнгүй зохицуулдаг. Дээд шүүхийн хуулийн 2-р бүлгийн 5-д “Мужийн Дээд шүүх нь хуульд үндэслэн үүссэн аливаа маргаан, асуудлыг хянан, шийдвэрлэнэ”¹⁴³ гэж зааснаас үзвэл Австрали улсад хэргийн харьяалалтай холбоотой маргаан гардаггүй гэж үзэж болох ба Мужийн Дээд шүүх нь хэргийн харьяалал харгалзалгүй шийдвэрлэдэг байна.

II. ШИНЭ ЗЕЛАНД УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Шинэ Зеланд улсын шүүх эрх мэдэл нь Дүүргийн шүүх (англ. *District court*), Ерөнхий шүүх¹⁴⁴ (англ. *High court*), Давж заалдах шүүх (англ. *Court of Appeal*) болон Дээд шүүхээс (англ. *Supreme court*) бүрддэг.¹⁴⁵ Тус улсын шүүхийн систем нь 4 шатлалтай бөгөөд Дүүргийн шүүх нь анхан шатны шүүх бол Ерөнхий шүүх нь дүүргийн шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар хэлэлцэхээс гадна зарим хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцдэг. Шинэ Зеланд улсын шүүхийн тогтолцоог схемээр үзүүлбэл¹⁴⁶:

¹³⁹ Judiciary Act (1903).

¹⁴⁰ High Court of Australia Act (1979).

¹⁴¹ Federal Court of Australia Act (1976).

¹⁴² Supreme Court Act (1960).

¹⁴³ Supreme Court Act (1960), art 5(2) “to hear and determine all causes and matters arising under any law”.


¹⁴⁴ High court гэх энэхүү шүүх нь Шинэ Зеланд улсын Дээд шүүхийн цахим хуудаст бичсэнээр 350000 доллароос дээш үнийн дүнтэй иргэн болон эрүүгийн ноцтой хэргүүдийг хянан хэлэлцдэг бөгөөд дүүргийн шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар хянан хэлэлцдэг. Тус шүүхийг судлаачийн зүгээс Ерөнхий шүүх гэж орчууллаа. <https://www.courtsofnz.govt.nz/about-the-judiciary/structure-of-the-court-system/>

¹⁴⁵ *Ibid.*

¹⁴⁶ *Ibid.*



Схем 8. Шинэ Зеланд улсын шүүхийн тогтолцоо



Дээд шатны шүүхүүдийн тухай хуулийн 11-р зүйлийн (b)-д зааснаар Ерөнхий шүүх нь хэргийн харьяаллыг тогтоодог. Түүнчлэн Дээд шатны шүүхүүдийн тухай хууль¹⁴⁷ (англ. *Senior courts*¹⁴⁸ act)-ийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгчээс гадна 4-өөс багагүй 5-аас ихгүй шүүгчтэй байна. Тус хуулийн 81 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн 5 шүүгчээс бүрддэг бөгөөд Дээд шүүх бүх хэргийг 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэдэг.¹⁴⁹ Мөн хуулийн 85 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүхийн шийдвэрийг олонхын саналд үндэслэж гаргадаг. Нэмж дурдахад, Дээд шатны шүүхүүдийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар Шинэ Зеланд улсад Орлогч шүүгч (англ. *Acting judges*) гэх албан тушаалтан байдаг. Тус албан тушаалтан нь Улсын дээд шүүхэд сул орон тоо байгаа, тодорхой процесс эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч оролцох боломжгүй тохиолдолд Ерөнхий шүүгч эрх олгосны дагуу Дээд шүүхийн шүүгчийг орлоно. Өөрөөр хэлбэл, орлогч шүүгч нь Улсын дээд шүүхийн шүүгч үүргээ гүйцэтгэх боломжгүй үед шүүх бүрэлдэхүүнд ордог¹⁵⁰. Дээд шатны

¹⁴⁷ Шинэ Зеланд улсын Дээд шатны шүүхүүдийн тухай хууль, <https://www.legislation.govt.nz/act/public/2016/0048/latest/whole.html#DLM5759421>

¹⁴⁸ Шинэ Зеланд улсад Улсын дээд шүүх, Давж заалдах шүүх, Ерөнхий шүүхийг хамтад нь Senior courts гэж нэрлэдэг бөгөөд Senior courts гэх нэр томъёог судлаачийн зүгээс Дээд шатны шүүхүүд гэж орчууллаа.

¹⁴⁹ Office of the Chief Justice, “Chief Justice’s 2023 Annual Report”, October 28, 2024, <https://www.courtsofnz.govt.nz/assets/7-Publications/2-Reports/20240827-Chief-Justices-Annual-Report-2023.pdf>

¹⁵⁰ Ibid



шүүхүүдийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар орлогч шүүгч нь 75 наснаас доош, Дээд шүүхийн тэтгэвэрт гарсан шүүгч байх бөгөөд Ерөнхий шүүгч орлогч шүүгчийг тогтоосон хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эсхүл тодорхой нэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх олгодог.

Түүнчлэн Дээд шүүхүүдийн Билл¹⁵¹ (англ. *Senior courts Bill*)-ийн 74 дүгээр зүйлийн 2-т зааснаар Дээд шүүх хяналтын журмаар гаргасан гомдлыг олон нийтэд ач холбогдолтой, эдийн засгийн өргөн ач холбогдолтой, процессын ноцтой алдаа үүссэн байж болзошгүй эсхүл хяналтын журмаар гаргасан гомдлыг хэлэлцээгүй тохиолдолд хууль хэрэглээний ноцтой алдаа үүсэх гэсэн үндэслэлээр тус тус хянан хэлэлцдэг байна. Өсвөр насныхны шүүх нь хүнийг алах болон авто тээврийн гэмт хэргээс бусад гэмт хэрэгт холбогдсон өсвөр насныхны хэргийг хянан шийдвэрлэдэг.¹⁵² Харин байгаль орчны шүүх нь Байгаль орчны шүүхийн албан ёсны цахим хуудаст бичсэнээр хүрээлэн буй орчны эрх зүйтэй холбоотой болон бусад хэргийг хянан шийдвэрлэдэг¹⁵³ бол Хөдөлмөрийн шүүх нь хөдөлмөрийн гэрээтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэдэг.¹⁵⁴ Түүнчлэн Цэргийн шүүх нь Шинэ Зеландын Зэвсэгт хүчний үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, сахилга бат, үр ашиг, ёс суртахууныг хадгалахад хувь нэмэр оруулах зорилготой¹⁵⁵ бөгөөд цэргийн шүүхийн тухай хуульд (англ. *Court martial act*)¹⁵⁶ заасан гэмт хэргийг хянан шийдвэрлэдэг. Мөн хуулийн 1-р хавсралтад зааснаар тус шүүхийн хянан шийдвэрлэх гэмт хэрэгт дайсанд туслах, дайсанд туслах зорилгоор мэдээлэл өгөх болон бусад гэмт хэргүүд хамаарч байна. Нэмж дурдахад Маорын газрын шүүх нь дэлхий дээрх цор ганц газрын шүүх бөгөөд тус шүүхийн зорилго нь Маорын газрыг өмчлөх, ашиглахтай холбоотой асуудлыг шийдвэрлэдэг байна.¹⁵⁷

¹⁵¹ Дээд шатны шүүхүүдийн Билл (2003). https://www.legislation.govt.nz/bill/government/2013/0178a/latest/whole.html?search=sw_096be8ed813cea92_repeal_25_se&p=1#DLM5759412

¹⁵² “About the Youth Court” District court of New Zeland, November 27, 2024 https://www.districtcourts.govt.nz/youth-court/about-the-youth-court/#What_YC_does

¹⁵³ “Environment court” Environment court of New Zeland, November 27, 2024 <https://www.environmentcourt.govt.nz/>

¹⁵⁴ “About Employment court” Employment cour of New Zeland, November 27, 2024 <https://www.employmentcourt.govt.nz/about/>

¹⁵⁵ “Annual report on the military justice system”, Defence legal service, November 27, 2024, https://www.nzdf.mil.nz/assets/Uploads/DocumentLibrary/Discipline-Report_2021-2022.pdf

¹⁵⁶ Цэргийн шүүхийн тухай хууль, <https://www.legislation.govt.nz/act/public/2007/0101/latest/whole.html#DLM1001934>

¹⁵⁷ “The Maory land court” Community law, November 27, 2024 <https://communitylaw.org.nz/community-law-manual/chapter-2-maori-land/the-maori-land-court/>



III. ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Эрх зүйн тогтолцоогоо дагаад Их Британи улс нь гурван өөр шүүхийн тогтолцоотой бөгөөд Англи болон Уэльсийн шүүхийн тогтолцоо, Умар Ирландын шүүхийн тогтолцоо, Шотландын шүүхийн тогтолцоо гэж хуваагддаг. Эдгээр гурван шүүхийн тогтолцооны дээд шатны эцсийн шийдвэр гаргах эрхтэй шүүх нь Их Британи улсын Дээд шүүх (англ. *The Supreme Court of the United Kingdom*) байна. Англи, Уэльс, Умард Ирландын шүүхийн тогтолцооны хувьд эрүүгийн хэргийг магистратын шүүх (англ. *Magistrates Court*) анхан шатны журмаар шийдвэрлэдэг бол, илүү ноцтой хэрэг маргааны хааны шүүх (англ. *Crown Court*) анхан шатны журмаар шийдвэрлэдэг.

Иргэний хэргийг дүүргийн шүүх (англ. *County Court*) анхан шатны журмаар шийдвэрлэдэг бол, Хөдөлмөрийн маргаантай холбоотой хэргийг трибунал (англ. *Tribunals*) анхан шатны шийдвэрлэдэг. Харин дээрх хэргийг давж заалдах шатны журмаар Англи, Уэльс, Умард Ирландын дээд шүүх (англ. *England, Wales and Northern Ireland High Court*), дараа нь Англи, Уэльс, Умард Ирландын давж заалдах шатны шүүх (англ. *England, Wales and Northern Ireland Court of Appeal*) хянан шийдвэрлэдэг байна. Шотландын шүүхийн тогтолцооны хувьд эрүүгийн хэргийг шударга ёсны шүүх (англ. *Justice of the Peace Court*) болон шериф шүүх (англ. *Sheriff Court*) анхан шатны журмаар шийдвэрлэдэг бол, давж заалдах шатны журмаар шерифийн давж заалдах шатны шүүх (англ. *Sheriff Appeal Court*) шийдвэрлэдэг. Эрүүгийн хэргийн эцсийн шийдвэрийг шударга ёсны дээд шүүх (англ. *High Court of Justiciary*) гаргадаг. Иргэний хэргийг анхан шатны журмаар трибунал (англ. *Tribunals*) болон шериф шүүх шийдвэрлэдэг. Гэр бүлийн хэргийг шериф шүүх анхан шатны журмаар шийдвэрлэдэг байна. Иргэн болон гэр бүлийн хэрэг маргааныг давж заалдах шатны журмаар шерифийн давж заалдах шатны шүүх, дараа нь шүүгчдийн хуралдаан (англ. *Court of Session*) хянан шийдвэрлэдэг.¹⁵⁸


Тус улсын Дээд шүүх нь Ерөнхий шүүгч болон дэд тэргүүнийг оруулаад нийт 12 шүүгчтэй. Дээд шүүхийн дүрмийн 3 болон 9-д тус тус зааснаар аман сонсголыг нэг шүүгч дангаар шийдвэрлэж болох бөгөөд хэргийн

¹⁵⁸ “Structure of the Courts and Tribunals system,” Courts and Tribunals Judiciary, October 9, 2024, <https://www.judiciary.uk/about-the-judiciary/our-justice-system/court-structure/>.



ээдрээтэй байдлаас хамааран аливаа хэрэг маргааныг 3-аас доошгүй шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэдэг байна.¹⁵⁹ Хэлэлцэх хэрэг маргааны жагсаалт болон шүүх бүрэлдэхүүнийг дээд шүүхийн Ерөнхий шүүгч томилдог. Тухайн шүүх бүрэлдэхүүнийг Ерөнхий шүүгч эсхүл дэд тэргүүн даргалан оролцдог.¹⁶⁰

Схем 9. Их Британи улсын шүүхийн тогтолцоо¹⁶¹



- Их Британи улсын Дээд шүүх нь дараах хэрэг маргааныг эцсийн байдлаар хянан хэлэлцдэг. Үүнд:
- Нэгдсэн Их Британи улсын хэмжээнд бүх иргэний хэрэг, Англи,

¹⁵⁹ The Supreme Court Rules (2019), art. 3(3), 9(3).

¹⁶⁰ “Selection Commission Information Pack,” The Supreme Court of the United Kingdom, October 22, https://www.supremecourt.uk/docs/information_pack_president.pdf.

¹⁶¹ The Supreme Court and the United Kingdom’s legal system, October 9, 2024, <https://www.supremecourt.uk/about/uk-judicial-system.html>



Уэльс, Умард Ирланд зэрэг улсын хувьд эрүүгийн хэрэг зэргийг давж заалдах гомдол;

- Үндсэн хууль болон олон нийтэд ач холбогдол бүхий хэрэг маргаан;
- Нийтлэг эрх зүйн (англ. *common law*) ач холбогдол бүхий асуудлаар давж заалдсан гомдол хамаарна.¹⁶²

IV. КАНАД УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Канад улсын Дээд шүүхийн цахим хуудаст шүүх нь “үндсэн хууль, захиргаа, эрүү, иргэн” зэрэг бүх салбар эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх эрхтэй гэж дурдсан байна.¹⁶³

Канад улсын шүүхийн тогтолцоо нь олон хэсгээс бүрддэг ба дээд шүүх бүх тогтолцоог тэргүүлдэг.¹⁶⁴ Тус улсын шүүхийн тогтолцоог бүс нутгийн болон холбооны гэж хуваах боломжтой байна:

- Бүс нутгийн шүүхийн тогтолцоо: доод шатлал болох Бүс нутгийн шүүх нь бага хэмжээ бүхий үнийн дүнтэй иргэний хэрэг, өргөн хүрээний эрүүгийн хэрэг, гэр бүлийн эрх зүйн зарим маргааныг хянан шийдвэрлэдэг бол Бүс нутгийн дээд шүүх нь их хэмжээний үнийн дүн бүхий иргэний хэрэг, гэр бүл салалт зэрэг ноцтой (англ. *serious*) хэргүүдийг шийдвэрлэдэг байна. Харин бүс нутгийн давж заалдах шатны шүүх нь дээр дурдсан шүүхүүдийн шийдвэрт холбогдох давж заалдах гомдлыг хянан хэлэлцдэг.¹⁶⁵
- Холбооны шүүхийн тогтолцоо: Холбооны шүүх нь засгийн газрын эсрэг гаргасан нэхэмжлэл, холбооны нутаг дэвсгэр дэх иргэний хэрэг, зарим холбооны шүүхийн шийдвэрийг хянах зэрэг маргааныг шийдвэрлэдэг ба Холбооны давж заалдах шатны шүүх нь Холбооны шүүх болон Татварын шүүхийн шийдвэрт холбогдох давж заалдах гомдлыг хянан хэлэлцдэг байна.¹⁶⁶


¹⁶² “Role of The Supreme Court,” The Supreme Court of the United Kingdom, October 22, <https://www.supremecourt.uk/about/role-of-the-supreme-court.html>.

¹⁶³ “Canadian Judicial System,” Supreme court of Canada, October 28, <https://www.scc-csc.ca/court-court/sys-eng.aspx>.

¹⁶⁴ “Canada’s Court system,” Department of Justice Canada, November 27, 2024, <https://www.justice.gc.ca/eng/csj-sjc/ccs-ajc/01.html>.

¹⁶⁵ Ibid.

¹⁶⁶ *Supra* note 213.

Схем 10. Канад Улсын шүүхийн тогтолцоо¹⁶⁷

Канад улсын Дээд шүүх нь ерөнхий шүүгч болон 8 шүүгч, нийт 9 шүүгчээс бүрдэх ба шүүгчийг Үндэсний танхим (англ. *The Governor in Council*) санал болгосны дагуу Ерөнхий захирагч (англ. *The Great Seal*) томилдог¹⁶⁸. Тус шүүхийн дурын 5 шүүгч оролцсоноор шүүх хуралдааныг явуулах боломжит ирц бүрдэх¹⁶⁹ ба Дээд шүүх хяналтын гомдлыг шийдвэрлэх зорилгоор жилд 3 удаа чуулган хэлбэрээр хуралддаг¹⁷⁰.

Тус улсад шүүхэд шийдвэрлэх хэргийн харьяаллыг хууль болон журмаар зохицуулах харилцаа түгээмэл ажиглагдаж байгаа боловч хэргийн харьяалалтай холбогдож үүссэн маргааныг шийдвэрлэх харилцааг зохицуулсан зохицуулалт байхгүй байна.

¹⁶⁷ "The judicial structure," Department of Justice Canada, October 24, 2024, <https://www.justice.gc.ca/eng/csj-sjc/just/07.html>.

¹⁶⁸ Дээд шүүхийн тухай хууль - Supreme court act (1985), art 4(2).

¹⁶⁹ Дээд шүүхийн тухай хууль - Supreme court act (1985), art 25.

¹⁷⁰ Дээд шүүхийн тухай хууль - Supreme court act (1985), art 32(1).



V. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Америкийн Нэгдсэн Улс (цаашид “АНУ” гэх)-ын шүүхийн тогтолцоо нь холбооны шүүхийн тогтолцоо болон муж улсын шүүхийн тогтолцоо гэж үндсэндээ 2 хуваагддаг боловч холбооны улс учраас муж улс бүр өөрийн гэсэн шүүхийн тогтолцоотой. АНУ-ын Үндсэн хууль (англ. Constitution of the United States)-ийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нэгдсэн улсын шүүх эрх мэдлийг хууль ёсны дээд шүүхэд болон үе үеийн конгрессын шийдвэрээр байгуулсан доод шатны шүүхэд хадгална” гэж заажээ.¹⁷¹

Холбооны шүүхийн тогтолцоо нь үндсэн 3 шатлалтай. Анхан шатны шүүх буюу холбооны дүүргийн шүүх (англ. *district court*), давж заалдах шатны шүүх буюу холбооны тойргийн шүүх (англ. *circuit court*), эцсийн шатны шүүх буюу АНУ-ын дээд шүүх (англ. *The Supreme court of the United States*) юм. Улсын хэмжээнд 94 холбооны дүүргийн шүүх, 13 холбооны тойргийн шүүх, 1 Улсын дээд шүүх байдаг.

Холбооны дүүргийн шүүх нь зөвхөн холбооны хуулиар харьяалуулсан иргэний болон эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэдэг бөгөөд дүүрэг тус бүрт татварын, дампуурлын, цагаачлалын, холбооны Засгийн газрын эсрэг, олон улсын худалдааны зэрэг дагнасан шүүхтэй. Үүнийг хязгаарлагдмал хэргийн харьяалал (англ. *limited jurisdiction*)¹⁷² бүхий шүүх гэдэг. Холбооны тойргийн шүүх нь холбооны дүүргийн шүүхийн шийдвэрт давж заалдсан гомдлыг авч хэлэлцдэг. Үүнээс гадна зэвсэгт хүчний хэрэг маргаантай холбоотой асуудлыг давж заалдах гомдлоор авч хэлэлцдэг.

Холбооны шүүх нь Үндсэн хуулийн маргаан, холбооны хуулиар зохицуулсан гэмт хэргийн маргаан, улс хоорондын худалдааны маргаан, цагаачлалын хэрэг маргааныг хүлээн авч хянан шийдвэрлэдэг. Хуулиар зарим тохиолдолд холбооны шүүхийн харьяалал нь муж улсын шүүхийн харьяалалтай давхцдаг. Энэ тохиолдолд:

- Нэхэмжлэгч нэхэмжлэлээ анхан шатны журмаар холбооны шүүх, эсхүл муж улсын шүүхийн алинд нь гаргахаа өөрөө шийддэг. Үүнийг шүүхийн анхдагч харьяалал (англ. *original jurisdiction*) гэдэг.

¹⁷¹ Constitution of the United States (1787), art. 3(1) “The judicial Power of the United States, shall be vested in one supreme Court, and in such inferior Courts as the Congress may from time to time ordain and establish”.

¹⁷² “Limited jurisdiction”, Legal Information Institute, https://www.law.cornell.edu/wex/limited_jurisdiction, (Сүүлд үзсэн: 2024.11.20).



- Хариуцагч нь өөр мужид байгаа тохиолдолд муж улсын хуулиар харьяалагдах хэргийн нэхэмжлэлийг холбооны шүүхэд гаргаж болно. Үүнийг шүүхийн олон талт харьяалал (англ. *diversity jurisdiction*) гэдэг. Гэхдээ хэрэг маргаанд олон хариуцагч татагдсан тохиолдолд бүгд нэхэмжлэгчээс өөр муж улсын харьяалалтай байх, мөн нэхэмжилж буй мөнгөн дүн 75,000 доллароос дээш байхыг шаарддаг. Эрүүгийн хэргийн хувьд шүүхийн олон талт харьяалал үйлчилдэггүй.¹⁷³

Муж улсын шүүхийн тогтолцооны хувьд ихэнх нь холбооны шүүхийн тогтолцоотой адил буюу 3 шатлалтай боловч 2 болон 4 шатлал бүхий муж улс ч байдаг. Муж улс бүрийн шүүх өөрийн гэсэн үйл ажиллагааны дүрэмтэй. Муж улсын шүүх нь Холбооны шүүхэд хуулиар харьяалаагүй бүх хэргийг хянан шийдвэрлэдэг ба үүнийг ерөнхий харьяалал (англ. *general jurisdiction*)¹⁷⁴ гэдэг.

Тухайн муж улсаас хамааран шүүхийн нэршил өөр өөр байдаг. Анхан шатны шүүх (англ. *Trial court*) нь ерөнхий харьяаллын дагуу хэргийг хянан шийдвэрлэдэг боловч зарим муж улсын анхан шатны шүүх нь тусгай хэргийн харьяалалтай. Жишээ нь орон нутгийн шүүх (англ. *municipal court*) гэх нэршил бүхий шүүх нь тусгай хэргийн харьяаллын дагуу хот, орон нутагт үйлдэгдсэн хөнгөн гэмт хэрэг, хотын захиргааны шийдвэртэй холбоотой хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэдэг.¹⁷⁵ Мөн ерөнхий харьяаллын дагуу анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэдэг дээд шатны шүүх (англ. *Superior court*) гэж зарим муж улсад байдаг. Энэ шүүх нь ихэвчлэн их хэмжээний мөнгөн дүнтэй иргэний хэрэг, хүнд төрлийн хэргийг шийдвэрлэдэг.¹⁷⁶

Давж заалдах шатны шүүх (англ. *Intermediate Appellate Courts*)-ийн хувьд муж улс болгонд байдаггүй бөгөөд анхан шатны шүүхийн шийдвэрийг хянадаг. Муж улсын дээд шүүх (англ. *State Supreme court*) нь давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хянадаг боловч, зарим муж улсад анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах тохиолдол бий.¹⁷⁷

¹⁷³ “Introduction to the Federal Court system”, U.S. Department of Justice, <https://www.justice.gov/usao/justice-101/federal-courts>. (Сүүлд үзсэн: 2024.11.20).

¹⁷⁴ “General jurisdiction”, Legal Information Institute, <https://www.law.cornell.edu/wex/general-jurisdiction>. (Сүүлд үзсэн: 2024.11.20).

¹⁷⁵ “Municipal court”, Legal Information Institute, <https://www.law.cornell.edu/wex/municipal-court>. (Сүүлд үзсэн: 2024.11.20).

¹⁷⁶ “Court System Breakdown”, The law firm of Douglas G. Jackson, <https://www.getyourlegalaction.com/understanding-the-differences-between-state-and-federal-courts/>. (Сүүлд үзсэн: 2024.11.21).

¹⁷⁷ Ibid



Схем 11. АНУ-ын шүүхийн тогтолцоо



АНУ-ын дээд шүүх нь Үндсэн хуулийг хамгаалах, тайлбарлах гол үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд холбооны шүүх болон муж улсын дээд шүүхийн шийдвэрийг эцсийн байдлаар хянаж шийдвэрлэдэг. Дээд шүүхийн бүрэлдэхүүн нь нийт 9 шүүгчтэй ба Ерөнхий шүүгч (англ. *Chief Justice*) болон бусад 8 туслах шүүгч (англ. *Associate Justice*)-ээс бүрддэг. Шүүх хурлын ирцийг 6 буюу түүнээс дээш шүүгч цугласнаар хүчинтэйд тооцдог.¹⁷⁸ Шүүгчдийг Ерөнхийлөгч насан туршид нь томилж, Сенатаас баталгаажуулдаг байна. Мөн шүүгчдийн цалингийн хэмжээг бууруулахыг хориглодог бөгөөд энэ нь шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангадаг.

АНУ-ын Үндсэн хуулийн 3-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “Элчин сайд, төрийн сайд, консул болон аль нэг улс оролцогч тал болсон хэрэг маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Үндсэн хууль болон бусад хуулийн дагуу хийсэн бүхий л гэрээ хэлцэл, эрүүгийн хэрэг


¹⁷⁸ Title 28 United States Code §1 “The Supreme Court of the United States shall consist of a Chief Justice of the United States and eight associate justices, any six of whom shall constitute a quorum”

маргаантай холбоотой шийдвэрийг давж заалдах шатны журмаар эцэслэн шийдвэрлэнэ.”¹⁷⁹ Ингэхдээ дээд шүүх рүү давж заалдсан гомдол бүрийг хэлэлцдэггүй, 1925 оны Шүүхийн тухай хуулиар дор хаяж 4 шүүгчийн зөвшилцсөнөөр эрх зүйн хэмжээнд ач холбогдолтой, холбооны тойргийн шүүх хоорондын шийдвэр эрх зүйн зөрчилтэй хэргийг хянан шийдвэрлэдэг байна.¹⁸⁰ Дээд шүүх нь хэрэг маргааныг олонхын саналаар шийдвэрлэдэг. Хэрэв шүүгчдийн санал тэнцвэл, доод шатны шүүхийн шийдвэрийг харгалзаж үзнэ.¹⁸¹

VI. СИНГАПУР УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Сингапур улсын шүүхийн тогтолцоо нь анхан шатны шүүхүүд (англ. *State courts*), гэр бүлийн шүүхүүд (англ. *Family justice courts*) болон Улсын дээд шүүхээс (англ. *Supreme court*) бүрддэг.¹⁸²

Схем 12. Сингапур улсын шүүхийн тогтолцоо¹⁸³



Сингапур улсын Үндсэн хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар Улсын дээд шүүх нь Хяналтын шүүх (англ. *The Court of Appeal*) болон

¹⁷⁹ Constitution of the United States (1787), art. 3(2).

¹⁸⁰ “Supreme Court Procedures”, United States Courts, <https://www.uscourts.gov/about-federal-courts/educational-resources/about-educational-outreach/activity-resources/supreme-1>, (Сүүлд үзсэн: 2024.11.21).

¹⁸¹ Congressional Research Service, *Federal and State Courts: Structure and Interaction*, (CRS ,2023), 4, <https://crsreports.congress.gov/product/pdf/R/R47641>.

¹⁸² “About the Singapore courts”, Singaporean courts, November 27, 2024, <https://www.judiciary.gov.sg/who-we-are/about-singapore-courts>

¹⁸³ Singapore court structure, November 27, 2024, *Singapore and UK Case Law Conducted by Lee Su-Lin 19 August ppt download*



Ерөнхий шүүхээс (англ. *High court*)¹⁸⁴ бүрддэг бөгөөд Ерөнхий шүүх нь Ерөнхий танхим (англ. *General division*) болон Давж заалдах танхимд (англ. *Appellate division*) хуваагддаг¹⁸⁵ байна. Мөн Ерөнхий шүүхийн бүрэлдэхүүнд Сингапурын Олон улсын худалдааны шүүх (англ. *Singapore International Commercial Court*)¹⁸⁶ багтдаг. Улсын дээд шүүхийн бүрэлдэхүүн болох Ерөнхий шүүхийн Ерөнхий танхим нь 250000 доллароос дээш үнийн дүнтэй иргэний хэрэг болон цаазаар авах ял эсхүл 10 жилээс дээш хорих ялтай эрүүгийн хэргийг анхан шатны журмаар, анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэдэг.

Мөн Ерөнхий шүүхийн Давж заалдах танхим нь хуульд зааснаар Хяналтын шатны шүүхэд харьяалуулаагүй иргэний хэргийг хянан шийдвэрлэдэг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэдэггүй¹⁸⁷. Харин Хяналтын шүүх нь Ерөнхий шүүхийн Ерөнхий танхимын бүх эрүүгийн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэдэг.¹⁸⁸ Түүнчлэн Улсын дээд шүүхийн үйл ажиллагааны тухай (англ. *Supreme Court of Judicature Act*)¹⁸⁹ хуулийн 6 дугаар хавсралтын 1 дүгээр зүйлд зааснаар Ерөнхий шүүхийн Ерөнхий танхим нь үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх бөгөөд Ерөнхий танхимын шийдвэрийг Улсын дээд шүүхэд давж заалдах боломжтой.

Үүнтэй холбоотойгоор Улсын дээд шүүхийн үйл ажиллагааны тухай (англ. *Supreme Court of Judicature Act*)¹⁹⁰ хуулийн 10 дугаар зүйлд зааснаар хуульд өөрөөр заагаагүй бол Ерөнхий шүүхийн Ерөнхий танхим хэрэг маргааныг 1 шүүгч дангаараа шийдвэрлэдэг. Мөн хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар Ерөнхий шүүхийн Давж заалдах танхим ба Хяналтын шүүх нь хэргийг 3 болон түүнээс дээш сондгой шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр

¹⁸⁴ Сингапур улсад High court нь анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар, зарим төрлийн хэрэг маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэдэг. Тус шүүхийг судлаачийн зүгээс Ерөнхий шүүх гэж орчууллаа.

¹⁸⁵ Сингапур улсын Үндсэн хууль, <https://sso.agc.gov.sg/act/cons1963>

¹⁸⁶ Singapore International Commercial court гэх энэхүү шүүх нь Улсын дээд шүүхийн үйл ажиллагааны тухай хуулийн 18 Д-д зааснаар шүүхийн дүрэмд заасан шаардлагыг хангасан олон улсын арилжааны үйл ажиллагаатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэдэг.

¹⁸⁷ "Role and structure of Supreme court" Singaporean courts, November 27, 2024 <https://www.judiciary.gov.sg/who-we-are/role-structure-supreme-court>

¹⁸⁸ Ibid

¹⁸⁹ Сингапур улсын Шүүхийн үйл ажиллагааны тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/SCJA1969?WholeDoc=1#pr10->

¹⁹⁰ Сингапур улсын Шүүхийн үйл ажиллагааны тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/SCJA1969?WholeDoc=1#pr10->



хянан шийдвэрлэдэг. Мөн Сингапурын Шүүхийн дүрмийн (англ. *Rules of Court*)¹⁹¹ 9 дүгээр дүрмийн 7 дугаар зүйлд зааснаар хэргийн харьяаллын маргааныг Ерөнхий шүүхийн Ерөнхий танхим шийдвэрлэдэг.

Цаашилбал, Анхан шатны шүүхэд Дүүргийн (англ. *District court*), Магистратын (англ. *Magistrates courts*), Тодорхойгүй үхлийн шалтгааныг тогтоох шүүх (англ. *Coroner's court*)¹⁹² болон Бага үнийн дүнтэй хэргийн (англ. *Small Claims Tribunals*)¹⁹³ болон Хөдөлмөрийн трибунал (англ. *Employment Claims Tribunals*)¹⁹⁴ хамаардаг. Мөн дээр схемээр үзүүлсэнчлэн Гэр бүлийн шүүх тогтолцоонд Гэр бүлийн шүүх, Өсвөр насныхны шүүх болон Ерөнхий шүүхийн Гэр бүлийн танхим багтдаг байна. Гэр бүлийн шүүх нь гэрлэлт цуцлах, хүүхэд үрчлэх болон гэр бүлийн хүчирхийллээс хамгаалахтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэдэг. Харин Өсвөр насныхны шүүх нь хүүхэд хамгаалал, өсвөр насны хүнд холбогдох гэмт хэргийг хянан шийдвэрлэдэг. Мөн Ерөнхий шүүхийн Гэр бүлийн танхим нь Гэр бүлийн шүүх болон Өсвөр насныхны шүүхийн шийдвэрийн давж заалдах журмаар хянан шийдвэрлэдэг.¹⁹⁵

Түүнчлэн, Дүүргийн болон Магистратын шүүх нь эрүү, иргэний хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг. Тус шүүхүүдийн хянан шийдвэрлэх хэргүүд нь үнийн дүн болон оногдуулах ялын төрөл, хэмжээгээрээ ялгагддаг байна.¹⁹⁶

Сингапур улс нь 2 шатлал бүхий шүүхийн тогтолцоотой улс бөгөөд тус улсад Үндсэн хуулийн шүүх байдаггүй. Улсын дээд шүүх нь үндсэн хуулийн шүүхийн чиг үүргийг давхар гүйцэтгэдэг байна. Мөн Үндсэн хуулийн 94-р зүйлд зааснаар Улсын дээд шүүх нь Хяналтын шүүх болон Ерөнхий шүүхээс бүрддэг онцлогтой. Дээрх улсад Ерөнхий шүүх нь давж

¹⁹¹ Сингапурын шүүхийн дүрэм, https://sso.agc.gov.sg/SL-Supp/S914-2021/#P11-PO18-P41_1-pr1-

¹⁹² Coroner's court гэх энэхүү шүүх нь гэнэтийн болон зуурдаар, эсхүл хүчирхийллийн улмаас амь нас нь хохирсон байх магадлалтай тохиолдолд үхлийн шалтгааныг тодруулах шүүх юм. https://www.nas.gov.sg/archivesonline/government_records/agency-details/120

¹⁹³ Бага үнийн дүнтэй хэргийн трибунал нь Зээлээр худалдах, худалдан авах гэрээ, эд хөрөнгөд учруулсан гэм хор, орон сууц түрээсийн гэрээтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэдэг.

¹⁹⁴ Хууль бусаар ажлаас халагдсантай холбоотой хөдөлмөрийн хөлсний маргааныг хянан шийдвэрлэдэг.

¹⁹⁵ "Role and structure of the Family Justice Courts" Singaporean courts, November 27, 2024, <https://www.judiciary.gov.sg/who-we-are/role-structure-family-justice-courts/role>

¹⁹⁶ Дүүргийн шүүх нь 10 жил ба түүнээс дээш хорих ялаас хэтрэхгүй эсхүл зөвхөн торгууль ногдуулах эрүүгийн хэрэг болон 60,000 доллараас дээш 250,000 доллар хүртэлх нэхэмжлэлтэй иргэний хэргийг хянан шийдвэрлэдэг. Харин Магистратын шүүх нь 5 жил ба түүнээс доош хорих ял эсхүл зөвхөн торгох ял ногдуулах гэмт хэрэг эсхүл 60,000 доллар болон түүнээс доош хэмжээний нэхэмжлэлтэй иргэний хэргийг хянан шийдвэрлэдэг. <https://www.judiciary.gov.sg/who-we-are/role-structure-state-courts/role>



заалдах шатны шүүх болохоос гадна зарим хэрэг маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг.

ГУРАВ. СОЦИАЛИСТ ЭРХ ЗҮЙН БҮЛ БОЛОН ПОСТ СОЦИАЛИСТ ОРНЫ ТӨЛӨӨЛӨЛ

I. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид “БНХАУ” гэх)-д эрх мэдэл хуваарилах зарчим үйлчилдэггүй бөгөөд Үндсэн хууль (1982)-ийн 128 дугаар зүйлд зааснаар Ардын шүүх нь улсын шүүн таслах байгууллага (хят.审判机关) мөн. Шүүхийн тогтолцооны хувьд Ардын дээд шүүх, Бүх шатны орон нутгийн шүүхүүд, Цэргийн шүүх зэрэг дагнасан шүүхүүдээс бүрдэнэ.¹⁹⁷ Тус улсын тогтолцооны онцлог нь дөрвөн шатны шүүхтэй бөгөөд хэргийг хоёр шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэх зарчим (хят.两审终审)-тай. Энэ зарчим нь давж заалдах журмаар хэргийг шийдвэрлэсэн бол цаазаар авах, бүх насаар хорих ял шийтгэснээс бусад тохиолдолд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болно.¹⁹⁸

Ардын дээд шүүх

Ардын дээд шүүх нь шүүн таслах төрийн дээд байгууллага болохын хувьд хуулийн албан ёсны тайлбар, жишиг шийдвэр (指导性案例) гаргах, хуулиар харьяалуулсан хэргийн хүрээнд танхим байгуулах эрхтэй.¹⁹⁹ Ардын дээд шүүхийн бүтэц нь Хэрэг хүлээн авах хоёр танхим (хят.立案庭), Эрүүгийн хэргийн таван танхим, Иргэний хэргийн дөрвөн танхим, Захиргааны хэргийн танхим, Нөхөн төлбөрийн хорооны алба, Хяналтын танхим, Шийдвэр гүйцэтгэх хэлтсээс тус тус бүрдэнэ.²⁰⁰ Дээрх танхимууд дотроо хэргийн төрлөөр дагнаж хуваагдсан байдаг. Тухайлбал, Иргэний нэгдүгээр танхим нь гэм хор, хөдөлмөрийн болон гэр бүлийн маргааныг,

¹⁹⁷ БНХАУ-ын Үндсэн хууль, https://www.gov.cn/guoqing/2018-03/22/content_5276318.htm

¹⁹⁸ Jianli Song, “China’s Judiciary: Current Issues”, *Maine Law Review* 59, no. 1 (Jan 2007), 145, <https://digitalcommons.maine.maine.edu/cgi/viewcontent.cgi?article=1319&context=mlr> (Сүүлд үзсэн: 2021.11.27).


¹⁹⁹ Ардын дээд шүүх хууль хэрэглээний тайлбар гаргахдаа Шүүхийн хорооны нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Харин жишиг шийдвэр гаргах бол Шүүхийн хорооны мэргэжлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Ардын шүүхийн зохион байгуулалтын тухай хууль, https://www.gov.cn/xinwen/2018-10/27/content_5334895.htm - 《中华人民共和国人民法院组织法》第三十七条。

²⁰⁰ 谭世贵,《中国司法制度(第四版)》[M],法律出版社, 2016:72.



Иргэний хоёрдугаар танхим нь гэрээ, компани, үнэт цаастай холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ. Иргэний дөрөвдүгээр танхим нь далайн хэргийн маргаан, мөн гадаадын этгээд холбогдсон маргааныг, Иргэний гуравдугаар танхим нь оюуны өмчийн маргаан буюу зохиогчийн эрх, барааны тэмдэг, патентын зөрчлүүдийг шийдвэрлэдэг.²⁰¹ Танхим нь Ардын дээд шүүхийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд шийдвэр, захирамж нь мөн шүүхийн адил хүчин чадалтай.

Схем №13. БНХАУ-ын Шүүхийн тогтолцоо



Ардын шүүхийн зохион байгуулалтын тухай хууль (хят. 人民法院组织法)-д шүүхийн бүтэц, зохион байгуулалт, бүрэн эрх зэргийг тусгаж, салбар эрх зүйн процессын хуулиудад шүүхийн харьяаллыг тогтоосон байдаг. Ардын дээд шүүх нь дараах хэргийг хянан шийдвэрлэнэ:²⁰²

1. Хуульд зааснаар харьяалалд нь хамаарах, эсхүл өөрийн харьяалалд хамаарах үндэслэлтэй гэж үзсэн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;²⁰³

²⁰¹ Jiunn-Rong Yeh and Wen-Chen Chang, *Asian Courts in Context* (Cambridge University Press, 2014), 490-491.

²⁰² Ардын шүүхийн зохион байгуулалтын тухай хууль, https://www.gov.cn/xinwen/2018-10/27/content_5334895.htm

²⁰³ Практикт Ардын дээд шүүх хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх нь тун ховор байдаг. 梁平, 刘宇晖. 中国司法制度概论[M]. 中国法制出版社, 2023:38.



2. Дээд шатны шүүхийн шийдвэр (хят.判決), захирамжид (хят.裁定) гомдол, эсэргүүцэл гаргасан хэрэг;
3. Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын Хорооны журамд зааснаар давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргасан хэрэг;
4. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах (хят.再审) хэрэг;
5. Дээд шатны шүүхээс цаазаар авах ялыг батлуулахаар шилжүүлсэн хэрэг.

2015 онд Ардын дээд шүүхээс захиргааны бүсчлэл дамнасан ач холбогдол бүхий (хят.重大) захиргааны болон иргэний хэргийг шударгаар, шуурхай шийдвэрлэх, шүүхийн үйл ажиллагааны төвлөрлийг бууруулж, маргааныг тухайн орон нутагт шийдвэрлэх замаар шүүхийн үйлчилгээг иргэдэд хялбар, хүртээмжтэй болгох зорилгоор долоон Тойргийн танхим (хят.巡回法庭) байгуулжээ. Энэхүү Тойргийн танхим нь байнгын ажиллагаатай шүүн таслах байгууллага бөгөөд шийдвэр нь Ардын дээд шүүхийн шийдвэрийн адил хүчин төгөлдөр байна. Тойргийн танхим нь дараах маргааныг хянан шийдвэрлэнэ. Үүнд:²⁰⁴

1. Улсын хэмжээний ач холбогдолтой, хууль хэрэглээний нарийн төвөгтэй анхан шатны иргэний болон захиргааны хэрэг;
2. Дээд шатны шүүхийн анхан шатны журмаар шийдвэрлэсэн иргэн, захиргааны хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх;
3. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас Дээд шатны шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, захирамж, эвлэрлийг хянуулах хэрэг;
4. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас эрүүгийн хэргийг хянуулах прокурорын эсэргүүцэл;
5. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас Ерөнхий шүүгч хэргийг дахин хянах;
6. Дээд шатны шүүхийн цагдан хорих, торгох шийдвэрийг дахин хэлэлцүүлэх хэрэг;
7. Дээд шатны шүүхийн харьяалалтай холбоотой асуудлаар Ардын дээд шүүхээс шийдвэр, захирамж гаргуулах хэрэг;
8. Дээд шатны шүүхийн хэргийн хугацаа сунгуулах хүсэлт;
9. Хуульд заасан бусад хэрэг.

²⁰⁴ Ардын дээд шүүхийн “Тойргийн хэрэг хянан шийдвэрлэх зарим асуудлын тухай” журам, <https://www.chinacourt.org/law/detail/2015/01/id/148087.shtml>



Ардын дээд шүүх эрүүгийн хэргийг 3-7 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэх²⁰⁵ бөгөөд тус улсад сондгой тоотой бүрэлдэхүүнээр хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий зарчим үйлчилдэг.

Дээд шатны шүүх

Дээд шатны шүүх нь Мужийн дээд шатны шүүх, Автономит бүсийн дээд шатны шүүх, Шууд захирагдах хотын дээд шатны шүүхээс бүрдэх бөгөөд дараах хэргийг хянан шийдвэрлэнэ. Үүнд:

1. Хуулиар тусгайлан харьяалуулсан хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэх;
2. Доод шатны шүүхээс анхан шатны журмаар шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн хэрэг;
3. Ардын дээд шүүхээс харьяалал тогтоосны дагуу анхан шатны журмаар шийдвэрлэх хэрэг;
4. Дунд шатны шүүхийн шийдвэр, захирамжид гомдол, эсэргүүцэл гаргасан хэрэг;
5. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хэрэг;
6. Дунд шатны шүүхээс цаазаар авах ялыг батлуулахаар шилжүүлсэн хэрэг.²⁰⁶

Дээд шатны шүүх нь муж (автономит бүс, шууд захирагдах хот)-ийн хэмжээнд үйлдэгдсэн ач холбогдол бүхий эрүү, иргэн, захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.²⁰⁷

Дунд шатны шүүх

Дунд шатны шүүх нь Муж, Автономит бүсийн дунд шатны шүүх, Шууд захирагдах хотын дунд шатны шүүх, Автономит тойргийн дунд шатны шүүх, Муж болон Автономит бүсийн доторх бүсчилсэн дунд шатны шүүхээс тус тус бүрдэнэ. Дунд шатны шүүх дараах хэргийг хянан шийдвэрлэнэ. Үүнд:

²⁰⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, <https://flk.npc.gov.cn/detail2.html?ZmY4MDgxODE4YTlxZGMxMzAxOGI0MjUzMDNiNzA4NmQ%3D> - 《刑事诉讼法》第一百八十三条。

²⁰⁶ Ардын шүүхийн зохион байгуулалтын тухай хууль, https://www.gov.cn/xinwen/2018-10/27/content_5334895.htm - 《人民法院组织法》第二十条，第二十一条。

²⁰⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйл, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйл, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйл.



1. Хуулиар тусгайлан харьяалуулсан хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэх;
2. Доод шатны шүүхээс анхан шатны журмаар шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн хэрэг;
3. Дээд шатны шүүхээс харьяалал тогтоосны дагуу анхан шатны журмаар шийдвэрлэх хэрэг;
4. Анхан шатны шүүхийн шийдвэр, захирамжид гомдол, эсэргүүцэл гаргасан хэрэг;
5. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хэрэг.

Дунд шатны шүүхэд хуулиар тусгайлан харьяалуулсан хэргийг гурван том процессын хуульд (хят.三大诉讼法) заасан байдаг. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль²⁰⁸ (刑事诉讼法)-д зааснаар Дунд шатны шүүх Улсын аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд, Терроризмтой холбоотой гэмт хэргүүд, бүх насаар нь хорих болон цаазаар авах ял шийтгэх гэмт хэргийг хянан шийдвэрлэнэ. Жишээлбэл, Улсын аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт эх орноосоо урвах, зэвсэгт үймээн дэгдээх, төрийн эрх мэдлийг хууль бусаар авах гэмт хэргүүд хамаарна.²⁰⁹

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль²¹⁰ (民事诉讼法)-д зааснаар Дунд шатны шүүх хэргийн оролцогчид эсхүл тэдгээрийн аль нэг нь гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн, тус улсад оршин суудаггүй /гадаадад холбогдох/ этгээдийн ач холбогдол бүхий хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ; мөн тухайн бүс нутагт ач холбогдол бүхий хэрэг; Ардын дээд шүүхээс шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн хэргийг тус тус хянан шийдвэрлэнэ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль²¹¹ (行政诉讼法)-д зааснаар Дунд шатны шүүх Төрийн зөвлөлийн хэлтэс (хят.国务院部门) эсхүл, хошуунаас дээш зэрэглэлийн газрын засгийн газрын шийдвэрийн эсрэг гаргасан нэхэмжлэл, Гаалийн байгууллагын шийдвэрт холбогдох хэрэг, тухайн газарт хамаарах ач холбогдол бүхий, ээдрээ төвөгтэй

²⁰⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, <https://flk.npc.gov.cn/detail2.html?ZmY4MDgxODE4YTlxZGMxMzAxOGI0MjUzMDNiNzA4NmQ%3D> - 《刑事诉讼法》第二十一条。

²⁰⁹ Эрүүгийн хууль, <https://flk.npc.gov.cn/detail2.html?ZmY4MDgxODE3OTZhNjM2YTAXNzk4MjJhMTk2NDBjOTI%3D>

²¹⁰ Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, <https://flk.npc.gov.cn/detail2.html?ZmY4MDgxODE3ZWQ3NjZlYTAXN2VINmFiOTIhZDFjYmM> - 《民事诉讼法》第十九条。

²¹¹ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, <https://flk.npc.gov.cn/detail2.html?ZmY4MDgxODE3ZWQ3NjZlYTAXN2VINmFiOTIhZDFjYmM%3D> - 《行政诉讼法》第十五条。



хэрэг болон хуульд заасан бусад хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

Анхан шатны шүүх

Анхан шатны шүүх нь Хошуу, Автономит хошууны анхан шатны шүүх, Дүүрэггүй хотын анхан шатны шүүх, Тойргийн анхан шатны шүүхээс бүрдэх бөгөөд хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэнэ. Мөн Эвлэрүүлэх хороо²¹² (хят.调解委员会)-ны ажилд мэргэжлийн тусламж, чиглэл өгөх үүрэгтэй. Анхан шатны шүүх газар нутаг, хүн ам, хэргийн онцлогт тулгуурлан хэд хэдэн Ардын танхим (хят.人民法庭) байгуулж болно. Ардын танхим нь анхан шатны шүүхийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд шийдвэр, захирамж нь анхан шатны шүүхийн шийдвэр, захирамжтай адил хүчинтэй.

Анхан шатны шүүх нь дээд шатны шүүхийн харьяалалд хамаарахаас бусад эрүү, иргэн, захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.²¹³ Гэвч шаардлагатай тохиолдолд дээд шатны шүүх нь доод шатны шүүхийн эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх боломжтой. Мөн хэргийн нөхцөл байдал ноцтой, ээдрээ төвөгтэй байна гэж үзвэл доод шатны шүүхээс дээд шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргах эрхтэй.²¹⁴

Анхан шатны шүүх, Дунд шатны шүүх эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхдээ гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй эсхүл шүүгч болон иргэдийн төлөөлөгчөөс бүрдсэн гурван хүний бүрэлдэхүүнтэй эсхүл долоон хүний бүрэлдэхүүнтэй шийдвэрлэнэ. Харин хэргийг хялбаршуулсан журмаар эсхүл түргэвчилсэн журмаар²¹⁵ шийдвэрлэх тохиолдолд шүүгч хэргийг дангаар шийдвэрлэж болно.²¹⁶

²¹² Эвлэрүүлэх хороо нь тосгоны хороо, оршин суугчдын хорооны хурлын дэргэдэх иргэд хоорондын маргааныг шийдвэрлэх үүрэг бүхий олон нийтийн зохион байгуулалтын нэг хэлбэр юм. Тус хорооны эрх зүйн байдлыг Ардын эвлэрүүлэх тухай хуулиар нарийвчлан зохицуулдаг.

²¹³ Ардын шүүхийн зохион байгуулалтын тухай хууль, https://www.gov.cn/xinwen/2018-10/27/content_5334895.htm - 《人民法院组织法》第二十六条。

²¹⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйл, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйл, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйл.

²¹⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, <https://flk.npc.gov.cn/detail2.html?ZmY4MDgxODE4YTlxZGMxMzAxOGI0MjUzMDNiNzA4NmQ%3D> - 《刑事诉讼法》第二十四条。

²¹⁶ Хэргийн нөхцөл байдал тодорхой, нотолбол зохих байдал бүрэн тогтоогдсон, гурван жилээс доош хугацаатай хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрч, түргэвчилсэн журмаар шийдвэрлүүлэхээр зөвшөөрсөн тохиолдолд Анхан шатны шүүх энэ журмыг хэрэглэнэ.



Шүүх давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцэлтэй хэргийг гурав эсхүл таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй (иргэдийн төлөөлөгчгүй) хянан шийдвэрлэнэ. Шүүх бүрэлдэхүүн олонхын саналаар зөвлөлдөж шийдвэр гаргана.

Иргэний хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүний хувьд шүүгч дангаар, шүүгч иргэдийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй эсхүл зөвхөн шүүгчдийн бүрэлдэхүүнтэй байна.²¹⁷ Харин доор заасан хэргийг шүүгч дангаар шийдвэрлэхийг хориглоно. Үүнд:

- Төрийн, нийтийн ашиг сонирхолд хамаарах хэрэг;
- Олон нийтийг хамарсан, нийгмийн тогтвортой байдалд хамаарах хэрэг;
- Олон нийтийн анхаарал татсан эсхүл нийгэмд өндөр ач холбогдол бүхий бусад хэрэг;
- Шинэ төрлийн эсхүл ээдрээ төвөгтэй хэрэг;
- Хуульд заасан заавал бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх хэрэг;
- Шүүгч дангаараа шийдвэрлэхэд зохимжгүй бусад хэрэг.

Анхан шатны шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх явцад хэргийн ач холбогдол, ээдрээ төвөгтэй байдлын улмаас шийдвэр гаргах боломжгүй бол тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид хандаж Шүүхийн хороо (хят.审判委员会)-д шилжүүлнэ. Шүүх хорооноос гарсан шийдвэрийг бүрэлдэхүүн дагаж мөрдөнө. БНХАУ-ын Ардын шүүх бүрд Ерөнхий шүүгч, түүний орлогч шүүгч, хэд хэдэн туршлагатай шүүгчээс бүрдсэн сондгой тоотой бүрэлдэхүүнтэй Шүүхийн хороо ажилладаг. Бүтцийн хувьд нийт шүүгчийн хуралдаан болон мэргэжлийн хуралдаанд хуваагдана. Дунд шатны болон түүнээс дээш шатны шүүхүүд Шүүхийн хорооны гишүүдийн мэргэжил, ажлын хуваарилалтад үндэслэн, шүүн таслах ажлын хэрэгцээг хангах үүднээс эрүүгийн, иргэний, захиргааны шүүхийн мэргэжлийн хуралдаанд хувааж зохион байгуулах эрхтэй. Шүүхийн хороо дараах үндсэн үүрэгтэй:²¹⁸

- Шүүн таслах ажлыг дүгнэх;
- Ач холбогдол бүхий, ээдрээ төвөгтэй хэргийн хууль хэрэглээний

²¹⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, <https://flk.npc.gov.cn/detail2.html?ZmY4MDgxODE4YTlxZGMxMzAxOGIOMjUzMDNiNzA4NmQ%3D> - 《刑事诉讼法》第一百八十三条。

²¹⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, <https://flk.npc.gov.cn/detail2.html?ZmY4MDgxODE4YTlxZGMxMzAxOGIOMjUzMDNiNzA4NmQ%3D> - 《刑事诉讼法》第一百八十五条。



асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

- Тус шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, захирамж, эвлэрлийг дахин хянах шаардлагатай эсэхийг хэлэлцэж шийдвэрлэх;
- Шүүн таслах ажилтай холбоотой бусад ач холбогдол бүхий асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх.

Тус улсын шүүхэд Ерөнхий шүүгч, Шүүхийн хороо өргөн эрх мэдэлтэй байдаг боловч шүүхийн хараат бусад байдалд хамааралгүй гэж үздэг. Энэ нь шүүхийн хараат бус байдлыг “Ардын шүүх хуульд зааснаар шүүн таслах эрх мэдлийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, нийгмийн болон хувь хүний оролцоогүйгээр бие даан явуулна”²¹⁹ гэж тодорхойлдогтой холбоотой.

Дагнасан шүүх

Цэргийн шүүх бол БНХАУ-ын Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан цэргийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх онцгой чиг үүрэгтэй ардын дагнасан шүүх юм. Ерөнхий шүүгчийг Ардын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн санал болгосноор Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын Хорооны шийдвэрээр томилж, чөлөөлнө. Ардын чөлөөлөх армийн дээд шүүх нь Дээд шатны шүүхийн статустайгаар Ардын дээд шүүхийн хяналт дор үйл ажиллагаа явуулдаг. Цэргийн шүүхийн бүтэц нь долоон Дунд шатны цэргийн шүүх, хэд хэдэн Анхан шатны цэргийн шүүхээс бүрддэг бөгөөд засаг захиргааны бүсчлэлээс хамаарахгүйгээр гурван шатны шүүхийн тогтолцоотой.²²⁰

Далайн хэргийн маргаан нь мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, бүс нутгийн онцлог шинж чанартай байдаг тул Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хороо 1984 оны 11 дүгээр сард “Далайн боомт бүхий хотуудад далайн хэргийн шүүх байгуулах тухай тогтоол”-ыг баталж, энэ төрлийн маргааныг шийдвэрлэх дагнасан шүүхийг байгуулах шийдвэр гаргасан аж. Улмаар 1984 оны Ардын дээд шүүхийн шийдвэрээр тус шүүхийн харьяаллыг тусгайлан тогтоосон байдаг. Тухайлбал, далайн хөлөг онгоц мөргөлдсөний улмаас хохирол барагдуулах, зорчигч болон ачаа тээвэрлэх гэрээний маргаан, хөлөг онгоц түрээслэх, засварлах зэрэг 18 төрлийн хэрэг маргааныг хянан

²¹⁹ Ардын шүүхийн зохион байгуулалтын тухай хууль, https://www.gov.cn/xinwen/2018-10/27/content_5334895.htm - 《人民法院组织法》第四条。

²²⁰ 梁平, 刘宇晖. 中国司法制度概论[M]. 中国法制出版社, 2023:45.



шийдвэрлэнэ. Далайн хэргийн шүүх Дунд шатны шүүхтэй ижил статустай байдаг. Иймд тус шүүхийн шийдвэрийг тухайн засаг захиргааны бүсчлэлийн Дээд шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэдэг. Хэрэв Дээд шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргавал Ардын дээд шүүх хянан шийдвэрлэх тогтолцоотой.²²¹

Төмөр замын тээврийн шүүх нь 1954 онд байгуулагдсан хамгийн анхны дагнасан шүүх юм. 2012 онд тус шүүхийн удирдлагын тогтолцоо өөрчлөгдсөний дараа, Ардын дээд шүүх тус шүүхийн харьяаллыг шинэчилж “Төмөр замын тээврийн шүүхийн хэргийн харьяаллын тухай зарим журам”-ыг гаргасан. Уг журамд зарим эрүү, иргэний хэргийг буюу төмөр замын байгууламжид хохирол учруулсан гэмт хэрэг, төмөр замын талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, төмөр замын ажилчдын үйлдсэн гэмт хэрэг, тээвэрлэлт, эд хөрөнгө, аюулгүй байдалд холбогдох иргэний хэргийн хүрээнд тогтоожээ.²²²

БНХАУ-д интернэт болон нийгмийн амьдрал хоорондын харилцан үйлчлэл гүнзгийрэхийн хэрээр цахим худалдааны маргаан жилээс жилд нэмэгдсээр иржээ. Ханжөү хотын шүүхийн 2016 оны тайлангаас үзэхэд энэ төрлийн хэрэг, маргааны тоо 10,000 давсан байна. Уламжлалт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар эдгээр маргааныг шийдвэрлэх нь өндөр зардалтай, урт хугацаатай, нотлоход ээдрээ төвөгтэй зэрэг олон сөрөг асуудлыг дагуулсан байна. Энэ нь дагнасан шүүх байгуулах хэрэгцээ шаардлагыг улам тодотгож байв. Улмаар Жэжянь мужийн Дээд шатны шүүхээс зарим Анхан шатны шүүхүүдэд цахим худалдааны маргааныг интернэтээр шийдвэрлэх туршилтыг хэрэгжүүлж, амжилттай үр дүнд хүрсэн байна. Энэ туршлага нь Бээжин, Гуанжөү зэрэг хотуудад интернэт шүүх байгуулах суурийг тавьжээ.²²³

Интернэт шүүх нь хэргийг онлайн хэлбэрээр шийдвэрлэдэг. Дэлгэрүүлбэл, хэрэг хүлээн авах, мэдэгдэх хуудас хүргүүлэх, эвлэрүүлэн зуучлах, нотлох баримт солилцох, урьдчилсан хэлэлцүүлэг хийх, шүүх хуралдаан явуулах, шүүхийн шийдвэр гардуулах зэрэг шүүхийн үйл ажиллагааны бүхий л үе шат ерөнхийдөө цахимаар явагдана. Гэвч хэргийн оролцогчдын хүсэлт эсвэл шүүх хэргийг хянан шийдвэрлэх шаардлагад

²²¹ Мөн тэнд, 46 дахь тал.

²²² Мөн тэнд.

²²³ Мөн тэнд.



нийцүүлэн зарим ажиллагааг танхимын хэлбэрээр явуулж болно.²²⁴ Тус шүүх цахим орчинд үйлдэгдсэн дараах хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Үүнд:

1. Цахим худалдааны платформоор гэрээ байгуулсан эсхүл, интернет худалдааны гэрээний биелэлттэй холбоотой үүссэн маргаан;
2. Гэрээ байгуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа бүгд интернет орчинд үйлдэгдсэн сүлжээний үйлчилгээний гэрээний маргаан;
3. Гэрээ байгуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа бүгд интернет орчинд үйлдэгдсэн санхүүгийн зээлийн гэрээний маргаан, бага үнийн дүнтэй зээлийн гэрээний маргаан;
4. Интернэт орчинд анх удаа бүтээлээ нийтэлснээр үүссэн зохиогчийн эрх болон хамаарах эрх (анг.Neighboring rights)-ийн маргаан;
5. Онлайн хэлбэрээр бүтээлээ байршуулсан, дамжуулсны улмаас зохиогчийн эрх болон хамаарах эрх зөрчигдсөн маргаан;
6. Домэйн нэр, гэрээний зөрчилтэй холбоотой маргаан;
7. Интернет орчинд бусдын эрх, эд хөрөнгийн эрх болон бусад эрх, эрх чөлөөг зөрчсөний улмаас үүссэн маргаан;
8. Цахим платформоос худалдан авсан бүтээгдэхүүний доголдлын улмаас бусдын эрх, эд хөрөнгийн эрхийг зөрчсөн гэрээний хариуцлагатай холбоотой маргаан;
9. Прокурорын байгууллагаас нийтийн ашиг сонирхлыг төлөөлж гаргасан маргаан;
10. Захиргааны байгууллагын интернэт үйлчилгээ, бүтээгдэхүүний худалдаатай холбоотой шийдвэрээс үүссэн маргаан;
11. Дээд шатны шүүхээс харьяалал тогтоосон бусад иргэний болон захиргааны хэрэг /интернет/.

Интернэт шүүх нь анхан шатны шүүхийн статустай бөгөөд давж заалдах журмаар гаргасан гомдлыг Дунд шатны шүүх харьяалан шийдвэрлэнэ. Тухайлбал, Бээжин хотын интернэт шүүхийн шийдвэрт гаргасан давж заалдах гомдлыг Бээжин хотын 4 дүгээр Дунд шатны шүүх шийдвэрлэнэ. Харин онлайн хэлбэрээр бүтээлээ байршуулсан, дамжуулсны улмаас зохиогчийн эрх болон хамаарах эрх зөрчигдсөн

²²⁴ Ардын дээд шүүхийн “Интернэт шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх зарим асуудлын тухай” журам, <https://flk.npc.gov.cn/detail2.html?MmM5MGU1YmE2NWM2OGNmNzAxNjdmMmU1NDRmZjUwMTI%3D>



маргаан; домэйн нэр, гэрээний зөрчилтэй холбоотой маргааныг мөн хотын Оюуны өмчийн шүүх хянан шийдвэрлэнэ.²²⁵

II. ОХУ-ЫН ЗОХИЦУУЛАЛТ

“Оросын Холбооны Улс (цаашид “ОХУ” гэх)-ын шүүхийн тогтолцооны тухай” Холбооны Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “ОХУ-д ОХУ-ын шүүхийн тогтолцоог бүрдүүлдэг **холбооны шүүхүүд** болон **ОХУ-ын бүс нутгуудын энх тайвны шүүгчид** үйл ажиллагаагаа явуулна” хэмээн заажээ.

Мөн зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар **холбооны шүүхүүдэд** ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх; ОХУ-ын Дээд Шүүх; Ерөнхий харьяаллын холбооны шүүхийн тогтолцоог бүрдүүлэх Ерөнхий харьяаллын хоёрдугаар давж заалдах шатны шүүхүүд, Ерөнхий харьяаллын давж заалдах шатны шүүхүүд, бүгд найрамдах улсуудын дээд шүүхүүд, хязгаарын, мужийн шүүхүүд, холбооны ач холбогдол бүхий хотуудын шүүхүүд, өөртөө засах мужийн болон болон өөртөө засах тойргийн шүүхүүд, Дүүргүүдийн шүүхүүд, цэргийн болон дагнасан шүүхүүд; Холбооны арбитрын шүүхийн тогтолцоог бүрдүүлэх тойргуудын арбитрын шүүхүүд, давж заалдах шатны арбитрын шүүхүүд, ОХУ-ын субъектүүдийн арбитрын шүүх болон дагнасан арбитрын шүүхүүд хамаарна.


ОХУ-ын шүүхийн тогтолцооны тухай” Холбооны Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “**Энх тайвны шүүгчид ОХУ-ын бүс нутгуудын ерөнхий харьяаллын шүүгчид болно**”²²⁶ гэж заажээ. Үүнийг дараах байдлаар схемээр илэрхийллээ.

²²⁵ 梁平, 刘宇晖. 中国司法制度概论[M]. 中国法制出版社, 2023:53-54.

²²⁶ Федеральный конституционный закон от 31 декабря 1996 года № 1-ФКЗ «О судебной системе Российской Федерации» // Собрание законодательства РФ. 1997 г., № 1. // 1996 оны 12-р сарын 31-ний өдрийн № 1-ХҮХ «ОХУ-ын шүүхийн тогтолцооны тухай» Холбооны Үндсэн хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга. 1997, №1.



Схем 14. ОХУ-ын шүүхийн тогтолцоо



ОХУ-ын дээд шүүх иргэний хэрэг, эдийн засгийн маргаантай, эрүүгийн, захиргааны болон дээр дурдсан шүүхүүдэд харьяалагдах бусад хэргүүдийг хяналтын шатны шүүхийн хувьд, мөн түүнчлэн өөрийн бүрэн эрхийн хүрээнд давж заалдах болон хоёрдугаар давж заалдах шатны шүүхийн



журмаар хянан үзэж, холбооны хуульд заасан процессын хэлбэрээр энэхүү Холбооны үндсэн хуулийн дагуу байгуулагдсан шүүхүүдийн үйл ажиллагаанд хяналт тавина. ОХУ-ын Дээд Шүүх түүний харьяалалд хамаарах хэргийг анхан шатны журмаар мөн шинээр эсвэл дахин нээгдсэн нөхцөл байдлын улмаас хянан үзнэ. ОХУ-ын Дээд Шүүх ОХУ-ын хууль тогтоомжуудыг нэгдмэл байдлаар хэрэглүүлэхийн тулд шүүхийн практикийн асуудлаар шүүхүүдэд тайлбар өгнө. “ОХУ-ын Дээд шүүхийн тухай” Холбооны Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн²²⁷ 1 дэх хэсэгт “ОХУ-ын Дээд Шүүх нь нэг зуун далан ОХУ-ын Дээд Шүүхийн шүүгчээс бүрдэнэ”²²⁸ гэж заасан байна.

ОХУ-ын Дээд шүүх нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 332 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 412.1 дэх зүйлийн 3 дахь хэсэг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 391.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан холбогдох шүүхүүдийн шийдвэрүүд, тодорхойлолтууд, тогтоолууд хэргийн оролцогчид болон бусад этгээдүүдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн тухай гомдлыг гаргасан тохиолдолд ОХУ-ын Дээд шүүхийн Шүүгчдийн бүрэлдэхүүн тус гомдлыг хянан үздэг байна. ОХУ-ын Дээд Шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2014.08.07-ны өдрийн №2 “ОХУ-ын Дээд Шүүхийн дүрмийг батлах тухай” тогтоолын 3 дугаар хэсгийн 3.2.-т зааснаар **ОХУ-ын Дээд Шүүхийн шүүгчдийн бүрэлдэхүүн** нь Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, түүний орлогчид болон Дээд Шүүхийн шүүгчид гэх нийт 13 шүүгчээс бүрдэнэ гэж зохицуулжээ.

ОХУ-ын Шүүхийн тогтолцооны тухай Холбооны Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Дүүргийн шүүх өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд хэргийг²²⁹ анхан шатны болон давж заалдах шатны журмаар болон шинээр эсвэл дахин нээгдсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэх ба холбооны үндсэн хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Дүүргийн шүүх холбогдох дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй энх тайвны шүүгчдийн хувьд дээд шатны шүүх болдог ба ОХУ-ын Шүүхийн тогтолцооны тухай Холбооны Үндсэн хуулийн 28 дугаар зүйлд

²²⁷ ОХУ-ын Дээд шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйл. ОХУ-ын Дээд Шүүхийн бүрэлдэхүүн.

²²⁸ Федеральный конституционный закон от 5 февраля 2014 года № 3-ФКЗ «О Верховном Суде Российской Федерации» // «Собрание законодательства РФ», 10.02.2014, N 6, ст. 550.// “ОХУ-ын Дээд шүүхийн тухай” 2014 оны 02-р сарын 05-ны өдрийн № 3 Холбооны Үндсэн хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга, 2014.02.10, N 6, 550 х.// 1)

²²⁹ Мөн тэнд.



зааснаар Энх тайвны шүүгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд иргэний, захиргааны болон эрүүгийн хэргүүдийг анхан шатны шүүхийн хувьд (*ор. в качестве суда первой инстанции*) хянан үзнэ.

ОХУ-ын Шүүхийн тогтолцооны тухай Холбооны Үндсэн хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу Цэргийн шүүхүүд ОХУ-ын Зэвсэгт хүчин, бусад цэрэг, цэргийн анги, мөн холбооны хуулиар цэргийн алба хаахыг заасан байгууллагуудад шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх ба Цэргийн шүүхүүд өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд хэргийг анхан шатны болон давж заалдах шатны журмаар болон шинээр эсвэл дахин нээгдсэн нөхцөл байдлын улмаас хянан үзнэ.²³⁰

“ОХУ-ын цэргийн шүүхүүдийн тухай” Холбооны Үндсэн хуулийн 12.2 дугаар зүйлийн 1 дэх ххэсэгт зааснаар хоёрдугаар давж заалдах шатны цэргийн шүүх холбооны хуулиар тогтоосон харьяаллын дагуу хоёрдугаар давж заалдах шатны шүүхийн хувьд гарнизоны цэргийн шүүхүүд, дүүргийн (тэнгисийн) цэргийн шүүхүүд болон давж заалдах шатны цэргийн шүүхүүдийн хүчин төгөлдөр болсон шүүхийн актуудад гаргасан гомдлын дагуу хэргийг, мөн түүнчлэн шинээр эсвэл дахин нээгдсэн нөхцөл байдалтай хэргийг хянан хэлэлцэх ба холбооны хуулийн дагуу бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Түүнчлэн Дүүргийн (тэнгисийн) цэргийн шүүх анхан шатны журмаар иргэний болон захиргааны хэргүүдийг, ОХУ-ын Эрүүгийн процессын хуулиар тус цэргийн шүүхийн бүрэн эрхэд хамааруулсан эрүүгийн хэргүүдийг болон захиргааны нэхэмжлэлээр боломжит хугацаанд шүүхээр шүүлгэх эрхийг зөрчсөний нөхөн төлбөрийг боломжит хугацаанд олгуулах эсвэл гарнизоны цэргийн шүүхэд харьяалагдах хэргүүдээр гарсан шүүхийн актыг боломжит хугацаанд биелүүлэх эрхийн тухай хэргүүдийг хянан хэлэлцдэг. Дүүргийн (тэнгисийн) цэргийн шүүх энэхүү²³¹ холбооны үндсэн хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд, гарнизоны цэргийн шүүхийн хүчин төгөлдөр болоогүй ба анхан шатны журмаар гаргасан

²³⁰ Федеральный конституционный закон от 31 декабря 1996 года № 1-ФКЗ «О судебной системе Российской Федерации» // Собрание законодательства РФ. 1997 г., № 1. // 1996 оны 12-р сарын 31-ний өдрийн № 1-ХҮХ «ОХУ-ын шүүхийн тогтолцооны тухай» Холбооны Үндсэн хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга. 1997, №1.

²³¹ Федеральный конституционный закон «О военных судах Российской Федерации» от 23 июня 1999 г., №1-ФКЗ // Собрание законодательства Российской Федерации от 28 июня 1999 г., № 26 // 1999 оны 6-р сарын 23-ны өдрийн №1- ХҮХ “ОХУ-ын цэргийн шүүхүүдийн тухай” Холбооны Үндсэн хууль // 1999 оны 6-р сарын 28-ны өдрийн № 26 ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга.



шийдвэр, захирамж, магадлал болон тогтоолд гаргасан гомдлыг хянан хэлэлцэнэ.

Харин Гарнизоны цэргийн шүүх Холбооны үндсэн хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд анхан шатны журмаар холбооны үндсэн хуулиар болон (эсвэл) холбооны хуулиар Цэргийн албан хаагчдын шүүхийн коллегийн эсвэл дүүргийн (тэнгисийн) цэргийн шүүхүүдийн харьяалалд хамааруулаагүй иргэний, захиргааны болон эрүүгийн хэргүүдийг, мөн түүнчлэн цэргийн албан хаагчид болон цэргийн сургалтад хамрагдаж буй иргэд сахилгын баривчлах шийтгэл оногдуулахуйц ноцтой сахилгын зөрчил гаргасан тухай материалуудыг хянан хэлэлцдэг байна.²³²

ОХУ-ын Шүүхийн тогтолцооны тухай Холбооны Үндсэн хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу Ерөнхий харьяаллын шүүхүүдэд харьяалагдах иргэний болон захиргааны хэргийн, мөн түүнчлэн арбитрын шүүхүүдэд харьяалагдах эдийн засгийн маргаан болон бусад хэргүүдийг хянан үзэх Холбооны дагнасан шүүхүүдийг энэхүү Холбооны үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар байгуулна.

ОХУ нь Оюуны өмчийн эрхийн дагнасан шүүхтэй бөгөөд тус шүүх нь оюуны өмчийн эрхийг хамгаалахтай холбоотой маргааныг анхан шатны болон хоёрдугаар давж заалдах шатны журмаар өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шийдвэрлэнэ.²³³

Мөн ОХУ-д хэргийн харьяаллын талаар маргахыг хориглосон онцлог зохицуулалт бий. Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйл²³⁴, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 4 дэх хэсэг²³⁵, Иргэний хэрэг хянан

²³² Федеральный конституционный закон «О военных судах Российской Федерации» от 23 июня 1999 г., №1-ФКЗ // Собрание законодательства Российской Федерации от 28 июня 1999 г., № 26 // 1999 оны 6-р сарын 23-ны өдрийн №1- ХҮХ “ОХУ-ын цэргийн шүүхүүдийн тухай” Холбооны Үндсэн хууль // 1999 оны 6-р сарын 28-ны өдрийн № 26 ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга.

²³³ Федеральный конституционный закон от 31 декабря 1996 года № 1-ФКЗ «О судебной системе Российской Федерации» // Собрание законодательства РФ. 1997 г., № 1. // 1996 оны 12-р сарын 31-ний өдрийн № 1-ХҮХ «ОХУ-ын шүүхийн тогтолцооны тухай» Холбооны Үндсэн хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга. 1997, №1.

²³⁴ Уголовно-процессуальный кодекс Российской Федерации от 18.12.2001 № 174-ФЗ // Собрание законодательства РФ. - 24.12.2001. - № 52 (ч. I). - ст. 4921. // (2001 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн № 174 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга. – 2001.12.24. -№ 52 (1 х.). 4921 х).

²³⁵ Кодекс административного судопроизводства Российской Федерации» от 08.03.2015 N 21-ФЗ // Собрание законодательства РФ, 09.03.2015, N 10, ст. 1391. // ОХУ-ын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2015.03.08-ний өдрийн N 21-XX // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга, 2015.03.09, N 10, 1391 х.



шийдвэрлэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг²³⁶, Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт²³⁷ тус тус заасны дагуу ОХУ-ын шүүхүүдийн хооронд хэргийн харьяаллын талаар маргахыг хориглоно гэжээ.

III. БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Бүгд Найрамдах Польш улс (цаашид “Польш улс” гэх)-д шүүх эрх мэдлийг дээд шүүх, ерөнхий харьяаллын шүүх (англ. *Common courts*), захиргааны шүүх, цэргийн шүүх тус тус хэрэгжүүлдэг.²³⁸ Мөн тус улсын Үндсэн хуулийн 176 дугаар зүйлийн 176.2 дахь хэсэгт “*Шүүхийн бүтэц, харьяалал, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулиар тогтооно*” гэж заасан байх бөгөөд тус улсын шүүхийн тогтолцоо нь хоёр тусдаа салбараас бүрддэг²³⁹. Өөрөөр хэлбэл тус улсын шүүхийн тогтолцоо нь дээд шүүхээс ерөнхий харьяаллын шүүхийн шийдвэрийг кассаци хэлбэрээр хянах (Орч. Cassation гэдэгт аливаа хэрэг маргааныг үйл баримтад бус хууль хэрэглээ, хууль тайлбарлах агуулгаар хянах)²⁴⁰ болон захиргааны байгууллагын үйл ажиллагааг шүүхээс хянах захиргааны шүүхийн хяналт гэж тус тус хуваагддаг байна.


²³⁶ Гражданский процессуальный кодекс Российской Федерации от 14.11.2002 № 138-ФЗ // Собрание законодательства РФ, 18.11.2002, N 46, ст. 4532. // 2002.11.14-ний өдрийн № 138 -XX ОХУ-ын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга, 2002.11.18, N 46, 4532 х.

²³⁷ Арбитражный процессуальный кодекс Российской Федерации от 24.07.2002 № 95-ФЗ // Собрание законодательства РФ», 29.07.2002, N 30, ст. 3012. // (2002.07.24 өдрийн № 95-XX ОХУ-ын Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга, 2002.07.29, N 30, 3012 х.

²³⁸ Бүгд Найрамдах Польш улсын Үндсэн хууль - The Constitution of The Republic of Poland (1997), art. 175(1).

²³⁹ “Poland National report”, Global access to justice, November 21, 2024, <https://globalaccesstojustice.com/global-overview-poland/>.

²⁴⁰ А.Бямбажаргал, “Улсын дээд шүүхийн чиг үүргийн талаарх харьцуулсан шинжилгээ,” *Нээлттэй нийгэм форум*, №29, (2020), 11 дэх тал.

Схем 15. Польш улсын шүүхийн тогтолцоо²⁴¹

Польш улсын эрх зүйн тогтолцоо нь эх газрын эрх зүйн тогтолцоонд суурилдаг²⁴² ба пост социалист улс юм.²⁴³ Ердийн харьяаллын шүүх нь эрүү, иргэн, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн даатгал²⁴⁴ гэх 5 төрлийн маргаан буюу захиргааны шүүх, дээд шүүх, цэргийн шүүхэд хуулиар харьяалуулснаас бусад төрлийн маргааныг хянан шийдвэрлэх эрх хэмжээг хэрэгжүүлдэг байна.²⁴⁵ Түүнчлэн тус шүүх нь бүс, дүүрэг, давж заалдах шат гэж²⁴⁶ хуваагдах ба тус улсын Үндсэн хуульд “шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хоёроос доошгүй үе шаттай байна” гэж зохицуулсан байна.²⁴⁷

Мөн Польш улсын зэвсэгт хүчин дэх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан хэмжээгээр хэрэгжүүлдэг Цэргийн шүүх байх бөгөөд хуульд заасан тохиолдолд зэвсэгт хүчинд харьяалагдахгүй иргэнд холбогдох эрүүгийн хэргийг мөн шийдвэрлэдэг байна.²⁴⁸ Захиргааны шүүх нь төрийн захиргааны байгууллагын (англ. *Public administration*)

²⁴¹ Ibid.

²⁴² F.Pazderski, “An Overview of Polish Law”, *GlobaLex*, (April 2020), <https://www.nyulawglobal.org/globalex/poland1.html>.

²⁴³ *Supra* note 239.

²⁴⁴ *Supra* note 239.

²⁴⁵ Ерөнхий харьяаллын шүүхийн тухай хууль - Law on Common Courts Organisation (2001), art. 2.

²⁴⁶ Ерөнхий харьяаллын шүүхийн тухай хууль - Law on Common Courts Organisation (2001), art. 1.

²⁴⁷ Бүгд Найрамдах Польш улсын Үндсэн хууль - The Constitution of The Republic of Poland (1997), art. 175(1).

²⁴⁸ Цэргийн шүүхийн тогтолцооны тухай хууль - Law on the system of military courts (1997), art. 1.



үйл ажиллагааг хянахын зэрэгцээ төрийн захиргааны байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын (англ. *Local government*) хооронд үүссэн эрх мэдэл болон түүний харьяалалд (англ. *competence and jurisdiction*) холбогдох маргааныг шийдвэрлэх замаар захиргааны шүүхийн хяналтыг хэрэгжүүлдэг байна.²⁴⁹ Харин Захиргааны дээд шүүх нь орон нутгийн захиргааны шүүхийн шийдвэрийг хянах, маргаантай хуулийн зохицуулалтыг тайлбарлах зэрэг хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг.²⁵⁰ Мөн тус шүүх нь танхимын хэлбэрээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах бөгөөд санхүү (англ. *Financial*), худалдаа (англ. *Commercial*) болон захиргааны ерөнхий танхимд тус тус хуваагддаг.²⁵¹

Хэргийн харьяалалд холбогдох маргааныг тухайлан шийдвэрлэх эрхтэй этгээдийг тогтоохдоо дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

- Иргэний хэргийн хувьд: Хэргийн нөхцөл байдлаас шалтгаалж нэхэмжлэл гаргах шүүхийн харьяаллыг тогтоох боломжгүй бол Дээд шүүх нэхэмжлэл гаргах шүүхийг тогтооно.²⁵²
- Эрүүгийн хэргийн хувьд: давж заалдах шатны болон ердийн харьяаллын шүүхийн харьяаллын талаарх маргааныг Дээд шүүх шийдвэрлэнэ.²⁵³

Тус улсын шүүхийн тогтолцооны нэг бие даасан байгууллага бол Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндсэн хуулийн шүүх (англ. *Constitutional Tribunal*) юм.²⁵⁴ Үндсэн хуулийн хяналт гэдэгт: хууль тогтоомж, олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж буй эсэх²⁵⁵, Үндсэн хуулийн байгууллага (англ. *central constitutional organs of the State*) хоорондын эрх хэмжээнд холбогдох маргаан²⁵⁶, Улс төрийн намуудын зорилго, үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцэж буй эсэх²⁵⁷ зэрэг багтана.

²⁴⁹ Захиргааны хэргийн шүүхийн тогтолцооны тухай хууль - Law on the system of administrative courts (2002), art. 1(1).

²⁵⁰ Захиргааны хэргийн шүүхийн тогтолцооны тухай хууль - Law on the system of administrative courts (2002), art. 3(2).

²⁵¹ Захиргааны хэргийн шүүхийн тогтолцооны тухай хууль - Law on the system of administrative courts (2002), art. 39(1).

²⁵² Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль - Code of Civil Procedure (1964), art. 45(1).

²⁵³ Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль - Code of Criminal Procedure (1997), art. 38(1).

²⁵⁴ *Supra* note 242.

²⁵⁵ Бүгд Найрамдах Польш улсын Үндсэн хууль - The Constitution of The Republic of Poland (1997), art. 188(1).

²⁵⁶ Бүгд Найрамдах Польш улсын Үндсэн хууль - The Constitution of The Republic of Poland (1997), art. 189.

²⁵⁷ Бүгд Найрамдах Польш улсын Үндсэн хууль - The Constitution of The Republic of Poland (1997), art. 188(4).



Хяналтын шатны шүүхэд холбогдох эрх зүйн зохицуулалт

Дээр дурдсан ердийн харьяаллын шүүх болон цэргийн шүүхийн шийдвэрийг хянах эрх бүхий байгууллага нь Дээд шүүх юм.²⁵⁸ Тус шүүх нь Польш улсын шүүхийн тогтолцооны дээд байгууллага²⁵⁹ ба доод шатны шүүхийн²⁶⁰ шийдвэрт холбогдох гомдлыг хянан хэлэлцэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.²⁶¹ Мөн тус улсын ерөнхийлөгч, хууль тогтоох байгууллага, европын парламент зэрэг сонгуулийн санал хүчин төгөлдөр эсэх талаарх маргааныг шийдвэрлэдэг ба бүх нийтийн санал асуулга хүчинтэй эсэхийг баталгаажуулах²⁶² болон хуульд заасан сахилгын хэргийг хянан шийдвэрлэх²⁶³ чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.

Тус улсын Дээд шүүхийн тухай хуульд ерөнхийлөгч дээд шүүхийн танхимын нийт шүүгчдийн орон тоог 120-с багагүй байхаар²⁶⁴ тогтооно гэж заасан байх бөгөөд ерөнхийлөгчийн баталсан Дээд шүүхийн дүрэмд “дээд шүүх 125 шүүгчийн орон тоотой байна”²⁶⁵ гэж зохицуулсан. Түүнчлэн дээд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа танхимын хэлбэрээр зохион байгуулагддаг. Тодруулбал, 1) иргэн, 2) эрүү, 3) хөдөлмөр - нийгэм хамгаалал, 4) тусгай хяналт – нийтийн асуудал (англ. *Extraordinary Control and Public Affairs*), 4а) сахилгын хэрэг (англ. *Disciplinary*) гэх танхимуудад хуваагдана.²⁶⁶ Танхимын шүүгчийн орон тооны хувьд иргэний хэргийн танхим 45, Эрүүгийн хэргийн танхим 38, Хөдөлмөр – нийгэм хамгааллын танхим 22, тусгай хяналт – нийтийн асуудал 20 тус тус байна.²⁶⁷

Дээд шүүхэд хэрэгжүүлэх хэргийн хөдөлгөөний удирдлагын хувьд, хуульд өөрөөр заагаагүй бол дээд шүүх 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг шийдвэрлэнэ.²⁶⁸ Харин доод шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн нөхцөл байдал тогтоогдвол дээд шүүхийн тэргүүн (англ. *The First President of the Supreme Court*) уг зөрүүг арилгах, хууль хэрэглээний

²⁵⁸ Бүгд Найрамдах Польш улсын Үндсэн хууль - The Constitution of The Republic of Poland (1997), art. 183(1).

²⁵⁹ Ibid.

²⁶⁰ (Ердийн харьяаллын болон цэргийн шүүхийн шийдвэр).

²⁶¹ Дээд шүүхийн тухай хууль - Act on the Supreme court (2017), art. 1(1a).

²⁶² Дээд шүүхийн тухай хууль - Act on the Supreme court (2017), art. 1(3).

²⁶³ Дээд шүүхийн тухай хууль - Act on the Supreme court (2017), art. 1(2).

²⁶⁴ Дээд шүүхийн тухай хууль - Act on the Supreme court (2017), art. 4.

²⁶⁵ Дээд шүүхийн тухай дүрэм - Rules of the Supreme Court (2022), art. 2.

²⁶⁶ Дээд шүүхийн тухай хууль - Act on the Supreme court (2017), art. 3.

²⁶⁷ Дээд шүүхийн тухай дүрэм - Rules of the Supreme Court (2022), art. 40(1).

²⁶⁸ Дээд шүүхийн тухай хууль - Act on the Supreme court (2017), art. 77(1).



нэгдмэл байдал бий болгох зорилгоор 7 буюу зохих бусад²⁶⁹ шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэх хүсэлт (англ. *request*) гаргаж болдог.²⁷⁰

Цаашилбал, шүүгчид хэрэг хуваарилах, шүүх бүрэлдэхүүн томилох чиг үүргийг танхимын тэргүүн²⁷¹ (англ. *The President of the Supreme Court*) хэрэгжүүлдэг.²⁷² Тодруулбал, танхимын тэргүүн шүүгчдийн нэрсийг цагаан толгойн үсгийн дарааллаар жагсааж²⁷³ танхимд хэргийг хүлээн авсан дарааллаар шүүгчид хуваарилдаг байна.²⁷⁴

Дээрх дэд хэсгийг дүгнэвэл, Польш улс нь эх газрын эрх зүйн тогтолцоонд хамаардаг байх ба шүүхийн тогтолцооны хувьд ердийн харьяаллын болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд хуваагдаж байна. Мөн цэргийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг биелэлтийг хянах болон үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих тусгай чиг үүрэг бүхий бие даасан шүүхтэй. Түүнчлэн хэргийн харьяалалд холбогдох маргааныг шийдвэрлэх тухайлсан чиг үүрэг бүхий этгээдийг тогтоосон зохицуулалт байхгүй боловч эрүү, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар төсөөтэй хэрэглэх боломж бүхий зохицуулалтыг хуульчилсан байна.

Хяналтын шатны шүүхийн хувьд нийт 125 шүүгчтэй байх бөгөөд танхимын зохион байгуулалтад хуваагдаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдаг. Ингэхдээ доод шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгаж, нэгдмэл хэрэглээг бий болгох, сонгуулийн үйл ажиллагаанд холбогдох маргааныг хянан хэлэлцэж, бүх нийтийн санал асуулгын үр дүн баталгаажуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Хэргийн хөдөлгөөний удирдлагын хувьд танхимын тэргүүн хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг нэрсийн жагсаалтын дагуу томилдог байх ба хуульд өөрөөр заагаагүй бол 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг шийдвэрлэдэг байна. Мөн хууль хэрэглээний нэгдмэл байдал бий болгох, эрх зүйн ач холбогдол бүхий хэргийг шийдвэрлэхдээ 7 шүүгч,

²⁶⁹ Дээд шүүхийн тухай хууль (2017)-ийн 86 дугаар зүйлийн 2 дахь хэсэг: “7 шүүгчийн бүрэлдэхүүн нь шүүхийн практик дахь ач холбогдол болон эргэлтээ бүхий байдлыг харгалзан “үндэслэлтэй” гэж үзвэл хууль хэрэглээний зөрүү арилгах хүсэлтийг танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар шийдвэрлэж болно. Мөн танхим дээрх агуулгаар хоёр буюу түүнээс дээш танхим нэгдэж эсхүл дээд шүүхийн нийт танхимын бүрэлдэхүүнд шилжүүлж болно”.

²⁷⁰ Дээд шүүхийн тухай хууль - Act on the Supreme court (2017), art. 83(1).

²⁷¹ (Орч. Дээд шүүхийн тухай хууль (2017)-ийн 15 дугаар зүйлд “The President of the Supreme Court” гэх албан тушаал танхимын үйл ажиллагааг хариуцна гэж заасан байх тул “танхимын тэргүүн” гэж орчуулсан болно).

²⁷² Дээд шүүхийн тухай хууль - Act on the Supreme court (2017), art. 80(1).

²⁷³ Дээд шүүхийн тухай дүрэм - Rules of the Supreme Court (2022), art. 78(1).

²⁷⁴ Дээд шүүхийн тухай дүрэм - Rules of the Supreme Court (2022), art. 80(1).



шаардлагатай гэж үзвэл танхимын нийт шүүгч болон хоёр болон түүнээс дээш танхим нийлж хэргийг шийдвэрлэх боломжтой байна.

IV. БҮГД НАЙРАМДАХ УЗБЕКИСТАН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Бүгд Найрамдах Узбекистан Улс (цаашид “Узбекистан” гэх)-ын хууль, эрх зүйн суурь нь уугуул иргэдийн заншлын эрх зүйгээс гадна Оросын эзэнт гүрний үеийн болон Зөвлөлт Холбоот Улс (цаашид “ЗХУ” гэх)-ын эрх зүйтэй ихээхэн холбогддог. 19 дүгээр зуунд Оросууд Узбекийн нүүдэлчдийн маргааныг шийдвэрлэх уламжлалт шариат (англ. *shariah*)-ын²⁷⁵ болон заншлын шүүхээс гадна ерөнхий харьяаллын шүүхүүдийг байгуулсан байдаг. Улмаар ЗХУ-ын дэглэмийн үед эх газрын эрх зүйн бүлд суурилсан социалист хууль, шүүхийн тогтолцоог нэвтрүүлсэн.

Узбекистан улс нь засаг захиргааны нэгжийн хувьд 12 муж, нийслэл Ташкент хот (англ. *Tashkent*), мөн тусдаа өөрийн гэсэн үндсэн хууль, шүүх тогтолцоо бүхий автономит эрхт Бүгд Найрамдах Каракалпакстан Улсаас бүрддэг учир шүүхийн тогтолцоо нь ч энэ бүтцээ даган хөгжиж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Ерөнхийлөгчийн 2020 оны 7 сарын 24-ний өдрийн “Шүүхийн үйл ажиллагааг цаашид сайжруулах, шударга ёсны үр нөлөөг дээшлүүлэх нэмэлт арга хэмжээний тухай” зарлигийн хүрээнд 2021 томоохон шинэчлэлт хийгджээ.²⁷⁶

Нийт шүүхийг үндсэн хуулийн, ерөнхий харьяаллын болон дагнасан гэж хуваах ба үүнд: **1) Үндсэн хуулийн шүүх; 2) Дээд шүүх; 3) Бүгд Найрамдах Каракалпакстан Улсын шүүх** (цаашид “Каракалпакстаны шүүх” гэх) (англ. *Court of the Republic of Karakalpakstan*); **4) мужийн шүүх** (англ. *regional courts*); Ташкент хотын шүүх (англ. *Court of the city Tashkent*) буюу **ерөнхий харьяаллын давж заалдах шатны шүүхүүд; 5) анхан шатны шүүхийн хувьд дүүрэг дундын, дүүргийн болон хот дахь иргэний хэргийн шүүхүүд; дүүрэг болон хот дахь эрүүгийн хэргийн шүүхүүд; дүүрэг дундын, дүүргийн болон хот дахь эдийн засгийн шүүхүүд орно; харин тусгай харьяаллын 6) цэргийн шүүх; 7) захиргааны**

²⁷⁵ Шариатын эрх зүйн нь муслим шашинтнуудын дагаж мөрддөг шашны зан үйлийн зарчмуудыг тодорхойлсон шашны хууль юм.

²⁷⁶ Juraev Saifiddin Akhmatovich*, Mukhitdinova Firyuza Абдурашидовна, “Uzbekistan: A New Dimension of Judicial Reforms,” *Journal of Advanced Zoology*, Volume 44 Issue S-5 Year 2023, p.1533.



хэргийн шүүхүүд тус тус шүүн таслах ажиллагааг явуулж байна.

Цэргийн шүүх нь улсын хэмжээний болон бүс нутгийн шүүх гэсэн 2 шатлалтай бол захиргааны хэргийн шүүхийн хувьд ерөнхий харьяаллын шүүхийн тогтолцоотой ижил буюу Каракалпакстаны, Ташкент хот дахь болон мужийн гэсэн **захиргааны хэргийн давж заалдах** шатны болон дүүрэг дундын **захиргааны хэргийн анхан шатны** шүүхүүдтэй.²⁷⁷

Схем 16. Узбекистан улсын шүүх тогтолцоо



Дээд шүүх (*Supreme Court of the Republic of Uzbekistan*)

Дээд шүүх нь эрүү, иргэн, эдийн засаг, захиргааны хэргийн дээд шатны давж заалдах шүүх бөгөөд өөрийн бүрэн эрхийн хүрээнд хэрэг, маргааныг анхан, давах, кассацийн шатны шүүхийн журмаар хянан шийдвэрлэдэг төдийгүй хүндэтгэн үзэхүйц шинэ нөхцөл байдлаас шалтгаалан хэргийг хүлээж авах нь бий. Дээд шүүх нь хууль санаачлах эрхтэй ба хуулийн төслийг парламентын доод танхим (англ. *Oliy Majlis*)-д өргөн мэдүүлэх боломжтойн²⁷⁸ дээр бүх доод шатны шүүхүүд, цэргийн шүүх болон Каракалпакстаны шүүхэд хяналт тавих эрх хэмжээтэй²⁷⁹ буюу босоо тогтолцоотой. Тухайлбал, шүүхийн практик, статистикт дүн шинжилгээ

²⁷⁷ Бүгд Найрамдах Узбекистан Улсын Шүүхийн тухайн хууль (2021).

²⁷⁸ Бүгд Найрамдах Узбекистан Улсын Шүүхийн тухайн хууль (2021)-ийн 6 дугаар зүйл.

²⁷⁹ Judiciaries Worldwide, "Uzbekistan," <https://judiciariesworldwide.fjc.gov/country-profile/uzbekistan>, (Сүүлд үзсэн: 2024.11.27).



хийх, шүүгч, шүүхийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авах үүргийг хүлээдэг.²⁸⁰ Бүтэц, удирдлагын хувьд тэргүүн, тэргүүний нэгдүгээр орлогч буюу захиргааны хэргийн коллегийн тэргүүн, мөн удаах орлогч болох иргэн, эрүү, эдийн засгийн хэргийн коллегийн дарга болон бусад шүүгчдээс бүрдэнэ.

Дээд шүүх нь үйл ажиллагааны бүтцийн хувьд Дээд шүүхийн нийт шүүгчдийн чуулган (англ. *Plenum of the Supreme Court of the Republic of Uzbekistan*), Дээд шүүхийн тэргүүлэгчдийн бүрэлдэхүүн (англ. *Presidium of the Supreme Court of the Republic of Uzbekistan*) болон захиргаа, иргэн, эрүү, эдийн засгийн коллегид хуваагдана. Мөн шүүхийн коллегиудад тусгай мэргэшсэн шүүхийн бүрэлдэхүүнийг байгуулах боломжтой байдаг.²⁸¹ Нийт шүүгчдийн чуулган зайлшгүй шаардлагатай үед хуралдаж, ингэхдээ дөрвөн сард нэгээс доошгүй удаа хуралдахаар хуульчилжээ.²⁸² Нийт шүүгчдийн чуулган эрх хэмжээнийхээ хүрээнд хууль хэрэглээтэй холбоотой тайлбар гаргах, хуулийн төсөл парламентын доод танхимд өргөн мэдүүлэх эрхтэй.²⁸³

Хүснэгт 1. Узбекистан улсын Дээд шүүхийн бүтэц

Узбекистан улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн чуулган Дээд шүүхийн нийт шүүгч, Каракалпакстаны ерөнхий харьяаллын болон захиргааны хэргийн шүүхийн тэргүүнүүдээс бүрдэх Узбекистан улсын Дээд шүүхийн тэргүүлэх бүрэлдэхүүн.			
Узбекистан улсын Дээд шүүхийн тэргүүлэгчдийн бүрэлдэхүүн Дээд шүүхийн шүүгчид дундаас Узбекистан улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн чуулганы тогтоосон тоогоор бүрдүүлдэг.			
Захиргааны хэргийн коллеги	Иргэний хэргийн коллеги	Эрүүгийн хэргийн коллеги	Эдийн засгийн хэргийн коллеги

Давж заалдах шатны шүүхүүд

2021 оны 01 сарын 12-ны өдөр батлагдсан хуулиудын дагуу хяналтын шатны шүүх (англ. *supervisory instance*)-ийг татан буулгаж Узбекистан улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг

²⁸⁰ Бүгд Найрамдах Узбекистан Улсын Шүүхийн тухайн хууль (2021)-ийн 18 дугаар зүйл.

²⁸¹ Мөн тэнд, 19 дүгээр зүйл.

²⁸² Мөн тэнд, 21 дүгээр зүйл.

²⁸³ Мөн тэнд, 22 дүгээр зүйл.



хянан шийдвэрлэх тухай хууль, Эдийн засгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд болон Захиргааны зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, шүүхийн шийдвэрийг хянан үзэх институтийг сайжруулах зохицуулалтуудыг тусгажээ. Улмаар тухайн оны 01 дүгээр сараас эхлэн эрүү, иргэн, эдийн засгийн мужийн түвшний шүүхүүдийг ерөнхий харьяаллын шүүх болгон нэгтгэн байгуулсан байдаг. Тухайлбал, “нэг шүүх – нэг шат” зарчмыг баримтлан, дүүрэг дундын болон дүүрэг (хот)-ийн шүүхийн шийдвэрийг мужийн түвшний шүүхэд давж заалдах журмаар хянаж, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг Дээд шүүх кассацын журмаар хянан шийдвэрлэхээр зохицуулсан.²⁸⁴

Өмнө дурдсанчлан засаг захиргааны бүтцээр 12 муж, нийслэл Ташкент хот болон Каракалпакстан улсуудад хуваагдан, тус бүр ерөнхий харьяаллын болон захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхтэй.²⁸⁵ Мөн ерөнхий харьяаллын давж заалдах шатны шүүхүүд нь Дээд шүүхийн жишгээр эрүү, иргэн болон эдийн засгийн хэргийн коллегуудад хуваагддаг байна.²⁸⁶

Хүснэгт 2. Каракалпакстан, мужийн болон Ташкент хот дахь шүүхүүд

Каракалпакстан, мужийн, Ташкент хот дахь шүүхүүдийн тэргүүлэгчдийн бүрэлдэхүүн		
Иргэний хэргийн коллеги	Эрүүгийн хэргийн коллеги	Эдийн засгийн хэргийн коллеги

Анхан шатны шүүхүүд

Анхан шатны шүүх нь харьяаллын хувьд дүүрэг дундын, дүүргийн, хот дахь гэж хуваагддаг бол захиргааны хэргийн анхан шатны шүүх нь зөвхөн дүүрэг хоорондын байна. Харин эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нь дүүргийн болон хотын харьяалалтай, энэ нь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тоо хамгийн их байгааг илтгэж байж болох юм. Мөн Бүгд Найрамдах Узбекистан Улсын Шүүхийн тухайн хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар иргэн, эрүү, эдийн засгийн шүүхүүд өөр өөрсдийн харьяалалд хамаарах хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхийн сацуу захиргааны

²⁸⁴ Farzona Khayrulla qizi Kayumova, “Judicial instances and types in the developing judicial system of Uzbekistan,” *Scientific Progress* Vol.3, 2022, p. 804.

²⁸⁵ “Courts and Cases Uzbekistan,” *lexadin.nl*, 2010, <https://www.lexadin.nl/wlg/courts/nofr/oeur/lxctuzb.htm>, (Сүүлд үзсэн: 2024.11.28).

²⁸⁶ Бүгд Найрамдах Узбекистан Улсын Шүүхийн тухайн хууль (2021)-ийн 32 дугаар зүйл.



зөрчлийн хэргийг давхар харьяалан шийдвэрлэхээр хуульчилсан нь онцлогтой.

Хүснэгт 3. Узбекистан улсын анхан шатны шүүхүүд

Дүүрэг дундын, дүүргийн болон хот дахь иргэний хэргийн шүүхүүд	Дүүргийн болон хот дахь эрүүгийн хэргийн шүүхүүд	Дүүрэг дундын, дүүргийн болон хот дахь эдийн засгийн хэргийн шүүхүүд	Дүүрэг дундын захиргааны хэргийн шүүхүүд
--	--	--	--

Нийтийн эрх зүйн харилцаанаас үүдэлтэй захиргааны маргаан, түүнчлэн захиргааны зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх хэрэгцээ шаардлагын дагуу 2017 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу захиргааны хэргийн шүүхүүдийг, Дээд шүүхэд захиргааны хэргийн коллегийг тус тус байгуулсан. Улмаар Ерөнхийлөгчийн 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн зарлигаар захиргааны хэргийн шүүхээс захиргааны зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хасаж, эрүүгийн шүүхийн харьяалалд шилжүүлсэн байна.



НОМ ЗҮЙ

I. Монгол эх сурвалж

1. Д.Баярсайхан, *Эрх зүйн онол*, 5 дахь хэвлэл, 2018 он.
2. Б.Амарсанаа, *Харьцуулсан эрх зүй судлал*, хоёр дахь хэвлэл, 2014 он.
3. Б.Чимид, *Бүгд найрамдах монгол ард улсын захиргааны эрх зүй (Ерөнхий анги)*, 1988 он.
4. Б.Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал*, 2017 он.
5. Б.Дөлгөөн, *Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны эрх зүй: онол, хэрэглээ, тулгамдсан асуудал*, 2023 он.
6. А.Бямбажаргал, “Улсын дээд шүүхийн чиг үүргийн талаарх харьцуулсан шинжилгээ,” *Нээлттэй нийгэм форум*, №29, 2020 он.
7. Парламентийн судалгааны хүрээлэн, *Парламент (судалгааны эмхэтгэл)*, 2021 он.
8. С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, 2011 он.

II. Гадаад эх сурвалж

A. Эрх зүйн эх сурвалж

1. Австрали улсын Үндсэн хууль (1901).
2. Австрали улсын Шүүхийн хууль (1903).
3. Австрали улсын Дээд шүүхийн хууль (1979).
4. Австрали улсын Холбооны шүүхийн хууль (1976).
5. Холбооны Үндсэн хууль (1920).
6. Дээд шүүхийн тухай хууль (1968).
7. Дээд шүүхийн үйл ажиллагааны журам (2019).
8. Дээд шүүхийн тухай хууль (1985).
9. ХБНГУ-ын Үндсэн хууль (1949).
10. ХБНГУ-ын Шүүхийн тунхаг хууль (1975).
11. Их Британи улсын дээд шүүхийн дүрэм (2009).
12. БНСУ-ын Үндсэн хууль (1988).
13. БНСУ-ын Шүүхийн бүтэц, зохион байгуулалтын тухай хууль



(2024).

14. Франц улсын Шүүхийн зохион байгуулалтын хууль (1978)
15. Франц улсын Захиргааны шүүхийн хууль (2000)
16. Шинэ Зеланд улсын Дээд шатны шүүхүүдийн тухай хууль (2016).
17. Шинэ Зеланд улсын Дээд шатны шүүхүүдийн Билл (2016).
18. Эстони улсын Үндсэн хууль (1992).
19. Эстони улсын Шүүхийн тухай хууль (2002).
20. Эстони улсын Иргэний процессын хууль (2006).
21. Эстони улсын Эрүүгийн процессын хууль (2004).
22. Эстони улсын Захиргааны процессын хууль, (2012).
23. Япон Улсын Үндсэн хууль (1946).
24. Япон Улсын шүүхийн тухай хууль (1947).
25. Япон Улсын дээд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх журам (1947).
26. Улсын дээд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам (1947).
27. Япон Улсын эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (1948).
28. Япон Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (1996).
29. Сингапур улсын Үндсэн хууль (1965).
30. Улсын дээд шүүхийн үйл ажиллагааны тухай хууль (1969).
31. Сингапур улсын Шүүхийн дүрэм (2021).
32. Шинэ Зеланд улсын цэргийн шүүхийн тухай хууль (2007).
33. Бүгд Найрамдах Узбекистан Улсын Шүүхийн тухайн хууль (2021).
34. Оросын Холбооны Улсын Үндсэн хууль (1993)
35. “Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай” Холбооны Үндсэн хууль (1994)
36. “Оросын Холбооны Улсын Дээд Шүүхийн тухай” Холбооны үндсэн хууль (2014)
37. “Оросын Холбооны Улсын шүүхийн тогтолцооны тухай” Холбооны Үндсэн хууль (1996)
38. “Оросын Холбооны Улсын ерөнхий харьяаллын шүүхүүдийн тухай” Холбооны Үндсэн хуулийн хууль (2011)
39. “Оросын Холбооны Улсын цэргийн шүүхүүдийн тухай” Холбооны Үндсэн хууль (1999)



40. Оросын Холбооны Улсын Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2002)
41. Оросын Холбооны Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2001)
42. Оросын Холбооны Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2002)
43. Оросын Холбооны Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2015)
44. Оросын Холбооны Улсын Дээд Шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2014.08.07-ны өдрийн №2 “Оросын Холбооны Улсын Дээд Шүүхийн дүрмийг батлах тухай” тогтоол
45. Arbeitsgerichtsgesetz, 1953.
46. Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, 1949.
47. Gerichtsverfassungsgesetz, 1950.
48. Finanzgerichtsordnung, 1965.
49. Strafprozeßordnung, 1950.
50. Strafgesetzbuch, 1871.
51. [Sozialgerichtsgesetz](#) , 1953.
52. Zivilprozessordnung, ZPO, 1950.
53. The Constitution of The Republic of Poland (1997).
54. Code of Civil Procedure (1964).
55. Code of Civil Procedure (1964).
56. Law on Common Courts Organisation (2001).
57. Law on the system of administrative courts (2002).
58. Act on the Supreme court (2017).
59. Rules of the Supreme Court (2022).
60. Constitution of the United States (1787).
61. United States Code (1948).
62. 《中华人民共和国刑法》(1979).
63. 《中华人民共和国宪法》(1982).
64. 《中华人民共和国民事诉讼法组织法》(1980).
65. 《中华人民共和国民事诉讼法》(1991).
66. 《中华人民共和国刑事诉讼法》(1979).
67. 《中华人民共和国行政诉讼法》(1989).



68. 《最高人民法院关于设立海事法几个院问题的决定》(1984).
69. 《最高人民法院关于巡回法庭审理案件若干问题的规定》(2015).
70. 《最高人民法院关于互联网法院审理案件若干问题的规定》(2018).

Б. Ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл

1. Mary Ann Glendon, *Comparative Legal Traditions: Text, Materials and Cases on Western Law*, 3rd ed, (American Casebook Series, 2007).
2. Sofia Stefanelli, *A Comparative Study Of The German And French Paths To Codification Of Private Law*, 2023.
3. Joseph Dainow, *The Civil Law and the Common Law: Some Points of Comparison*, 1967.
4. Mary ann Glendon, Paolo G.Carozza, Colin B.Picker, *Comparative legal traditions*, 3rd ed, 2007.
5. Jasper Kim, *American Law 101: An Easy Primer on the U.S. Legal System*, (American Bar Association Book Publishing, 2024) .
6. Mary Ann Glendon, Paolo G. Carozza and Colin B. Picker, *Comparative Legal Tradition*, 3rd ed. (Thomson West, 2007) .
7. Mikaia Mariel Lemonik Arthur, *Law and Justice Around the World: A Comparative Approach*, (University of California Press, 2020) .
8. Uwe Kischel, *Comparative Law*, (Oxford Press, 2019).
9. “Poland National report”, Global access to justice, 2024.
10. F.Pazderski, “An Overview of Polish Law”, GlobaLex, (April 2020) .
11. Congressional Research Service, *Federal and State Courts: Structure and Interaction*, (CRS ,2023).
12. Mirfozil Khasanov, “Legal Research in Uzbekistan,” *law.nyu.edu*, 2005.
13. GAFUROV Askar, “Constitutional Control in Uzbekistan: Current State and Development Perspective,” *Nagoya University Asian Law Bulletin* Vol.6, 2021.
14. Juraev Saifiddin Akhmatovich¹*, Mukhitdinova Firyuza Абдурашидовна, “Uzbekistan: A New Dimension of Judicial Reforms,” *Journal of Advanced Zoology*, Volume 44 Issue S-5 Year 2023.
15. Jurabek Nematov, “Transformation of Soviet Administrative Law:



- Uzbekistan's case study in judicial review over administrative acts," *Administrative Law and Process*, (1(28), 2020).
16. Farzona Khayrulla qizi Kayumova, "Judicial instances and types in the developing judicial system of Uzbekistan," *Scientific Progress Vol.3*, 2022.
 17. Jianli Song, "China's Judiciary: Current Issues", *Maine Law Review* 59, no. 1 (Jan 2007).
 18. Jiunn-Rong Yeh and Wen-Chen Chang, *Asian Courts in Context* (Cambridge University Press, 2014).
 19. 梁平, 刘宇晖. 中国司法制度概论 [M], 中国法制出版社, 2023.
 20. 谭世贵, 中国司法制度 (第四版) [M], 法律出版社, 2016.

В. Бусад

1. "Internal organization of the ordinary courts competent to review administrative acts," Association of the Councils of State and Supreme Administrative.
2. "The Supreme Court of Justice," The Supreme Court of Justice of the Republic of Austria.
3. "Canadian Judicial System," Supreme court of Canada.
4. "Message from the Chief Justice, Richard Wagner," Supreme court of Canada.
5. "Role of the Court," Supreme court of Canada.
6. "The judicial structure," Department of Justice Canada.
7. Cour de cassation, The cour de cassation's international newsletter, 2024
8. The President of the Federal Court of Justice, *The Federal Court of Justice - Broschuere*, (2021).
9. Volker Krey, Manfred Heinrich: Deutsches Strafverfahren, 2019.
10. Norbert Schwab, Stephan Weth: Arbeitsgerichtsgesetz Kommentar, 2011.
11. Global Access to Justice Project, New Zealand national report," <https://globalaccesstojustice.com/global-overview-new-zealand/?lang=de>
12. Courts of New Zealand "Structure of the court system" 2024, <https://www.courtsofnz.govt.nz/about-the-judiciary/structure-of-the-court-system/>



13. Courts of New Zealand, “New Zealand Chief-Justices-Annual-Report, 2023, <https://www.courtsofnz.govt.nz/assets/7-Publications/2-Reports/20240827-Chief-Justices-Annual-Report-2023.pdf>
14. Courts of New Zealand, “New Zealand Supreme Court workload statistic”, <https://www.courtsofnz.govt.nz/the-courts/supreme-court/annual-statistics/>
15. University of Ottawa, Civil law Systems and Mixed Systems with a Civil law Tradition” <https://www.juriglobe.ca/eng/sys-juri/class-poli/droit-civil.php>
16. Estonian court system, <https://www.riigikohus.ee/en/estonian-court-system#:~:text=Estonia's%20court%20system%20consists%20of,is%20prohibited%20by%20the%20Constitution>
17. Supreme Court of Estonia Brochure,2019, <https://www.riigikohus.ee/sites/default/files/Tr%C3%BCKis/2019-Riigikohus-brozuur-2019-ENG.pdf>
18. “About the Singapore Courts”, Singaporean courts, <https://www.judiciary.gov.sg/who-we-are/about-singapore-courts>
19. “Role and structure of Supreme court” Singaporean courts”, Singaporean courts, <https://www.judiciary.gov.sg/who-we-are/role-structure-supreme-court>
20. “The Coming of Age of Constitutional Judicial Review in Singapore: The Advent of Proportionality”, IACL blog, <https://blog-iacl-aidc.org/constitutional-landmark-judgments-in-asia>
21. “Judges and judicial officers in the Supreme Court” Singaporean courts, <https://www.judiciary.gov.sg/who-we-are/role-structure-supreme>
22. “Corner’s Court”, National archives of Singapore https://www.nas.gov.sg/archivesonline/government_records/agency-details/120
 - “History of the courts” Singapore Courts, <https://www.judiciary.gov.sg/who-we-are/history-courts#family-justice-courts>
23. “Role and structure of the Family Justice Courts” Singaporean courts, <https://www.judiciary.gov.sg/who-we-are/role-structure-family-justice-courts/role>
24. “Estonian court” State portal, <https://www.eesti.ee/eraisik/en/artikkel/republic-of-estonia/court>
25. “About the Youth Court” District court of New Zealand, https://www.districtcourts.govt.nz/youth-court/about-the-youth-court/#What_YC_does



26. “Environment court” Environment court of New Zeland, <https://www.environmentcourt.govt.nz/>
27. “About Employment court” Employment court of New Zeland, <https://www.employmentcourt.govt.nz/about/>
28. “The Maory land court” Community law, <https://communitylaw.org.nz/community-law-manual/chapter-2-maori-land/the-maori-land-court/>
29. “Annual report on the military justice system”, Defence legal service, https://www.nzdf.mil.nz/assets/Uploads/DocumentLibrary/Discipline-Report_2021-2022.pdf
30. 五十嵐清『社会主義法系は存在したか？ -John Quigley, Socialist Law and the Civil Law Tradition, 37 Am.J.Comp.L.781(1989)の紹介を中心に-』、札幌法学3巻1号（1991）
31. 最高裁判所『裁判所法逐条解説中巻』（東京法曹会 1968年）
32. 市川正人ほか『現代の裁判（第8版）』（有斐閣 2022年）
33. 임현, “법의 지배와 좋은 정부” 정부학연구 제18권 제2호 (2012)

III. Цахим эх сурвалж

1. Австрали улсын Үндэсний их сургуулийн цахим хуудас: <https://www.anu.edu.au/>.
2. Австрали улсын Засгийн газрын цахим хуудас: <https://www.dfat.gov.au/>.
3. Австрали улсын дээд шүүхийн цахим хуудас: <https://www.hcourt.gov.au/>.
4. Баруун Австралийн дээд шүүхийн цахим хуудас: <https://www.supremecourt.wa.gov.au/default.aspx>.
5. Холбооны хууль эрх зүйн мэдээллийн систем: <https://www.ris.bka.gv.at/>.
6. Бүгд Найрамдах Австри Улсын Дээд шүүхийн цахим хуудас: <https://www.ogh.gv.at/>.
7. Австри Улсын шүүхийн цахим хуудас: <https://www.justiz.gv.at/>.
8. Канад Улсын Дээд шүүхийн цахим хуудас: <https://www.scc-csc.ca/>.
9. Канад Улсын Хууль зүйн яамны цахим хуудас: <https://www.justice.gc.ca/>.
10. Их Британи улсын шүүхийн цахим хуудас: <https://www.judiciary.uk/>.
11. Их Британи улсын дээд шүүхийн цахим хуудас: <https://www.supremecourt.uk/>
12. БНСУ-ын дээд шүүхийн цахим хуудас: <https://www.scourt.go.kr/>



- scourt/
13. БНСУ-ын мэдээний сайт: <http://chunchu.yonsei.ac.kr/>
 14. Франц улсын Хяналтын шүүхийн албан ёсны цахим хуудас - <https://www.courdecassation.fr/en>
 15. Франц улсын Захиргааны дээд шүүхийн албан ёсны цахим хуудас - <https://www.conseil-etat.fr/>
 16. Дэлхийн шударга ёсны төслийн албан ёсны цахим хуудас – <https://globalaccesstojustice.com/>
 17. Оттавагийн их сургуулийн албан ёсны цахим хуудас – <https://www.juriglobe.ca/eng/sys-juri/class-poli/droit-civil.php>
 18. Шинэ Зеланд Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын албан ёсны цахим хуудас – <https://www.dpmc.govt.nz/>
 19. Шинэ Зеланд улсын шүүхийн албан ёсны цахим хуудас – <https://www.courtsofnz.govt.nz/>
 20. Шинэ Зеланд улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем – <https://www.legislation.govt.nz/>
 21. Эстони улсын Дээд шүүхийн албан ёсны цахим хуудас – <https://www.riigikohus.ee/en/>
 22. Эстони улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем – <https://www.riigiteataja.ee/en/>
 23. Япон Улсын эрх зүйн хэм хэмжээний актын орчуулгын цахим систем <https://www.japaneselawtranslation.go.jp/en/dicts/>
 24. Япон Улсын дээд шүүхийн цахим хуудас <https://www.courts.go.jp/saikosai/index.html>
 25. Япон Улсын дээд шүүхийн шүүгчдэд санал өгөх тухай цахим хуудас <https://www3.nhk.or.jp/news/special/kokuminshinsa/index.html>
 26. Судалгааны цахим платформ: <https://heinonline.org/>
 27. Энэтхэг улсын Нээлттэй боловсролын үндэсний хүрээлэн: <https://nios.ac.in/>
 28. <https://blog.naver.com/chatwithsd/223568908236>
 29. Lawyer Birdie” 2023,
 30. <https://www.lawyerbirdie.com/post/%D1%8D%D1%80%D1%85-%D0%B7%D2%AF%D0%B9%D0%BD-%D0%B1%D2%AF%D0%BB%D2%AF%D2%AF%D0%B4>
 31. Georgetown Law, German legal research guide, 2024, <https://guides.ll.georgetown.edu/germanlegalresearch#:~:text=Germany%20is%20a%20federal%20constitutional,floor%20of%20the%20Williams%20Library>
 32. Бүгд Найрамдах Польш улсын Сеймийн цахим хуудас: <https://isap.sejm.gov.pl/>.



33. Хууль эрх зүйн тойм, хууль тогтоомжийн мэдээллийн сан: <https://legislationline.org/>
34. Хууль тогтоомжийн цахим мэдээллийн сан: <https://sip.lex.pl/>
35. Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан: <https://globalaccessstojustice.com/>.
36. Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан: <https://www.nyulawglobal.org/globalex>.
37. АНУ-ын дээд шүүхийн цахим хуудас: <https://www.supremecourt.gov/>.
38. АНУ-ын холбооны шүүхийн цахим хуудас: <https://www.uscourts.gov/>.
39. АНУ-ын хуульчдын холбооны цахим хуудас: <https://www.americanbar.org/>.
40. АНУ-ын хууль зүйн яамны цахим хуудас: <https://www.justice.gov/>.
41. Дуглас Ж.Жаксон хуулийн фирмийн цахим хуудас: <https://www.getyourlegalaction.com/>.
42. Мелборн их сургуулийн номын сангийн цахим хуудас: https://library.unimelb.edu.au/library_guides.
43. Корнелл хууль зүйн сургуулийн хууль зүйн мэдээллийн төвийн цахим хуудас: <https://www.law.cornell.edu/>.
44. Сингапур улсын шүүхүүдийн албан ёсны цахим хуудас – <https://judiciary.gov.sg/>
45. Сингапур улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем – <https://sso.agc.gov.sg/>
46. Judiciaries Worldwide, “Uzbekistan,” <https://judiciariesworldwide.fjc.gov/country-profile/uzbekistan>
47. “Courts and Cases Uzbekistan,” *lexadin.nl*, 2010, <https://www.lexadin.nl/wlg/courts/nofr/oeur/lxctuzb.htm>.
48. Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын цахим хуудас: <http://www.npc.gov.cn/npc/index.html>.
49. БНХАУ-ын эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://flk.npc.gov.cn/index.html>
50. Цахим номын сан: <https://weread.qq.com>.
51. Холбооны төрийн мэдээллийн систем «Төрийн болон орон нутгийн үйлчилгээний нэгдсэн порталын» (портал Төрийн үйлчилгээ) албан ёсны цахим хуудас - https://www.gosuslugi.ru/help/faq/apply_court/1026811